



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

ХУУЛЬ, ТОГТООМЖИЙН ТӨСӨЛ СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭНД ҮНДЭСЛЭСЭН БАЙХ ЗАРЧМЫН ХЭРЭГЖИЛТ

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

2025 он

ННА 67
ДАА 340
М-242

ХУУЛЬ, ТОГТООМЖИЙН ТӨСӨЛ СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭНД ҮНДЭСЛЭСЭН БАЙХ ЗАРЧМЫН ХЭРЭГЖИЛТ

“Тогтолцоо дүн шинжилгээ судалгааны хүрээлэн” НҮТББ

Хуульч М.Маралмаа
Хуульч Б.Мягмарсүрэн
Хуульч Р.Оюундэлгэр

Зөвлөх: Д.Эрдэнэчимэг, ННФ-ын Засаглалын хөтөлбөрийн менежер

© Нээлттэй Нийгэм Форум, 2025

Хаяг: Жамьян гүний гудамж, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар 14240
Утас: 76113207
Веб: <http://www.forum.mn>
И-мэйл: osf@forum.mn

Энэхүү тайлангийн дүгнэлт, зөвлөмж нь зөвхөн судлаачийн үзэл бодол, байр суурь бөгөөд Нээлттэй Нийгэм Форумын албан ёсны байр суурийг төлөөлөхгүй.

ISBN 978-9919-529-05-5

ГАРЧИГ

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	4
ГРАФИКИЙН ЖАГСААЛТ	4
ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ	5
ТОВЧИЛСОН ҮГ	6
ӨМНӨХ ҮГ	7
УДИРТГАЛ	9
НЭГ. ХУУЛИЙН ТӨСЛИЙГ СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭНД ҮНДЭСЛЭН БОЛОВСРУУЛАХ ЗАРЧМЫН ТУХАЙ ОЙЛГОЛТ	13
ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙГ СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭНД ҮНДЭСЛЭН БОЛОВСРУУЛАХ ЗАРЧМЫН ХЭРЭГЖИЛТ	18
2.1. Хуулийн төсөлд суурь судалгаа хийсэн байдал	19
2.2. Хуулийн төсөлд зардлын тооцоо хийсэн байдал	49
2.3. Хуулийн төсөлд үр нөлөөний үнэлгээ хийсэн байдал	64
ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛИЙН СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭНД ТАВИХ ХЯНАЛТ	80
ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	86
ЭХ СУРВАЛЖ	91

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.	Хуулийн төслийн зохицуулалтын үр нөлөөг үнэлэх шалгуур	14
Хүснэгт 2.	Хуулийн төслийн төрөл, түүнд хамаарах судалгаа, хийгдэх үе шат ...	16
Хүснэгт 3.	Суурь судалгаа гүйцэтгэсэн байдал, хуулийн төслийн төрлөөр	21
Хүснэгт 4.	Аргачлалд заасан дарааллыг баримтлаагүй боловч агуулгын хувьд аргачлалд заасан асуудлыг бүрэн хамарсан тайлангийн жишээ	26
Хүснэгт 5.	Зохицуулалтын хувилбаруудыг харьцуулан дүгнэж буй байдал, нийтлэг хариултууд	32
Хүснэгт 6.	Техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын тандан судалгаанд асуудлыг шийдвэрлэх хувилбаруудыг харьцуулан дүгнэсэн байдал	35
Хүснэгт 7.	Тандан судалгаанд зардлыг тооцсон байдал	36
Хүснэгт 8.	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбарыг шууд сонгосон үндэслэл	37
Хүснэгт 9.	Зардлын тооцоо хийх аргачлал.....	51
Хүснэгт 10.	Зардал тооцоогүй шалтгаан ба тооцвол зохих зардал.....	55
Хүснэгт 11.	Аргачлалд заасан зардлын төрөл	56
Хүснэгт 12.	Зардлын тооцооны аргачлалд нэмж тусгавал зохих зардлууд	57
Хүснэгт 13.	Зардал, үр өгөөжийн харьцааг тодорхойлсон байдал	59
Хүснэгт 14.	Зардал бууруулах саналыг тусгасан хуулиуд.....	61
Хүснэгт 15.	Зардал бууруулах саналыг тусгаагүй тохиолдол (нийтлэг дутагдал) ..	61
Хүснэгт 16.	Үр нөлөөний үнэлгээний шалгуур үзүүлэлт.....	65
Хүснэгт 17.	Үр нөлөөний үнэлгээний IV үе шатанд үр дүнг баримтжуулсан байдал.....	70
Хүснэгт 18.	Үр нөлөөний үнэлгээний үр дүнг баримтжуулсан байдал, эшлэл, эх сурвалжийн тоогоор	71
Хүснэгт 19.	Хуулийн төслийн үр дүнг ерөнхийлөн үнэлсэн жишээ	71
Хүснэгт 20.	Судалгаа нь хуулийн төсөл батлагдахаас гурав ба түүнээс олон жилийн өмнө хийгдсэн хуулиуд.....	84

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График 1.	Хуулийн төсөл боловсруулах, батлах үйл явцын ерөнхий зураглал: Судалгаа, шинжилгээ	16
График 2.	Судалгаанд хамруулсан нийт 98 хуулийн төсөлд судалгаа хийсэн байдал	18

График 3.	Суурь судалгаа гүйцэтгэсэн байдал	20
График 4.	Хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах ажлын үе шат	23
График 5.	Тандан судалгааны үе шатыг баримталсан байдал.....	24
График 6.	Тандан судалгааны аргачлалд заасан зохицуулалтын хувилбарууд...	30
График 7.	Харьцуулалт хийхээр сонгон авсан зохицуулалтын хувилбарын тоо (III үе шат)	31
График 8.	Зардлын тооцоо хийсэн байдал.....	52
График 9.	Зардлын тооцооны аргачлалд заасан элементүүдийг бүрэн хамарсан эсэх.....	52
График 10.	Зардлыг хувь хүн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үүсэх зардал тус бүрээр тооцсон эсэх	53
График 11.	Зардал, үр өгөөжийн харьцааг тодорхойлсон эсэх.....	53
График 12.	Зардал бууруулах санал, түүнийг хуульд тусгасан байдал	54
График 13.	Үр нөлөөний үнэлгээ хийсэн байдал	64
График 14.	Үр нөлөөний үнэлгээний үе шат	65
График 15.	Үр нөлөөний үнэлгээний шалгуур үзүүлэлтийг сонгосон байдал	66
График 16.	Үр нөлөөний үнэлгээний аль нэг шалгуур үзүүлэлтийг сонгоогүй тохиолдолд үндэслэлээ тайлбарласан байдал	67
График 17.	Хуулийн төслөөс үр нөлөөг тооцох хэсгээ тогтоосон байдал, үнэлгээний шалгуур үзүүлэлт тус бүрээр	69
График 18.	Үр дүнг үнэлж, зөвлөмж өгөх үе шат	70
График 19.	Үр нөлөөний үнэлгээний дүнд зөвлөмж өгсөн байдал	72
График 20.	Тайланд судалгаа гүйцэтгэсэн этгээдийг дурдсан байдал	81
График 21.	Судалгаа гүйцэтгэсэн этгээд	82
График 22.	Тайланд судалгаа гүйцэтгэсэн хугацааг дурдсан байдал.....	83

ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ

Хавсралт 1.	Судалгаанд хамрагдсан хуулиуд.....	93
Хавсралт 2.	ХТХ-д заасны дагуу судалгаа, шинжилгээ хийх шаардлагагүй хуулийн төсөл.....	97
Хавсралт 3.	Хуульд заасан зарим судалгааг хийгээгүй хуулийн төслийн жагсаалт, энэ талаарх УИХТГ-ын тайлбар	98
Хавсралт 4.	Хэрэгцээ, шаардлагын тандан судалгааны хүрээнд асуудлыг тодорхойлсон байдал	103
Хавсралт 5.	Хэрэгцээ, шаардлагын тандан судалгааны хүрээнд асуудал шийдвэрлэх зорилгыг тодорхойлсон байдал	104

Хавсралт 6.	Хэрэгцээ, шаардлагын тандан судалгааны хүрээнд харьцуулсан судалгаа гүйцэтгээгүй хуулиудын төсөл	
Хавсралт 7.	Хэрэгцээ, шаардлагын тандан судалгааны зөвлөмжийг хуульд тусгасан байдал.....	106
Хавсралт 8.	Үр нөлөөний үнэлгээний хүрээнд зарим шалгуур үзүүлэлтийг сонгоогүй шалтгааныг тайлбарласан байдал	108
Хавсралт 9.	Үр нөлөөний үнэлгээний үр дүнг баримтжуулах хүрээнд хамгийн олон эшлэл зүүлт авсан болон эх сурвалжийн жагсаалт хавсаргасан хуулийн төслийн жагсаалт.....	112
Хавсралт 10.	Үр нөлөөний үнэлгээний шалгуур үзүүлэлттэй шууд хамааралгүй асуудлаар зөвлөмж өгсөн жишээ	113
Хавсралт 11.	Үр нөлөөний үнэлгээний хүрээнд дагалдах хуультай холбоотой зөвлөмж өгсөн жишээ	115
Хавсралт 12.	Үр нөлөөний үнэлгээний хүрээнд тус хуулийн зохицуулалтыг бусад хуульд нийцүүлсэн талаар зөвлөмж өгсөн жишээ.....	117
Хавсралт 13.	Үр нөлөөний үнэлгээний хүрээнд олон нийтийн хэлэлцүүлэгтэй холбоотой асуудлаар дүгнэлт, зөвлөмж өгсөн жишээ.....	120

ТОВЧИЛСОН ҮГ

ЗГ	Засгийн газар
УИХ	Улсын Их Хурал
УИХТГ	Улсын Их Хурлын Тамгын газар
УДШ	Улсын Дээд Шүүх
ҮХЦ	Үндсэн Хуулийн Цэц
ХТтХ	Хууль тогтоомжийн тухай хууль
ЭЗХАХБ	Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа ба Хөгжлийн Байгууллага

ӨМНӨХ ҮГ

Нээлттэй нийгэм форум нь Хууль тогтоомжийн тухай хууль, түүний хэрэгжилт, үр нөлөөг сайжруулах зорилгоор цуврал бодлогын судалгаа эрхлэн хийж ирлээ. Энэ хүрээнд хийгдсэн яаралтай горим, дагалдах хууль, олон нийтийн хэлэлцүүлэг, хүний эрхийн нөлөөллийн үнэлгээ зэрэг хууль боловсруулах үйл явцад тулгамдаж буй асуудлаарх судалгаа болон тэдгээрт тулгуурласан бодлогын хэлэлцүүлгүүд нь Хууль тогтоомжийн тухай хуулийн шинэчлэлд тодорхой хувь нэмэр оруулж буйд итгэлтэй байна.

Энэ удаа бид “Хууль тогтоомжийн төслийг судалгаа, шинжилгээнд үндэслэн боловсруулах зарчмын хэрэгжилт” сэдэвт судалгааны үр дүнг Та бүхэнд танилцуулж байна.

Төрийн аливаа шийдвэр, бодлого, хууль тогтоомжийг боловсруулан батлахдаа тухайн асуудлын нөхцөл байдлыг нарийвчлан судалж, хамгийн оновчтой шийдлийг тодорхойлсны үндсэн дээр хуульчлах ёстой. Иймээс 2015 онд Хууль тогтоомжийн тухай хуулийг батлахдаа “судалгаа, шинжилгээнд үндэслэх” зарчмыг хууль тогтоомжийн төсөл боловсруулахад баримтлах үндсэн зарчим болгон хуульчилсан билээ.

Үүний дагуу аливаа хуулийн төслийг боловсруулахад түүний хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах, үр нөлөөг нь үнэлэх, хэрэгжилтэд шаардагдах зардлыг тооцох, мөн батлагдсаны дараа хэрэгжилт ба нийгэмд үзүүлэх үр дагаврыг тогтмол үнэлэх шаардлагыг мөн хуулиар тогтоожээ. Үүнтэй уялдуулан Засгийн газраас 2016 онд холбогдох судалгааны аргачлалуудыг батлан гаргасан билээ.

Гэвч хууль тогтоомжийг судалгаа, шинжилгээнд үндэслэн боловсруулах зарчмын хэрэгжилт хангалтгүй байсаар байна. Зарим тохиолдолд судалгаа хийгээгүй, эсхүл судалгаа хийхдээ аргачлал, шаардлагыг бүрэн мөрдөөгүйгээс хууль тогтоомжийн хийдэл, зөрчил, хэрэгжилтийн хүндрэлүүд үүсэх болов.

Иймд хууль тогтоомжийн төсөл боловсруулах үе шатны судалгаа, шинжилгээ ямар түвшинд хийгдэж байгааг үнэлж, цаашид сайжруулах чиглэлийг тодорхойлох зорилгоор энэхүү судалгааг хийв.

Судалгаанд УИХ-ын 2020–2024 оны бүрэн эрхийн хугацаанд батлагдсан 98 хуулийн төслийг сонгон авч, дараах чиглэлээр үнэлгээ хийсэн болно:

- Хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагын тандан судалгаа;
- Хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ;
- Хууль хэрэгжүүлэхэд гарах зардлын тооцооны чанар ба холбогдох аргачлалын хэрэгжилт.

Судалгааны үр дүнд тулгуурлан боловсруулсан санал, зөвлөмж нь хууль тогтоомжийн судалгааны аргачлалыг боловсронгуй болгох одоогийн үйл явцад бодит хувь нэмэр оруулна гэдэгт итгэлтэй байна.

Судалгааг амжилттай хийж гүйцэтгэсэн судлаач М.Маралмаа, Б.Мягмарсүрэн, Р.Оюундэлгэр болон тайланг сайжруулахад үнэтэй санал, зөвлөгөө өгч ажилласан Нээлттэй нийгэм форумын Засаглалын хөтөлбөрийн менежер Д.Эрдэнэчимэг нарт гүн талархал илэрхийлье.

Нээлттэй нийгэм форумын Гүйцэтгэх захирал П.Эрдэнэжаргал

УДИРТГАЛ

Хууль, тогтоомжийн төслийг судалгаа, шинжилгээнд үндэслэн боловсруулах нь хууль бүтээх үйл ажиллагааны үндсэн зарчим билээ.¹ Уг зарчмыг хэрэгжүүлэх хүрээнд 2016 оны 01 сарын 16-ны өдөр Монгол Улсын Засгийн газрын 59 дүгээр тогтоолоор хууль тогтоомжийн судалгаа, шинжилгээ хийх 6 аргачлал (**багц аргачлал**)-ыг батлан гаргажээ. Энэхүү багц аргачлал мөрдөгдөж эхлээд бараг 10 жилийн хугацаа өнгөрсөн байна.

Энэ хугацаанд Монгол Улсад эрх зүйн шинэчлэл эрчимтэй өрнөсөн ба ялангуяа сүүлийн жилүүдэд Улсын Их Хурлаар хэлэлцэх хууль тогтоомжийн тоо огцом нэмэгджээ. Тодруулбал, Улсын Их Хурал 2008-2012² оны бүрэн эрхийн хугацаандаа 219, 2012-2016 онд 168, 2016-2020 онд 194 хууль тус тус хэлэлцэж байсан бол 2020-2024 онд нийт 1838 хууль баталжээ.

Ийнхүү 2020 оноос хойш Улсын Их Хурлаар хэлэлцэх хууль, тогтоомжийн тоо огцом нэмэгдсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн 2019 оны нэмэлт өөрчлөлтийн хүрээнд гучин нэг³, Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд хорин долоо⁴, Монгол Улсын Үндсэн хуулийн 2023 оны өөрчлөлтийн хүрээнд долоо⁵, Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлд 153 хуулийн төслийг⁶ тус тус батлахаар төлөвлөсөнтэй холбоотой.

¹ Хууль тогтоомжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5-д зааснаар судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх нь хууль тогтоомжийн тухай хуулийг хэрэгжүүлэхэд баримтлах нийтлэг зарчим мөн.

² Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем legalinfo.mn-д 2008 оноос өмнөх үеийн парламентын ээлжит чуулганы хуралдаанаар хэлэлцэх асуудлын тов дарааллыг бүрэн байршуулаагүй тул 2008 оноос хойш байршсан мэдээллийг ашиглав.

³ "Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай" МУИХ-ын 2020 оны 02 дугаар тогтоол.

⁴ "Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай" МУИХ-ын 2021 оны 106 дугаар тогтоол.

⁵ "Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлттэй холбогдуулан авах арга хэмжээний тухай" МУИХ-ын 2023 оны 44 дугаар тогтоол.

⁶ "Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай" МУИХ-ын 2021 оны 12 дугаар тогтоол.

Эрх зүйн орчны энэ эрчимтэй өөрчлөлт 2024-2028 онд ч хэвээр үргэлжлэх төлөвтэй. Учир нь Улсын Их Хурлын ес дэх удаагийн ээлжит сонгуулиар бүрдсэн парламентын 2024-2028 оны стратеги төлөвлөгөөнд⁷ хууль тогтоомжийн төслийг боловсруулахдаа судалгаа, шинжилгээнд үндэслэх, хүн төвт үзэл санаанд суурилсан арга барил, хууль зүйн техникийг нэвтрүүлэх зорилго дэвшүүлж, хууль, эрх зүйн орчны шинэчлэл хийхээр Улсын Их Хурлын даргын захирамжаар 2024 онд 54 ажлын хэсэг байгуулсан билээ.⁸ Тэрчлэн Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлд нийт 147 хуулийн төслийг Засгийн газраас санаачлан өргөн мэдүүлэхээр төлөвлөжээ.⁹

Харин энэхүү эрчимтэй өөрчлөлт, шинэчлэл нь үндэслэл бүхий бөгөөд үр нөлөөтэй байж чадаж байна уу гэдэг асуудал зүй ёсоор тавигдана. Үүнд хууль бүтээх явцад хийгдэж буй судалгаа, шинжилгээний чанар, үнэн зөв байдал нэн чухал.

Иймд хууль тогтоомжийн төсөл боловсруулахад баримтлах “судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх” зарчмын хэрэгжилтийг үнэлж, судалгааны чанар, хууль тогтоомжийн үр нөлөөг сайжруулахад чиглэсэн санал, зөвлөмж боловсруулах зорилгоор энэхүү судалгааг гүйцэтгэлээ.

Энэхүү судалгааны хүрээнд дээрх 2020-2024 онд батлагдсан 1838 хуулиас Хууль тогтоомжийн тухай хуульд холбогдох судалгаа хийх шаардлагагүй гэж заасан хуулиуд¹⁰ болон нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудын дийлэнх хэсэг, дагалдах хууль зэргийг хасаж, бие даасан 98 хуулийг сонгон авсан болно. Дэлгэрэнгүй жагсаалтыг Хавсралт 1-ээс үзнэ үү.

Ийнхүү сонгон авсан 98 хуулийн төслийн бүрдэлд хавсаргасан судалгааны тайланд дүн шинжилгээ хийсэн бөгөөд үлдсэн 1740 хуулийг дараах үндэслэлээр судалгаанд хамруулаагүй болно. Үүнд:

- Анхдагч хууль боловч дагалдах хуулийн хэлбэрээр өргөн мэдүүлж батлагдсан 4 хуулийг энэ судалгаанд хамруулаагүй.
- Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль: 2020-2024 онд батлагдсан 1838 хуулийн 85 орчим хувь буюу 1570 нь нэмэлт, өөрчлөлт оруулах

⁷ "Монгол Улсын Их Хурлын 2024-2028 оны Стратеги төлөвлөгөө батлах тухай" МУИХ-ын 2024 оны 42 дугаар тогтоол.

⁸ УИХ, "УИХ-ын даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсгүүдийн мэдээлэл", 2024.09.09, <https://www.parliament.mn/np/62915/> [Сүүлд үзсэн: 2024.11.15]

⁹ "Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай" МУИХ-ын 2024 оны 181 дүгээр тогтоол.

¹⁰ Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт Хууль тогтоомжийн тухай хуульд заасан судалгаа шинжилгээ шаардахгүй 24 асуудлыг заасан.

тухай хууль байв. Эдгээрээс бие даасан 27 хуулийг түүвэрлэн авсан бөгөөд үлдэх 1543-ыг судалгаанд хамруулаагүй болно.

- Хууль хүчингүй болсонд тооцох тухай хууль: 2020-2024 онд хууль, хуулийн зүйл, хэсэг, заалтыг хүчингүй болсонд тооцох тухай нийт 72 хууль батлагдсан байх бөгөөд энэ төрлийн хууль нь ихэнхдээ дагалдах хууль байдлаар батлагддаг тул энэхүү судалгаанд хамруулах шаардлагагүй гэж үзэв.
- Дагаж мөрдөх журмын тухай хууль: Энэ төрлийн хууль 35 байсан бөгөөд уг хууль нь зөвхөн аль нэг хууль, эсвэл тодорхой заалтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн бэлтгэл, зохион байгуулалтын шинжтэй зохицуулалт агуулдаг тул судалгаанд хамруулаагүй.
- Гаалийн албан татвараас хөнгөлөх тухай, Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай 11 хууль байсан боловч холбогдох тооцоо судалгаа нь олдоогүй тул судалгаанд хамруулаагүй.
- ХТХ-д заасны дагуу судалгаа хийх шаардлагагүй 75 хуулийг мөн судалгаанд хамруулаагүй. Тодруулбал, тус хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт “12.1.2-12.1.6-д заасан аргачлал нь дараах хууль тогтоомжийн төсөл боловсруулахад хамаарахгүй” гээд нийт 19 төрлийн хууль тогтоомжийг нэрлэн заасан. Мөн зүйлийн 12.3-д “Энэ хуулийн 12.1.2-т заасан хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал дараах хууль тогтоомжийн төсөл боловсруулахад хамаарахгүй” гээд 3 төрлийн хууль тогтоомжийг дурдсан байдаг. Энэ үндэслэлээр судалгаанд хамруулах шаардлагагүй гэж үзсэн хуулийн төслүүдийг Хавсралт 2-оос үзнэ үү.

Сонгон авсан 98 хуультай холбоотой судалгааны тайланг УИХ-ын www.forum.parliament.mn болон УИХТГ-ын эрхлэн хөтөлдөг www.dparliament.mn цахим хуудаст байршуулсан хуулийн төслийн цахим хувийн хэргээс авав. Судалгааны тайлан цахим хуудаст байхгүй тохиолдлуудыг судалгаа хийгээгүй гэсэн утгаар авч үзсэн болно. Учир нь судалгаа хийсэн боловч тайланг цахимд байршуулаагүй эсхүл судалгаа огт хийгээгүй эсэхийг тодорхойлох боломжгүй байв.¹¹ Тэрчлэн өөр нэр, агуулга бүхий файлыг судалгааны тайлан хэмээн байршуулсан тохиолдол ч байв. Судалгааны тайлан

¹¹ Тухайлбал, 2023 оны 01 сарын 20-ны өдөр батлагдсан Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны тухай хуулийн төслийг нээлттэй байршуулсан санал авах хэсэгт хуулийн төсөл, дагалдах хуулийн төслүүд, төслийн үзэл баримтлал, төслийн танилцуулгыг оруулсан байх хэдий ч хуулийн төслийн холбогдох судалгаануудыг байршуулаагүй байна. <https://lawforum.parliament.mn/project/295/>, [Сүүлд үзсэн: 2025.04.10]

байршуулаагүй тохиолдлуудыг УИХТГ-тай холбогдон тодруулахад, хуулийн төслийн бүрдүүлбэр хянасан хэсэгт “судалгаа хийх шаардлагагүй” гэсэн тэмдэглэгээ хийсэн тохиолдлууд цөөнгүй гарсныг мөн дурдах нь зүйтэй. (Дэлгэрэнгүйг Хавсралт 3-аас үзнэ үү.)

НЭГ. ХУУЛИЙН ТӨСЛИЙГ СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭНД ҮНДЭСЛЭН БОЛОВСРУУЛАХ ЗАРЧМЫН ТУХАЙ ОЙЛГОЛТ

Хууль тогтоомж боловсруулан батлах шаардлага нь олон хүчин зүйлээс шалтгаална. Тухайлбал, эрх барьж буй улс төрийн хүчний бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөө, нийгэмд өрнөж буй үйл явдал, хэлэлцүүлэг, мэтгэлцээн, холбогдох талуудын санал шүүмж зэрэг нь шинэ хууль батлан гаргах, хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжид өөрчлөлт оруулахад хүргэнэ.¹²

Гэвч аливаа улсын эрх зүйн систем, онцлогоос үл хамааран хууль тогтоох ажиллагааны үндсэн зорилго нь чанартай буюу зорилгодоо хүрэх чадамжтай хууль бүтээх явдал юм.¹³ Үүнийг хангах үндсэн арга зам нь хуулийн төслийг боловсруулах явцад нарийвчилсан судалгаа, үнэлгээ шинжилгээ хийх явдал юм. Олон улсад хуулийн төсөл боловсруулах ажиллагааны чанарыг сайжруулах зорилгоор зохицуулалтын нөлөөллийн үнэлгээ (Regulatory болон Impact Assessment буюу RIA) хийдэг. Ялангуяа сүүлийн үед АНУ, Канад болон Европын зарим улсад хуулийн төслийн зохицуулалтын үр нөлөөг үнэлэх явдлыг хуулийн төсөл боловсруулах ажлын салшгүй хэсэг гэж үздэг ба үр ашигтай байдал (efficiency), үр дүн (effectiveness), нөлөөлөл (impact) гэсэн шалгуураар үнэлдэг.¹⁴

¹² European Assistance Mission to the Albanian Justice System, Law Drafting Manual: A Guide to the Legislative Process in Albania (2006), <https://ial-online.org/wp-content/uploads/2018/05/Rep.-Albania.pdf> ("EUMAJs"), p.13, last accessed on 6 February 2025.

¹³ Victoria E. Aitken, An exposition of legislative quality and its relevance for effective development (2013) p.4. ("Victoria E. Aitken") <https://research.luc.edu/media/lucedu/prolaw/documents/AITKEN%20FINAL%20ARTICLE.pdf> last accessed on 9 February 2025.

¹⁴ EUMAJs p.21., last accessed on 6 February 2025.

Хүснэгт 1. Хуулийн төслийн зохицуулалтын үр нөлөөг үнэлэх шалгуур

Агуулга	Тайлбар
Нөлөөлөх байдал (effectiveness)	Тухайн зохицуулалт чиглэж буй этгээд (хуулийн хэрэгжилтэд хамаарах хувь хүн, хуулийн этгээд, төрийн албан хаагч)-ийн хандлага, хариу үйлдэл нь хууль тогтоогчийн төсөөлөлтэй хэр нийцэж буйг тодорхойлдог. ¹⁵ Тус шалгуурын хүрээнд зохицуулалтын хэм хэмжээ нь хүлээн зөвшөөрөгдөх үү, хэрэгжих боломжтой юу гэх асуулт тавигдана. ¹⁶ Хууль нь чиглэж буй этгээддээ хүрч бүрэн хэрэгжих чадамжтай байх учиртай. ¹⁷
Үр дүнтэй байдал (efficacy)	Хууль тогтоомж нь хэрэгжих явцдаа хууль тогтоогчийн тавьсан зорилгод хүрэх чадамжтай эсэхийг авч үздэг. ¹⁸ Хуулийн хүрэх зорилгыг оновчтой тодорхойлохгүй бол түүний үр ашигтай байдлыг бодитойгоор хэмжих боломжгүй. Иймд хуулийн зорилгыг эхнээс нь (хуулийн төслийн баримт бичгийн хүрээнд, парламентын хэлэлцүүлгийн явцад) зөв тодорхойлох нь чухал ¹⁹ бөгөөд хууль зорилгодоо хүрэх чадамжтай байхын зэрэгцээ шинэ зохицуулалтын дүнд үүсэх нөхцөл байдал нь шударга, тэгш, тодорхой, таамаглахуйц байх ²⁰ учиртай.
Үр ашигтай байдал (efficiency)	Хууль тогтоомжийн зардал, үр ашгийн харилцан хамаарлыг тодорхойлох зорилготой. Энэ нь хуулийн хүрэх үр дүн, гарах зардал харилцан тэнцвэртэй байгаа эсэхийг хэмждэг бөгөөд зорилгод хүрэхэд илүү тэнцвэртэй өөр арга зам байгаа эсэхийг авч үздэг. ²¹ Үр өгөөжтэй байна гэдэг нь зардал-үр ашгийн харьцаа эерэг үзүүлэлттэй байх, улмаар өөр бусад арга хэлбэрээс илүү бага зардлаар зорьсон үр дүндээ хүрэх боломжтой байхыг ойлгоно. ²²

Зохицуулалтын нөлөөллийн үнэлгээг дараах алхмаар хийнэ. Үүнд:²³

- Хуулиар зохицуулахыг зорьж буй асуудал, хүрэх үр дүнг тодорхойлох;
- Зохицуулалтын арга, хэлбэр (хууль боловсруулах болон бусад)-ийг тодорхойлох;
- Сонирхогч талуудыг тодорхойлж, мэдээлэл цуглуулах;
- Сонирхогч талуудтай хэлэлцүүлэг өрнүүлэх;
- Хуулийн төслийн урьдчилсан болон хууль хэрэгжсэний дараах зардал, үр өгөөжийн харьцааг үнэлэх;
- Үнэлгээний үр дүнг нийтлэх.

¹⁵ EUMAJIS p.22-23. last accessed on 6 February 2025.

¹⁶ EUMAJIS p.23. last accessed on 6 February 2025.

¹⁷ Victoria E. Aitken p.6. last accessed on 9 February 2025.

¹⁸ Victoria E. Aitken, p.6. last accessed on 9 February 2025.

¹⁹ EUMAJIS p.23. last accessed on 6 February 2025.

²⁰ Victoria E. Aitken, p.7. last accessed on 9 February 2025.

²¹ EUMAJIS p.23. last accessed on 6 February 2025.

²² Victoria E. p.6. last accessed on 9 February 2025.

²³ EUMAJIS p.21. last accessed on 6 February 2025.

Тэрчлэн дээрхээс гадна хуулийн төсөл боловсруулах явцад хэрэгжих чадамжийг нь тодорхойлох (enforceability) үнэлгээ хийх нь бий.²⁴

Үндсэндээ улс орнууд хууль боловсруулж батлах явцад хуулийн төслийн нөлөөлөх байдал, үр дүнд хүрэх чадамж, үр ашигтай байдал, хэрэгжих чадамж зэргийг үнэлж, хуулийн төслийг сайжруулах чиглэлийг тодорхойлдог байна. Үүнээс гадна улс орнууд өөрийн онцлог, хууль тогтоох ажиллагааны соёл зэргээс хамааран дээр дурдсанаас өөр судалгаа, шинжилгээ, үнэлгээг нэмэлтээр хийх нь бий.

Хууль тогтоомжийн үнэлгээг хууль батлахын өмнөх буюу урьдчилсан (prospective - ex ante), дараах (retrospective - ex post) үнэлгээ гэж ангилна. Урьдчилсан үнэлгээ нь тухайн хуулийн үзүүлэх нөлөөллийн талаар урьдчилсан төсөөлөл гаргах замаар төслийг сайжруулах зорилготой бол удаах үнэлгээг хууль баталсны дараа хэрэгжилтийг үнэлэх зорилгоор хийдэг.

Энэхүү хоёр үнэлгээ нь харилцан уялдаатай. Тодруулбал, хуулийн төслөөс ирээдүйд бий болох нөлөөллийг судалдгийн хувьд урьдчилсан үнэлгээ нь хэрэгжилтийн үнэлгээний суурь болдог. Иймд эдгээрийг ач холбогдлын хувьд ижил түвшинд авч үзэн хөгжүүлэх шаардлагатай. Хуулийн төслийн урьдчилсан болон хууль хэрэгжсэний дараах үнэлгээний дүн зөрүүтэй байж болох ба ± 25 хувь хүртэлх зөрүүг хэвийн гэж үзнэ.

Хуулийн төслийн урьдчилсан үнэлгээ нь дангаараа хуулийн төслийг бүрэн сайжруулах нөхцөл болж чадахгүй. Олон нийтийн хэлэлцүүлэг, зохицуулалтын бусад хувилбарын давуу болоод сул талыг үнэлж дүгнэх зэрэг ажиллагаануудыг хамтад нь хийж байж илүү чанаржуулна.

Монгол Улсын хувьд ХТХ-д хууль санаачлан боловсруулах үйл ажиллагаа судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх зарчмыг онцгойлон тусгаж, хууль тогтоомжийн төсөл боловсруулахад (i) хэрэгцээ шаардлагын урьдчилсан тандан судалгаа эсхүл тухайн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ; (ii) зардлын тооцоо; (iii) үр нөлөөний үнэлгээг тодорхой аргачлалын дагуу хийхээр зохицуулжээ.

ХТХ-д заасан тооцоо, судалгааны заримыг нь хуулийн төсөл боловсруулах явцад, заримыг нь хууль батлагдсаны дараа гүйцэтгэнэ. Мөн хуулийн төслийн төрлөөс хамааран хийгдэх судалгаа, шинжилгээ харилцан адилгүй байдаг.


²⁴ EUMAJIS p.24. last accessed on 6 February 2025.

Хүснэгт 2. Хуулийн төслийн төрөл, түүнд хамаарах судалгаа, хийгдэх үе шат

Судалгааны төрөл	Уг судалгаа хийгдэх үе шат	Хуулийн төслийн төрөл
Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагын тандан судалгаа (efficacy and efficiency)	Хуулийн төсөл боловсруулж эхлэхээс өмнө	- Анхдагч хуулийн төсөл - Хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөл (хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуульд зарчмын шинжтэй зохицуулалт шинээр нэмэх тохиолдолд)
Хууль тогтоомжийн хэрэгжилт, үр дагаврын үнэлгээ (efficacy)	Хууль батлагдсаны дараа буюу хэрэгжилтийн явцад	- Шинэчилсэн найруулгын төсөл - Хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөл
Зардлын тооцоо (efficiency)	Хуулийн төсөл боловсруулсны дараа хийнэ.	- Бүх хуулийн төсөл
Хууль тогтоомжийн үр нөлөөний үнэлгээ (effectiveness)	Хуулийн төсөл боловсруулсны дараа хийнэ.	- Бүх хуулийн төсөл

Тухайн хуулийн төслийн төрлөөс хамааран хэрэгцээ, шаардлагын тандан судалгаа эсхүл хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний аль нэгийг хийх бол зардлын тооцоо, үр нөлөөний үнэлгээг бүх хуулийн төсөлд хийнэ.

График 1. Хуулийн төсөл боловсруулах, батлах үйл явцын ерөнхий зураглал: Судалгаа, шинжилгээ



Дээрхээс үзвэл, ХТтХ болон Багц аргачлалын дагуу Монгол Улсын хууль тогтоомж батлах үйл ажиллагааны явцад хийгдэж буй тооцоо, судалгаа, үнэлгээ нь олон улсад түгээмэл ашиглагддаг аргачлал, шалгууруудыг хамруулсан байх бөгөөд хийгдэх хугацааны хувьд ч хуулийг албан ёсоор батлахын өмнө болон баталсны дараа, хэрэгжилтийн шатанд үнэлгээ хийж эдгээр нь хоорондоо харилцан уялдаатай бөгөөд хууль тогтоомжийг боловсронгуй болгох үйл явц тасралтгүй үргэлжлэх шинжтэй байгаа нь сайшаалтай.

ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙГ СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭНД ҮНДЭСЛЭН БОЛОВСРУУЛАХ ЗАРЧМЫН ХЭРЭГЖИЛТ

Судалгаанд хамрагдсан 98 хуулийг боловсруулах явцад холбогдох судалгаа, шинжилгээ хийсэн байдлыг авч үзвэл тэдгээрийн 70-д хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагын тандан судалгаа эсхүл хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ (хамтад нь “суурь судалгаа” гэх) хийжээ. Үүний 55 нь хэрэгцээ шаардлагын тандан судалгаа, 15 нь хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ байна. Мөн 78 хуулийн төсөлд зардлын тооцоо, 81-д үр нөлөөний үнэлгээ тус тус хийгджээ.

График 2. Судалгаанд хамруулсан нийт 98 хуулийн төсөлд судалгаа хийсэн байдал



Үүнээс харахад хуулийн төслийг судалгаа, шинжилгээнд үндэслэн боловсруулах зарчмын хэрэгжилт төдийлөн хангалтгүй буюу судалгаа хийхгүй байх явдал гарсаар байна. Харин хийсэн судалгааны агуулга, чанар, түүнийг сайжруулахад анхаарах асуудлуудыг энэхүү тайлангийн үргэлжлэлээс үзнэ үү.

2.1. Хуулийн төсөлд суурь судалгаа хийсэн байдал

Хуулийн төсөл боловсруулах ажиллагаа нь хууль батлах хэрэгцээ, шаардлага, улс төрийн болон хууль зүйн үндэслэлийг тодорхойлохоос эхэлнэ. Иймд хууль санаачлагч тухайн хуулийн төслийн хэрэгцээт байдал, үр нөлөөг урьдчилан тогтоох үүрэгтэй. ЭЗХАХБ-ын Засаглалын чанарыг сайжруулах тухай 1995 оны зөвлөмж болон 2005 онд шинэчлэн найруулсан Хууль тогтоомжийн чанар ба гүйцэтгэлийг сайжруулах удирдамжид хууль тогтоомж батлах хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, Үндсэн хууль болон бусад хуультай нийцүүлэх, уялдаа холбоог хангахад дараах шалгуур асуултуудыг ашиглахыг зөвлөсөн байдаг. Үүнд:²⁵

1. Тулгамдаж буй асуудлыг зөв тодорхойлсон уу?
2. Засгийн газрын оролцоо буюу хуулийн зохицуулалт шаардлагатай юу?
3. Хууль тогтоомж нь зохицуулалтын хамгийн оновчтой хэлбэр мөн үү?
4. Хууль тогтоомж гаргах хууль зүйн үндэслэл байна уу?
5. Тухайн үйл ажиллагааг хэрэгжүүлэх засаг захиргааны хамгийн тохиромжтой нэгж нь аль вэ?
6. Хууль тогтоомжийн үр өгөөж нь зардлаас өндөр үү?
7. Нийгэмд үзүүлэх нөлөөлөл нь тодорхой юу?
8. Хууль тогтоомж нь ойлгомжтой, нийцтэй, уялдаа холбоотой, хуулийг хэрэгжүүлэх, хэрэглэх бүх этгээдэд хүртээмжтэй юу?
9. Сонирхогч талууд санал, бодлоо илэрхийлэх боломжтой байсан уу?
10. Хэрхэн мөрдүүлэх вэ?

Хуулийн төсөл боловсруулахын өмнө тухайн асуудлыг зайлшгүй хуулиар зохицуулах (шинээр хууль гаргах эсхүл өмнөх хуульд нэмэлт өөрчлөлт оруулах) шаардлагатай эсэхийг нухацтай үнэлэх нь чухал. Ингэхдээ хуулийн эерэг нөлөөг сөрөг үр дагавартай нь харьцуулан үнэлэх ба шинэ хууль нь олон нийт, бизнесийн болон төрийн байгууллагад өндөр зардал, ачаалал үүсгэхээр байвал тухайн тооцож буй үр нөлөөнд хүрэхийн тулд ийм хэмжээний зардал гаргах зайлшгүй шаардлага байгаа эсэхийг нягтална.²⁶

Хэрэв зохицуулах асуудлын цар хүрээ хязгаарлагдмал, цаг хугацааны явцад аяндаа шийдэгдэх магадлалтай бол заавал хууль батлах шаардлагагүй гэж үздэг ба зохицуулалтын бусад арга хэмжээ авах боломжийг эрэлхийлнэ.²⁷

²⁵ EUMAJIS p.14. last accessed on 10 March 2025.

²⁶ EUMAJIS p.14. last accessed on 10 March 2025.

²⁷ EUMAJIS p.14. last accessed on 10 March 2025.

Хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлагыг үнэлэхдээ "хууль зүйн тодорхой байдал" (legal certainty)-ын зарчмыг баримталдаг. Энэ нь хуулийн зохицуулалтын тодорхой, логик уялдаатай, тогтвортой байдлаар илрэх ба иргэдийн эрх болон хүлээлтийг хууль тогтоомжийн тогтворгүй байдлаар зөрчих ёсгүй гэж үздэг.²⁸


ХТТХ-ийн 14 дүгээр зүйлийн 14.1-т "Хууль санаачлагч хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсны эсхүл хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсний үндсэн дээр үзэл баримтлалын төсөл боловсруулна" гэж заажээ. Үүнээс харахад эдгээрийг хуулийн төсөл боловсруулах зорилго, үндэслэлийг тодорхойлох суурь баримт бичиг²⁹ буюу хуулийн төсөл боловсруулах ажлын хамгийн эхэнд хийгдэх суурь судалгаа гэж үзэж болох юм.

Судалгаанд хамрагдсан нийт 98 хуулиас 97-д суурь судалгаа хийх шаардлагатай байв.

Суурь судалгаа хийх шаардлагагүй гэж үзсэн нэг хууль нь 2020 оны 12 сарын 24-нд батлагдсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль байв. Тус хуулийн хувийн хэрэгт "ХТТХ-ийн 12.3.1-т заасны дагуу шаардлагагүй"³⁰ гэсэн тэмдэглэгээ хийсэн байх тул судалгааны энэ хэсэгт хамааруулаагүй.

Дээрх 97 хуульд суурь судалгаа хийсэн байдлыг дор харуулав.

График 3. Суурь судалгаа гүйцэтгэсэн байдал



²⁸ EUMAJIS p.14. last accessed on 10 March 2025.

²⁹ Р.Оюундэлгэр, Б.Ариунзаяа, "Хууль, тогтоомжийн төслийн ил тод байдал ба олон нийтээр хэлэлцүүлэх шаардлагын хэрэгжилт", Нээлттэй нийгэм форум, (2025) <https://forum.mn/product/459176>, 31 дэх тал

³⁰ Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3-т "Энэ хуулийн 12.1.2-т заасан хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал дараах хууль тогтоомжийн төсөл боловсруулахад хамаарахгүй" гээд 3 тохиолдлыг хамааруулжээ.

Эдгээр хуулиудийн 70-д нь суурь судалгаа хийгдсэн бол 27 хуулийн судалгааны тайлан олдоогүй. Энэ нь судалгаа огт хийгээгүй эсхүл тайланг нээлттэй болгоогүй аль нь болохыг тодорхойлох боломжгүй байв.

Суурь судалгаа гүйцэтгэсэн байдлыг хуулийн төслийн төрлөөр ангилан үзүүлэв.

Хүснэгт 3. Суурь судалгаа гүйцэтгэсэн байдал, хуулийн төслийн төрлөөр

№	Хуулийн төслийн төрөл	Судалгааны төрөл	Судалгаа гүйцэтгэсэн эсэх	Тоо	Нийт 97 хуульд эзлэх хувь
1	Анхдагч хуулийн төсөл	Хэрэгцээ, шаардлагын тандан судалгаа	Судалгаа гүйцэтгэсэн	21	21.6%
			Судалгаа олдоогүй эсхүл судалгаа гүйцэтгээгүй	3	3%
2	Хуулийн шинэчилсэн найруулгын төсөл	Хэрэгцээ, шаардлагын тандан судалгаа	Судалгаа гүйцэтгэсэн	17	17.5%
		Хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ	Судалгаа гүйцэтгэсэн	15	15%
		Судалгаа олдоогүй эсхүл судалгаа гүйцэтгээгүй		14	14%
3	Хуульд өөрчлөлт оруулах (нэмэлт; өөрчлөлт; нэмэлт, өөрчлөлт) хуулийн төсөл	Хэрэгцээ, шаардлагын тандан судалгаа	Судалгаа гүйцэтгэсэн	17	17.5%
			Судалгаа олдоогүй эсхүл судалгаа гүйцэтгээгүй	10	10%
Нийт				97	100%

Эндээс үзвэл шинэчилсэн найруулга, хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөлд суурь судалгаа хийхгүй байх явдал харьцангуй өндөр байна. Тэрчлэн энэ хоёр тохиолдолд суурь судалгааны алийг хийх нь ойлгомжгүй байгаа нь харагдаж байна. Тодруулбал, шинэчилсэн найруулга бүхий 32 төслөөс 17-д нь тандан судалгаа, 15-д нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийсэн байх бол хуульд өөрчлөлт оруулах тухай 17 хуульд тандан судалгаа хийсэн байна. Ийнхүү нэг төрлийн хуулийн төсөлд өөр өөр судалгааг хийх болсон нь ямар тохиолдолд аль судалгаа хийх ёстойг хуулиар нарийн тодорхойлоогүйтэй холбоотой.

ХТХ-ийн 13 дугаар зүйлийн 13.3-д анхдагч хууль болон хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуульд зарчмын шинжтэй зохицуулалт шинээр нэмж оруулах төсөл боловсруулахад хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагын тандан судалгаа хийхээр заасан бол, 51 дүгээр зүйлийн 51.1-д хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуульд өөрчлөлт оруулах, шинэчлэн найруулах, багц хуулийн төсөл боловсруулахад түүний хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийх

талаар тус тус заасан. Эндээс харахад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуульд зарчмын шинжтэй зохицуулалт шинээр нэмж тусгах бол хэрэгцээ, шаардлагын тандан судалгаа гүйцэтгэх ба бусад тохиолдолд хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг гүйцэтгэнэ. Харин ХТХ-д "зарчмын шинжтэй зохицуулалт" гэж юуг ойлгох талаар тодорхой хуульчлаагүйгээс ийнхүү суурь судалгаа гүйцэтгэх ойлгомжгүй байдал үүсжээ.

Судалгааны энэ хэсэгт хамаарах нийт 97 хуулиас судалгаа хийсэн эсэх нь тодорхойгүй 27 хууль, хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийсэн 15 хуулийн судалгааны тайланг хасаж³¹, цаашид 55 хуулийн тандан судалгааны тайланд чанарын үнэлгээ хийв. Чанарын үнэлгээг Засгийн газраас баталсан холбогдох аргачлалд суурилан хийсэн болно. Тэрчлэн чанарын үнэлгээнд хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хамруулаагүй. Учир нь энэ асуудлыг тусад нь бие даан судалж байгаа талаар өмнө дурдсан билээ.

ХТХ-ийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Хууль санаачлагч хууль тогтоомжийн төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлагыг энэ хуулийн 12.1.2-т заасан аргачлалын дагуу тодорхойлно" гэж заасан бөгөөд тус заалтыг хэрэгжүүлэх хүрээнд ЗГ-ын 2016 оны 59 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар "Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал"³² (**тандан судалгааны аргачлал**)-ыг баталжээ.

Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагын тандан судалгаа (**тандан судалгаа**) нь зөвхөн хуулийн төсөл боловсруулахын өмнөх бэлтгэл үе шат биш бөгөөд тухайн асуудлыг шийдвэрлэхэд зайлшгүй хууль батлах уу эсхүл бусад арга замаар шийдвэрлэх боломжтой юу гэх асуултад хариулт өгдөг. Хуулийн төслийн тандан судалгаа нь анхдагч хуулийн төсөл болон хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуульд зарчмын шинжтэй зохицуулалт шинээр нэмж оруулах тохиолдолд хийгдэнэ.³³


³¹ Судалгааны энэ хэсгийн эхэнд буюу график 2, 3-д үзүүлсэн тоон үзүүлэлт нь хууль тогтоомжийн (i) хэрэгцээ, шаардлагын тандан судалгаа, (ii) хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг тус тус багтаасан боловч цаашид чанарын үнэлгээг зөвхөн хэрэгцээ, шаардлагын тандан судалгааны хүрээнд хийсэн болно. Учир нь "Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ"-ний чанарыг үнэлэх судалгааг судалгааны өөр баг тусдаа хийгдэж байгаа болно.

³² ЗГ-ын 2016 оны 59 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт "Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах ажлын зорилт нь тодорхой асуудлыг шийдвэрлэх зохицуулалтын хувилбарыг тодорхойлж, эерэг болон сөрөг талыг харьцуулан судалсны үндсэн дээр үр нөлөөг урьдчилан тооцож, уг асуудлыг шийдвэрлэх үр дүнтэй хувилбарыг хууль санаачлагчид санал болгоход оршино."

³³ Хууль тогтоомжийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсэг.

Тандан судалгааны аргачлалд асуудлыг урьдчилан тандан судлах ажлын долоон үе шатыг тодорхойлжээ.

График 4. Хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах ажлын үе шат



Хэрэв тандан судалгаа хийж эхэлсэн боловч тухайн асуудлыг хууль батлахаас өөр хувилбараар шийдвэрлэх боломжтой гэж үзсэн бол судалгааг 3 дахь үе шатанд дуусгавар болгоно.³⁴ Харин үүнээс бусад тохиолдолд дээрх долоон үе шатыг бүхэлд нь баримтлах учиртай.

³⁴ Тандан судалгааны аргачлалын 5.3 дахь хэсэг "Энэхүү аргачлалын 5.1.1-5.1.6-д дурдсан зохицуулалтын хувилбарыг хэрэглэж зорилгод хүрэх боломжтой нь тогтоогдвол үр нөлөөг тандан судлах ажлыг цааш үргэлжлүүлэх шаардлагагүй бөгөөд энэ тухай дүгнэлт бичсэнээр ажиллагаа дуусгавар болно."

Судалгааны энэхүү хэсэгт хамаарах 55 хуулийн тандан судалгаанд дээрх долоон үе шатыг баримталсан байдлыг доор үзүүлэв.

График 5. Тандан судалгааны үе шатыг баримталсан байдал



Дээрхээс дүгнэвэл, тандан судалгааны чанарын үнэлгээнд хамаарах нийт 55 тайлангийн ихэнх буюу 49 нь судалгааны аргачлалд заасан долоон үе шатыг бүрэн баримталсан байх бол үлдэх зургаа нь аргачлалыг бүрэн баримтлаагүй буюу зарим үе шатыг орхигдуулсан эсхүл тухайн шатанд хийх зарим ажиллагааг дутуу хийсэн байна. Судалгааны гүйцэтгэлийг үе шат бүрээр дүгнэвэл:

- I үе шат: Бүх тайланд асуудал, түүний учир шалтгааныг ямар нэг байдлаар тодорхойлсон байх боловч зөвхөн 73 хувь нь асуудлыг баримтад тулгуурлан дүгнэсэн байх бол үлдсэн 27 хувьд асуудлын шинжилгээ нь хэт ерөнхий бөгөөд олон тооны асуудлыг таамаг төдий дурдсан байна.
- II үе шат: Нийт судалгааны тайланд асуудлыг шийдвэрлэх зорилгыг ямар нэг хэмжээгээр томъёолсон байх боловч олонх буюу 55 хувь нь “эрх зүйн зохицуулалт бий болгох, сайжруулах” гэх мэт ерөнхий байдлаар томъёолжээ.
- III үе шат: Асуудлыг шийдвэрлэх хувилбар тодорхойлохдоо дийлэнх буюу 71 хувь нь аргачлалд заасан шийдлийн долоон хувилбараас 6-7 хувилбар

сонгосон байх бол үлдсэн нь 1-3 хувилбарыг сонгож, тус хувилбаруудын эерэг, сөрөг тал, зардал, үр өгөөжийг маш товч харьцуулсан.

- IV үе шат: Зохицуулалтын хувилбарын үр нөлөөг үнэлэх шатанд өмнөх шатанд хийсэн эхний харьцуулалтад тулгуурлан сонгон авсан хувилбар бүрийн үр нөлөөг нарийвчлан үнэлэх ёстой ч энэ шаардлага бүрэн хэрэгжихгүй байна. Өөрөөр хэлбэл, III шатанд хэд хэдэн хувилбар сонгож эерэг, сөрөг талыг харьцуулах боловч цааш нь үр нөлөөний үнэлгээг зөвхөн хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбарт л хийж (нийт тайлангийн 93 хувь) байна. Харин үр нөлөөг үнэлэхэд аргачлалд заасан дөрвөн чиглэлийг баримталж хэвшжээ.
- V үе шат: Дээр дурдсанчлан хууль тогтоомжийн төсөл боловсруулахаас бусад хувилбарт үр нөлөөний үнэлгээ хийхгүй байгаа учраас нийт тайлангийн 93 хувь нь хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбарыг ямар нэгэн харьцуулалтгүйгээр шууд сонгосон байна
- VI үе шат: Нийт тайлангийн 80 хувьд нэг ба түүнээс олон гадаад улсын эрх зүйн орчны харьцуулсан судалгаа хийсэн. Харьцуулсан судалгаа хийгээгүй 11 тайлангийн 7 нь хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл байв.
- VII үе шат: Тайлангийн ихэнх нь ямар нэг зөвлөмж өгсөн байна. Зөвлөмж өгөөгүй буюу ямар нэг дүгнэлт хийгээгүй 2 тохиолдол байв.

Судалгаанд хамрагдсан хуулийн төслүүдийн тандан судалгаанд Засгийн газраас баталсан аргачлалыг хэрэглэж хэвшсэн байх боловч зарим үе шат, дэд хэсгүүдийг орхигдуулсан, хэлбэр төдий гүйцэтгэсэн тохиолдол цөөнгүй ажээ. Тухайлбал, 2022 оны 04 сарын 22-ны өдөр батлагдсан Эрдэнэсийн сангийн тухай хуулийн тандан судалгаанд асуудлын шинжилгээг зохих ёсоор хийгээгүй буюу аргачлалын 3 дахь хэсэгт заасанчлан асуудлын цар хүрээ, үүссэн шалтгаан, нөхцөл, эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээдийг тодорхойлоогүй байна.

Түүнчлэн судалгааг аргачлалд заасан дэс дарааллын дагуу хийгээгүй боловч тайлан нь агуулгын хувьд аргачлалд заасан шаардлагыг бүрэн хангасан тохиолдол ч байв. Тухайлбал, 2023 оны 07 сарын 07-ны өдөр батлагдсан Техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын тандан судалгааны тайлан бүтцийн хувьд нийтлэг жишгээс ялгаатай боловч аргачлалд заасан агуулгыг бүрэн багтаасан байв.

Хүснэгт 4. Аргачлалд заасан дарааллыг баримтлаагүй боловч агуулгын хувьд аргачлалд заасан асуудлыг бүрэн хамарсан тайлангийн жишээ

Тайлангийн бүтэц	Тухайн бүлгийн агуулга
1. Техникийн болон Мэргэжлийн боловсрол, сургалт	Хуулийн хэрэгжилт, тулгамдаж буй асуудлыг тодорхойлсон.
2. Асуудлыг хууль тогтоомжоор зохицуулах санал, тандалт судалгааны үр дүн	Асуулгын судалгааны үр дүнг тусгасан.
3. Хууль тогтоомжоор зохицуулах хувилбаруудын эерэг ба сөрөг тал	Хоёр хувилбар сонгон хооронд нь харьцуулсан бөгөөд ингэхдээ хуулийн төслийн зорилгыг тодорхойлж, түүнд хүрэх байдлыг харьцуулсан.
4. Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө, үр дүнтэй хувилбар	Сонгосон хувилбарын үр нөлөөг үнэлсэн.
5. Хуулийн шинэчилсэн найруулгад тусгах санал	Хуулийн төсөлд тусгах цөөн тооны зөвлөмжийг боловсруулсан.
6. Зохицуулалтын хувилбаруудыг харьцуулсан дүгнэлт	Хуулийн төсөлд тусгах цөөн тооны зөвлөмжийг боловсруулсан.
7. Шаардлагатай бусад судалгаа, олон улсын жишиг	Олон улсын харьцуулсан судалгаа гүйцэтгэсэн.
8. Зөвлөмж	Дүгнэлт, зөвлөмж боловсруулсан.

Мөн ХТтХ-ийн 12 дугаар зүйлийн 12.2 болон 12.3-т заасан тандан судалгаа хийх шаардлагагүй нөхцөлд хамаарахгүй хуулийг “хамаарна” хэмээн дүгнэж, аргачлалаас гажиж судалгаа гүйцэтгэсэн тохиолдол байв. Тухайлбал, 2024 оны 05 сарын 16-ны өдөр батлагдсан Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын тандан судалгааны тайланд “тус хуулийн төсөл нь ХТтХ-ийн 12 дугаар зүйлийн 12.2.8-д заасан “Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл” тул судалгаа хийх шаардлагагүй ч холбогдох судалгааг гүйцэтгэв” гээд тандан судалгаа хийжээ. Ингэхдээ тандан судалгааны аргачлалыг ерөнхийд нь дагасан байв. Улмаар хуулийн зохицуулах асуудлыг тодорхойлж, олон улсын харьцуулсан судалгаа хийсний үндсэн дээр хувилбар (i) 1993 оны 09 сард НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн төлөөлөгчдийн санал болгосныг баримтлах; (ii) Япон, Солонгос, Хятад, ОХУ, Казакстан зэрэг орнуудын шинжлэх ухаан, технологийг судлан Монгол Улсын өнөөгийн нөхцөл байдалтай уялдуулсны үндсэн дээр зохицуулалтыг шинэчлэх зэрэг хувилбаруудыг зөвлөжээ. Гэхдээ тус хуулиар ЗГ-ын бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулаагүй бөгөөд харин шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаанд баримтлах зарчим,

бодлого, төлөвлөлт, удирдлага, зохион байгуулалт, хувийн хэвшлийн оролцоо, төрийн дэмжлэг, санхүүжилтийн эрх зүйн үндсийг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулах зэрэг өргөн цар хүрээтэй зорилт тавьсан. Мөн тус хууль нь Монгол Улсын баримтлах шинжлэх ухааны суурь зарчмыг тодорхойлсон чухал ач холбогдол бүхий хууль атал тандан судалгаанд холбогдох аргачлалыг баримтлах шаардлагагүй гэж үзсэн нь анхаарал татаж байна. Энэ талаар хуулийн төслийн бүрдүүлбэрийг хянах үүрэг бүхий холбогдох байгууллага болон хууль тогтоогчийн зүгээс хяналт тавьж, судалгааг аргачлалд нийцүүлэхэд чиглэсэн ямар нэг арга хэмжээ аваагүй гэж үзэж болохоор байна.

ХТХ болон тандан судалгааны аргачлалын хэрэгжилтийн байдлыг тодорхойлох зорилгоор ЗГ-ын өргөн мэдүүлэх хуулийн төсөл ХТХ-д заасан шаардлагад нийцсэн эсэхийг шалгаж, ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэх, цаашлаад УИХ-д өргөн мэдүүлэх зөвшөөрөл олгодог институт болох Хууль зүй, дотоод хэргийн яамны холбогдох ажилтантай ярилцлага хийв.

Хуулийн төслийг өргөн барихад нэн түрүүнд төслийн бүрдүүлбэр хангасан байхыг шаарддаг тул бүхий л тохиолдолд ямар нэг байдлаар судалгааг гүйцэтгэсэн, бүрдүүлбэрийг хангасан байдаг. Гэхдээ аргачлалуудыг хэлбэрийн төдий барьж гүйцэтгэх нь түгээмэл байдаг. Харин чанарын хувьд сайн гүйцэтгэе гэвэл аргачлал нь судалгааны сайн суурь болж чадахуйц байдаг. Тухайн судалгаа нь чанарын хувьд үндэслэл бүхий, бодитой юу гэдэгт хяналт тавихад төрийн албаны хувьд хүний нөөцийн буюу мэргэжилтний тоо болон ур чадварын асуудал ихээхэн нөлөөлдөг. Иймд цаашид судалгаануудыг аргачлалын дагуу чанартай гүйцэтгэхэд анхаарах, үүнд хяналт тавих болон аргачлалуудыг шинэ хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн сайжруулах асуудал чухал байна.

Хууль зүй, дотоод хэргийн яамны холбогдох ажилтны ярилцлагаас

Судалгааны өмнөх хэсэгт тандан судалгааны аргачлалын хэрэгжилтийг үе шат тус бүрээр ерөнхийд нь авч үзсэн бол доорх хэсэгт тэдгээр үе шатуудад тавигдах шаардлага, хийгдвэл зохих ажиллагааны хэрэгжилтийг нарийвчлан үзлээ.

I үе шат: Асуудлыг тодорхойлох дүн шинжилгээ хийж буй байдал

Нийт тайланд асуудал, түүний учир шалтгааныг ямар нэг хэмжээнд тодорхойлсон байх боловч асуудлыг хэт ерөнхийлсөн эсхүл олон тооны асуудлыг баримтгүйгээр таамаг төдий дурдах байдал нийтлэг байна.

Тандан судалгааны аргачлалын дагуу хууль батлах зайлшгүй шаардлагатай эсэхийг тодорхойлохын тулд асуудлыг дараах байдлаар шинжлэн судлах ёстой. Үүнд:

- Тухайн асуудлын цар хүрээнд хамаарах магадлалтай этгээдүүдийн дунд санал асуулга явуулж, эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх нийгмийн бүлгийг нарийвчлан тодорхойлох, үүнд бусад этгээдийн оролцоог хангах;
- Санал асуулгад хамруулж байгаа этгээд нь тухайн бүлэг, салбар, нутаг дэвсгэрийг төлөөлөхүйц хэмжээнд байх;
- Мэргэжилтнүүдтэй уулзаж ярилцах болон бусад аргаар бүх шаардлагатай мэдээллийг цуглуулах;
- Тодорхой судалгаа, тоо баримт ашиглах.

Гэвч судалгааны энэ хэсэгт хамаарах 55 хуулийн төслийн тандан судалгааны 27 хувьд асуудлын дүн шинжилгээ нь хэт ерөнхий, зарим тохиолдол бүр таамаг төдий, тухайн асуудал бодитой эсэхийг нотлох статистик тоо баримт дурдаагүй байна. Мөн хэлэлцүүлэг, санал асуулгад хуулийн үйлчлэх хүрээнд хамаарах хүн ам, нийгмийн бүлэг, нутаг дэвсгэрийг бүрэн хамруулаагүй эсхүл төлөөлөхүйц хэмжээнд оролцуулаагүй, хуулийн үйлчлэлд шууд бусаар өртөх бусад этгээдийн оролцоог хангаагүй тохиолдол цөөнгүй байна.³⁵ Хуулийн үйлчлэлд өртөх талуудад тулгарч буй асуудлыг тодорхойлоход оролцооны аргыг ашиглахгүй, зөвхөн судалгаа, статистик, өмнөх хуулийн хэрэгжилтийн мэдээлэлд тулгуурлах нь нийтлэг байна. Тухайлбал, 2024 оны 04 сарын 05-ны өдөр батлагдсан Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн тандан судалгааны тайланд зөвхөн Архангай болон Баянхонгор аймгийн малчин өрхүүдийг хамруулсан нь хуулийн үйлчлэх хүрээнд хамрах хүн ам, нийгмийн бүлэг, нутаг дэвсгэрийг төлөөлөхүйц хэмжээнд хамруулах шаардлагад нийцэхгүй буюу 21 аймаг, нийт малчдыг бүрэн төлөөлж чадахааргүй байна (Дэлгэрэнгүйг Хавсралт 4-өөс үзнэ үү.)

³⁵ Р.Оюундэлгэр, Б.Ариунзаяа, “Хууль, тогтоомжийн төслийн ил тод байдал ба олон нийтээр хэлэлцүүлэх шаардлагын хэрэгжилт”, Нээлттэй нийгэм форум, (2025) <https://forum.mn/product/459176>, 35 дахь тал

II үе шат: Асуудлыг шийдвэрлэх зорилго, зорилтыг томьёолсон байдал

Дийлэнх тайланд асуудал шийдвэрлэх зорилгыг хэт ерөнхий буюу “тухайн харилцааг зохицуулах эрх зүйн орчныг бий болгох” гэх байдлаар томьёолжээ.

Угтаа тандан судалгааны аргачлалын дагуу асуудлыг шийдвэрлэх зорилгыг аль болох тодорхой, хэмжих боломжтой, хүрэхүйц байдлаар, бодитой томьёолох ёстой.

Тодруулбал, График 5-т харагдаж байгаачлан тандан судалгааны тайлангуудад “асуудлыг шийдвэрлэх зорилго”-ыг ямар нэг хэмжээнд тодорхойлсон байх боловч үүнээс 55 хувь нь ерөнхий, 45 хувь нь нарийвчлан тодорхойлжээ. Үүнийг хуулийн төслийн төрлөөр авч үзвэл, анхдагч хууль болон шинэчилсэн найруулгын төсөлд зорилгыг дийлэнхдээ нэлээд ерөнхий томьёолох хандлага ажиглагдаж байна. Тухайлбал, 2021 оны 04 сарын 02-ны өдөр батлагдсан Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай анхдагч хуулийн тандан судалгааны тайланд тус хуулийг батлах зорилгыг “Хүний эрхийн төлөө тэмцэж буй этгээдийг бусдын халдлагаас хамгаалах, үйл ажиллагаагаа тогтвортой явуулах боломжоор хангах” гэж томьёолжээ. (Бусад жишээг Хавсралт 5-аас үзнэ үү.)

Харин хуульд өөрчлөлт оруулах³⁶ төслүүдийн судалгааны тайланд асуудал шийдвэрлэх зорилгыг арай “тодорхой” гэж үзэж болохуйц буюу тухайн зохицуулалтыг нэмэх, өөрчлөх, эсхүл хассанаар ямар үр дүнд хүрэхийг нарийвчлан тусгасан нь онцлог байна. Тодруулбал, хуульд ямар нэг нэмэлт, өөрчлөлт оруулж буй 17 хуулийн төслийн тандан судалгааны тайлангийн 16-д нь зорилгыг тодорхой гэж үзэж болохуйцаар тодорхойлжээ. Тухайлбал, 2024 оны 06 сарын 05-ны өдөр батлагдсан Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн тандан судалгааны тайланд зорилгыг “оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн зориулалтаар импортолж байгаа, дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй түүхий эд, үндсэн болон туслах материалыг гаалийн албан татвараас чөлөөлснөөр оёдлын салбарын татварын дарамтыг бууруулж, дэмжлэг үзүүлэх” гэж тодорхойлсон нь хэмжиж болохуйц

³⁶ Хууль тогтоомжийн тухай хуулийн 24.5.Хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөл нь дараах төрөлд хуваагдана:

24.5.1.хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;

24.5.2.хуульд нэмэлт оруулах тухай;

24.5.3.хуульд өөрчлөлт оруулах тухай;

24.5.4.хуулийн зүйл, хэсэг, заалтыг хүчингүй болсонд тооцох тухай.

буюу бодитой хэрэгжихүйц байх шаардлагад нийцжээ. (Хуулийн төслийн төрлөөр ангилсан бусад жишээг дэлгэрүүлж Хавсралт 5-аас үзнэ үү.)

III үе шат: Тухайн асуудлыг зохицуулах хувилбаруудыг сонгож буй байдал

Тандан судалгааны аргачлалд асуудлыг шийдвэрлэх боломжит долоон хувилбарыг бүгдийг нь, хэд хэдийг эсхүл зөвхөн хамгийн үр дүнтэй гэж үзсэн аль нэгийг сорчлон сонгох ёстой юу гэдгийг тодорхой заагаагүйгээс судалгааны тайлангуудад харилцан адилгүй байдлаар сонгож, ийнхүү сонгосон үндэслэлээ тайлбарлахгүй байх нь нийтлэг байна. Тэрчлэн сонгон авсан хувилбаруудын эерэг, сөрөг тал болон зардал, өгөөжийн харьцааг харьцуулж буй байдал хэлбэрийн төдий хийгдэж байна.

Тандан судалгааны аргачлалд дараах зохицуулалтын хувилбаруудыг заасан бөгөөд хууль санаачлагч өмнөх шатанд хийсэн асуудлын шинжилгээний дүнд тулгуурлан эдгээрээс аль тохиромжтойг сонгон авч, зорилгод хүрэх байдал болон зардал, үр өгөөжийг үнэлнэ. Энэхүү үнэлгээний дүнг харгалзан хамгийн үр дүнтэй байж болох хувилбарыг сонгон судалгааг цааш үргэлжлүүлэх учиртай.

График 6. Тандан судалгааны аргачлалд заасан зохицуулалтын хувилбарууд





График 7. Харьцуулалт хийхээр сонгон авсан зохицуулалтын хувилбарын тоо (III үе шат)



Тандан судалгааны 55 тайлангийн дийлэнх буюу 71 орчим хувь нь зохицуулалтын 6-7 хувилбарыг хамт сонгосон байна. Сонгон авсан хувилбарын “зорилгод хүрэх байдал” болон “зардал, үр өгөөжийн харьцаа”-г үнэлэхдээ хуулийн төслийн зохицуулах асуудал, зорилтын ялгаатай байдлаас үл хамааран бараг бүх тохиолдолд “хууль тогтоомжийн төсөл боловсруулах” хувилбарыг хамгийн үр дүнтэй гэж үзсэн байв.

Мөн бусад хувилбарт өгсөн үнэлгээний агуулга өөр хоорондоо бараг ижил байгаа нь анхаарал татаж байна.

Тандан судалгааны аргачлалын 5.4-т зааснаар дараах нөхцөлд шууд хууль тогтоомжийн төсөл боловсруулах буюу өөр бусад хувилбаруудтай харьцуулах шаардлагагүй. Үүнд:

- тухайн асуудал нь хүний салшгүй эрхэд буюу Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуульд заасан хүний эрхийг хязгаарлах бол;
- тухайн асуудлыг гагцхүү хуулиар зохицуулах шаардлагатай болохыг Үндсэн хуульд онцлон заасан бол;
- Монгол Улсын олон улсын гэрээгээр Монгол Улс тухайн асуудлаар дотоодын хууль тогтоомждоо нэмэлт, өөрчлөлт оруулах, шинээр боловсруулах талаар тусгайлан үүрэг хүлээсэн бол;
- “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу хийсэн үнэлгээнээс тухайн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэсэн зөвлөмж гарсан бол.

Дээрх үндэслэлээр хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбарыг шууд сонгосон 11 тохиолдол байв.

Мөн аргачлалын 5.5-д тухайн асуудлыг хууль гаргах замаар шийдвэрлэх дүгнэлт гарсан тохиолдолд хуулийн төслийн бүтэц, агуулга, оруулах нэмэлт, өөрчлөлтийг ерөнхий байдлаар томъёолж бичнэ гэж заасны дагуу 24 судалгааны тайланд хуулийн төслийн агуулга эсхүл бүтцийг ерөнхий байдлаар томъёолжээ.

Хүснэгт 5. Зохицуулалтын хувилбаруудыг харьцуулан дүгнэж буй байдал, нийтлэг хариултууд

Тандан судалгааны аргачлалд заасан хувилбар		Зорилгод хүрэх байдал	Зардал, өгөөжийн харьцаа	Үр дүн
1	Тэг хувилбар (5.1.1)	Өнөөгийн тулгамдаад байгаа бэрхшээл хэвээр үргэлжлэх бөгөөд зорилгод хүрэх боломжгүй.	Нэмэлт зардал гарахгүй ч, сөрөг үр дагавар улам нэмэгдэнэ.	Үр дүн сөрөг Дангаар үр дүнд хүрэхгүй
2	Хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх (5.1.2)	Зорилгыг бүрэн хангахгүй ч байгууллага, иргэдийн идэвх, хяналт тодорхой хэмжээнд нэмэгдэх магадлалтай.	Зардал гарахгүй эсхүл зардал тодорхой хэмжээнд гарна. Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаврыг бүрэн бууруулж чадахгүй.	Үр дүн сөрөг Дангаар үр дүнд хүрэхгүй
3	Зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх (5.1.3)	Зорилгод хүрэх боломжгүй	Зардал гарахгүй эсхүл зардал тодорхой хэмжээнд гарна. Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаврыг бүрэн бууруулж чадахгүй.	Үр дүн сөрөг Дангаар үр дүнд хүрэхгүй
4	Төрөөс санхүүгийн интервенц хийх (5.1.4)	Зорилгод хүрэх боломжгүй	Зардал гарахгүй эсхүл зардал тодорхой хэмжээнд гарна. Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаврыг бүрэн бууруулж чадахгүй.	Үр дүн сөрөг Дангаар үр дүнд хүрэхгүй
5	Төрийн бус байгууллага, хувийн хэвслээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх (5.1.5)	Зорилгод хүрэх боломжгүй	Зардал гарахгүй эсхүл зардал тодорхой хэмжээнд гарна. Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаврыг бүрэн бууруулж чадахгүй.	Үр дүн сөрөг Дангаар үр дүнд хүрэхгүй

Тандан судалгааны аргачлалд заасан хувилбар		Зорилгод хүрэх байдал	Зардал, өгөөжийн харьцаа	Үр дүн
6	Захиргааны шийдвэр гаргах (5.1.6)	Зорилгод хүрэх боломжгүй	Зардал гарахгүй эсхүл зардал тодорхой хэмжээнд гарна. Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаврыг бүрэн бууруулж чадахгүй.	Үр дүн сөрөг Дангаар үр дүнд хүрэхгүй
7	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах (5.1.7)	Зорилгыг бүрэн хангана Хамгийн оновчтой хувилбар мөн Хамгийн үр дүнтэй хувилбар мөн	Тодорхой хэмжээний зардал гарах боловч энэ хувилбар нь асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг шийдвэрлэхэд чухал нөлөө үзүүлнэ. Зардал гарах боловч энэ хувилбар нь асуудлыг шийдвэрлэхэд оновчтой хувилбар.	Үр дүн эерэг Үр дүнтэй

Дээрх хүснэгтэд үзүүлсэнчлэн, тандан судалгааны тайланд зохицуулалтын хувилбарыг сонгосон шалтгаанаа хангалттай тайлбарлахгүй байх явдал нийтлэг байна.

Тодруулбал, хувилбар тус бүрийн үр нөлөө, зорилгод хүрэх байдал, зардал, үр өгөөжийг бодитойгоор харьцуулан үнэлж харьцуулах бус шууд “хууль тогтоомжийн төсөл боловсруулах” хувилбарыг шууд сонгоход чиглэсэн тайлбарыг эхнээс нь хийх хандлагатай байна. Тухайлбал, 2023 оны 07 сарын 07-ны өдөр батлагдсан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн тандан судалгаагаар “хууль тогтоомжийн төсөл боловсруулах” хувилбарыг сонгон үүнийхээ үндэслэлийг “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн хуулийн төслийг шинэчлэн боловсруулах замаар тулгарч байгаа асуудлыг шийдвэрлэх, тавьсан зорилго, зорилтыг хэрэгжүүлэх боломжтой” хэмээн ерөнхийлөн тайлбарлажээ. Энэ нь зохицуулалтын хувилбар сонгоход зардал, үр өгөөжийн харьцааг зайлшгүй харгалзан үзэх шаардлагад нийцэхгүй юм.

Өөр нийтлэг ажиглагдсан жишиг нь (i) зарим судалгаанд аргачлалд заасны дагуу “хууль тогтоомжийн төсөл боловсруулах” хувилбарыг бусад хувилбартай харьцуулахгүйгээр шууд сонгосон, (ii) аргачлалд заасан долоон хувилбарыг харьцуулсан байх боловч Хүснэгт 4-д үзүүлсэнчлэн хэт ерөнхий дүгнэлт хийх,

(iii) “хууль тогтоомжийн төсөл боловсруулах” хувилбарыг хамгийн үр дүнтэй гэж үзсэн байх боловч энэхүү сонгон авсан хувилбарт тулгуурласан өөр сонголтуудыг тандан судалгааны тайлан боловсруулагч өөрөө санал болгож, судалсан зэрэг тохиолдлууд байна. Тухайлбал, 2021 оны 10 сарын 29-ний өдөр батлагдсан Таримал ургамлын үр, сортын тухай хуулийн тандан судалгаанд хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбарыг “үр дүнтэй гэж үзэж байна” хэмээн сонгоод, зохицуулалтын дараах хувилбаруудыг дэвшүүлжээ. Үүнд:

- Таримал ургамлын үр, сортын одоогийн зохицуулалт, харилцааг хэвээр үлдээж, сорт сорилтын төвийг нэмж байгуулан тэнд ажиллагсдын нийгэм, эдийн засгийн баталгааг хангах;
- Эдийн засгийн үр ашигтай, хөрсний үржил шимд ээлтэй таримал, сортыг нутагшуулан бүс нутгийн хөрс, цаг уурын онцлогт тохирсон ирээдүйтэй, баталгаажсан таримал ургамлын сортын үрийн хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлийн үрээр ханган, үр, сортын тогтолцоог сэргээн хөгжүүлэх;
- Таримал ургамлын үр, сорттой холбогдсон харилцаа, таримал ургамлын шинэ сортыг хамгаалах, үр үйлдвэрлэх талаарх олон улсын хэм хэмжээний зарчим, сайн туршлагад нийцүүлэн өөрийн орны онцлогийг харгалзан тодорхойлсон эрх зүйн орчин бүрдүүлэх.

Тус судалгааг цааш үргэлжлүүлэхдээ дээрх хувилбаруудын (i) зорилгод хүрэх байдал, (ii) зардал-үр өгөөжийн харьцааг харьцуулан үнэлсний дүнд гурав дахь хувилбарыг сонгожээ.

Мөн 2023 оны 07 сарын 07-ны өдөр батлагдсан Техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын тандан судалгааны тайланд аргачлалд заасан зохицуулалтын долоон хувилбарыг харьцуулан үзэлгүй (i) Захиргааны шийдвэр гаргах, (ii) Хууль тогтоомжийн төсөл боловсруулах гэсэн хувилбаруудыг шууд сонгож, энэхүү хоёр хувилбараа судалгааны хүрээнд тодорхойлсон “зорилго” бүрээр үнэлжээ.

Хүснэгт 6. Техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын тандан судалгаанд асуудлыг шийдвэрлэх хувилбаруудыг харьцуулан дүгнэсэн байдал

Асуудлыг шийдвэрлэх зорилго	Захиргааны шийдвэр гаргах	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах
Мэргэшлийн үндэсний шаталсан бүтэц, тогтолцоог бүрдүүлж, төлөвшүүлэх	Мэргэшлийн үндэсний шаталсан бүтэц, тогтолцоо нь иргэдийн насан туршдаа, тасралтгүй сурч хөгжих боломжийг боловсрол болон хөдөлмөрийн бодлогоор дэмжих, иргэдийн олон улсад сурч боловсрох, хөдөлмөр эрхлэх эрх зүйн орчныг бий болгоно. Энэхүү харилцааг захиргааны актаар зохицуулах боломжгүй тул хуулийн тусгайлан бүлэг, зүйл заалтаар зохицуулах, хариуцах байгууллага байгуулах шаардлагатай.	Мэргэшлийн үндэсний шаталсан бүтэц, тогтолцоог бүрдүүлэх, төлөвшүүлэх асуудлыг хуулийн төсөл боловсруулах замаар шийдвэрлэх нь иргэдийн сурч хөгжих, хөдөлмөр эрхлэх зохистой бодлого, үйл ажиллагааг үр дүнтэй болгох боломж олгоно. Олон улсын хэмжээнд энэхүү асуудлыг хуулиар зохицуулж байгаа.

Мөн долоон хувилбарыг бүгдийг нь судалгааны хүрээнд тодорхойлсон асуудал тус бүрээр харьцуулсан тохиолдол ч байна. Тухайлбал, 2021 оны 12 сарын 17-ны өдөр батлагдсан Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн тандан судалгаанд зургаан асуудлыг тодорхойлж, дээрх долоон хувилбарыг асуудал тус бүрээр үнэлэн харьцуулж, бүх тохиолдолд “хууль тогтоомжийн төсөл боловсруулах” хувилбарыг үр дүнтэй гэж дүгнэсэн байна.

Дээрхийг нэгтгэн дүгнэвэл, тандан судалгааг гүйцэтгэж буй этгээдүүд судалгааны гурав дахь үе шат буюу “тухайн асуудлыг зохицуулах хувилбаруудыг тогтоож, тэдгээрийн эерэг болон сөрөг талыг харьцуулан судлах” шатны арга зүйг харилцан адилгүй байдлаар ойлгон хэрэглэж буй нь харагдаж байна.

Зардал, үр өгөөжийн харьцааг дүгнэж буй байдал (III үе шат дотор)

Тандан судалгааны аргачлалын 5.8-д сонгон авсан хувилбарыг хэрэгжүүлэхэд гарах зардлыг “зардал их/бага гарна” эсхүл “зардал гарахгүй” гэж тодорхойлохоор заасны дагуу 43 тайлан буюу нийт тайлангийн 78 хувьд зардал, үр өгөөжтэй холбоотой ямар нэг дүгнэлт хийсэн боловч эдгээрийн 30 нь аргачлалыг баримтлаагүй байна.

Тандан судалгааны аргачлалын 5.6-д зааснаар зохицуулалтын хувилбаруудын эерэг болон сөрөг талыг харьцуулахдаа “зардал, үр өгөөжийн харьцаа”-г нэг гол шалгуур болгоно. Мөн аргачлалын 5.8-д зааснаар зардал, үр өгөөжийн

харьцаа гэх шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлэхтэй холбогдон улсын төсөв, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс гарах зардал, үүсэж болзошгүй нэмэлт ачааллыг тандан судална. Улмаар зардлын хэмжээг:

- (i) зардал их,
- (ii) зардал бага,
- (iii) зардал гарахгүй гэх зэрэг ерөнхий байдлаар дүгнэх ёстой.

Учир нь тандан судалгааг хуулийн төсөл боловсруулахаас өмнө хийх тул зардлын тооцоо нь харьцангуй хийсвэр шинжтэй буюу зардал, үр өгөөжийн харьцааг урьдчилсан байдлаар тодорхойлдог. Харин илүү нарийн зардлын тооцоог хуулийн төсөл боловсруулсны дараа хийнэ.

Тандан судалгааны хүрээнд хийх зардлын тооцоо нь хэдийгээр хийсвэр шинжтэй, урьдчилсан тооцоолол боловч үндэслэл бүхий бодитой байх учиртай. Гэвч дийлэнх тохиолдолд “тодорхой зардал гарах боловч үр өгөөж нь зорилгод хүрэхүйц байна” эсхүл “зардал тодорхой хэмжээнд гарна” гэсэн ерөнхий дүгнэлтийг шууд хийдэг байна. Энэ нь зардлыг хэрхэн тооцоолж, их, бага хэмээн дүгнэх шалгуур тодорхойгүй байгаатай холбоотой.

Хүснэгт 7. Тандан судалгаанд зардлыг тооцсон байдал

№	Хуулийн нэр	Тандан судалгааны тайланд дурдсан дүгнэлт	Аргачлалын дагуу дүгнэлт хийсэн эсэх
1	2022 оны 12 сарын 23-ны өдөр батлагдсан Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль	Гарах зардлын хувьд төсвөөс эхний ээлжид зардал гарна. Уул уурхайн бүтээгдэхүүний бирж нь төрийн өмчит компани байх тул Уул уурхайн бүтээгдэхүүний биржийг олон улсын жишигт нийцүүлэн барихад шаардлагатай тодорхой хэмжээний зардал гарна.	Зардал нь их эсхүл бага болох тал дээр ямар нэг дүгнэлт хийгээгүй.
2	2021 оны 05 сарын 29-ний өдөр батлагдсан Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль	Улсын төсөвт нэмэлт зардал гарахгүй тул зардал гарахгүй.	Зөвхөн улсын төсвөөс гарах зардал дс уурил ан дүгнэсэн.
3	2021 оны 01 сарын 29-ний өдөр батлагдсан Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай хууль	Зардал, үр өгөөж, тэдгээрийн харьцааг бодитой тооцолгүй, зөвхөн хуулийн төсөл боловсруулахад гарах зардлыг тооцоолсон.	

Иймд тандан судалгааны хүрээнд зардал, үр өгөөжийн харьцааг тооцоолж төсөөлөл гаргах, их, бага гэх мэт дүгнэлт хийхэд баримтлах шалгуурыг тодорхой болгох шаардлагатай байна.

Хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбарыг шууд сонгох тохиолдлууд (III үе шат дотор)

ХТХ болон тандан судалгааны аргачлалын дагуу хуулийн төсөл боловсруулах хувилбарыг сонгож болох ч ийнхүү сонгосон үндэслэлдээ тайлбар, дүгнэлт хийхгүй байна.

Тандан судалгааны аргачлалын 5.4-т хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбарыг шууд сонгох дөрвөн нөхцөлийг заасан байдаг. Судалгаанд хамрагдсан тохиолдлуудаас дээрх нөхцөлөөр боловсруулагдсан 11 хууль байгаагийн гурав нь анхдагч хууль, тав нь шинэчилсэн найруулга, гурав нь хуульд өөрчлөлт оруулах тухай хууль байв.

Хуулийн төсөл боловсруулах хувилбарыг шууд сонгосон тохиолдолд үндэслэлийг тайлбарлах учиртай. Харин дээрх 11 тайлангийн зөвхөн гуравт яагаад хуулийн төсөл боловсруулах хувилбарыг шууд сонгосон тухай дурдсан байв.

Хүснэгт 8. Хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбарыг шууд сонгосон үндэслэл

№	Хуулийн төслийн нэр	Тандан судалгаандаа дурдсан үндэслэлүүд
1	2021 оны 12 сарын 17-ны өдөр батлагдсан Нийтийн мэдээллийн илтөд байдлын тухай хууль	Тус хуулиар хүний мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг зохицуулж буйн хувьд аргачлалын 5.4.1-д заасан “тухайн асуудал нь хүний салшгүй эрхэд буюу Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуульд заасан хүний эрхийг хязгаарлах бол хууль тогтоомжийн төсөл боловсруулна” гэсэн нөхцөлийг баримталжээ. Тус судалгаанд аргачлалд тусгасан долоон шийдэл тус бүрийг харьцуулсны үндсэн дээр хууль тогтоомжийн төсөл боловсруулах шийдлийг сонгосон. Гэхдээ энэ тохиолдолд аргачлалын 5.4.1-д заасан нөхцөл бүрдсэн тул бусад хувилбарыг заавал үнэлж харьцуулах шаардлагагүй байв.
2	2021 оны 12 сарын 17-ны өдөр батлагдсан Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль	Тус хуулийн хувьд дээрхийн адил “хууль тогтоомжийн төсөл шууд боловсруулах” хувилбарыг шууд сонгох боломжтой ч энэ талаар тайланд дурдаагүй, ямар нэг дүгнэлт өгөөгүй. Тодруулбал, тус хууль нь хүний халдашгүй байх эрх буюу хүний хувийн мэдээллийг бусад этгээд цуглуулах, боловсруулах, дамжуулах харилцааг зохицуулж буйн хувьд аргачлалын 5.4.1-т заасанчлан тухайн асуудал нь хүний салшгүй эрх буюу Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуульд заасан хүний эрхтэй шууд холбоотой харилцааг зохицуулж байна.

№	Хуулийн төслийн нэр	Тандан судалгаандаа дурдсан үндэслэлүүд
3	2024 оны 01 сарын 17-ны өдөр батлагдсан Хүүхэд хамгааллын тухай хууль	Тус хуулиар зохицуулах харилцаа нь хүүхдийн эрх, гэр бүлийн ашиг сонирхол зэрэг хүний эрхтэй салшгүй холбоотойн хувьд аргачлалын 5.4.1-т заасны дагуу хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбарыг шууд сонгох боломжтой байх боловч мөн л тайланд энэ талаар дурдаагүй.

Мөн нэмэлт, өөрчлөлт оруулах гурван хууль нь бүгд татварын харилцаатай холбоотой байв. Үүнээс нэг нь бусад хувилбартай харьцуулахгүйгээр шууд хуулийн төсөл боловсруулах хувилбарыг сонгосон бол үлдсэн хоёр нь хуулийн төсөл боловсруулах хувилбарыг “тэг” хувилбартай харьцуулж, үр дүнтэй хэмээн үзжээ.

Дээрхээс үзвэл, дийлэнх тохиолдолд тухайн хуулиар зохицуулах гэж буй асуудал нь яагаад шууд хуулийн төсөл шууд боловсруулах асуудал болохыг тайлбарлахгүй байгаа бөгөөд ямар нэг тайлбар дүгнэлт хийсэн ч тэр нь хэт ерөнхий, ач холбогдол багатай байна.

IV үе шат: Сонгон авсан хувилбарын үр нөлөөг үнэлж буй байдал

Хууль тогтоомжийн тандан судалгааны тайланд сонгон авсан зохицуулалтын хувилбарын үр нөлөө үнэлэх ажил хэлбэрийн төдий хийгдэж байна.

Сонгон авсан зохицуулалтын тодорхой хувилбарыг нарийвчлан судалж, үр нөлөөг урьдчилан тооцоолох нь тандан судалгааны аргачлалын нэг гол шаардлага юм. Энэ хүрээнд судалгааны өмнөх шатанд сонгосон зохицуулалтын хувилбар тус бүрийн үр нөлөөг IV үе шатанд заавал тооцож, харьцуулан үнэлнэ. Тодруулбал, IV шатанд сонгосон хувилбаруудыг дахин нэг удаа харьцуулж шалгана гэсэн үг юм.

Гэвч судалгаанд хамрагдсан бүх тайлангийн хэмжээнд “хууль тогтоомжийн төсөл боловсруулах”-аас бусад хувилбарын үр нөлөөг нь үнэлж, хооронд нь харьцуулан дүгнэсэн тохиолдол байхгүй байна. Үүнээс сонгон авсан зохицуулалтын хувилбарын үр нөлөөг үнэлэх ажиллагааг зөвхөн “хууль тогтоомжийн төсөл боловсруулах” хувилбарын хувьд хийдэг жишиг тогтсон гэж дүгнэж болохоор байна.

Тандан судалгааны аргачлалд заасны дагуу сонгон авсан хувилбарын үр нөлөөг хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчин гэсэн дөрвөн үндсэн чиглэлээр үнэлнэ. Ингэхдээ хүний эрхийн нөлөөллийг 17, эдийн засаг болон нийгмийн нөлөөллийг тус бүр 32, байгаль орчны 19 шалгуураар үнэлнэ.

Харин практикт үр нөлөөний үнэлгээг хэлбэр төдий гүйцэтгэх явдал нийтлэг байна. Нэн ялангуяа, анхдагч хууль болон шинэчилсэн найруулгын төслийн тандан судалгааны тайлангийн эхлэл хэсэгт захиргааны байгууллагын эрх хэмжээг тэлэх, шинэ чиг үүрэг бий болгох тухай дурдсан байх боловч үр нөлөөг үнэлэх шатыг дутуу дулимаг гүйцэтгэж, дэлгэрүүлэн тайлбарлахгүй орхиж байна. Тухайлбал, 2021 оны 10 сарын 29-ний өдөр батлагдсан Таримал ургамлын үр, сортын тухай хуулийн тандан судалгааны зөвлөмж хэсэгт "Сортын баталгаажуулалтын зөвлөл ажиллана, мөн тус зөвлөл нь таримал ургамлын шинэ сортыг баталгаажуулах чиг үүрэгтэй байхаас гадна, шинэ сортын бүртгэл хөтлөх, мэдээ, тайлан гаргах, үрийн хангамж, хүрэлцээг тооцоолох, импортлох, экспортлох үрийн тоо хэмжээг тогтоох, арга зүйн сургалт явуулж, гэрчилгээ олгох, сунгах, хүчингүй болгох үүрэг бүхий Үр, сортын асуудал эрхэлсэн ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг буюу Үр, сортын агентлаг ажиллахаар хуульчилна" гэж тусгажээ. Ийнхүү захиргааны байгууллагад шинэ чиг үүрэг бий болгох атал Эдийн засагт үзүүлэх үр нөлөөний 9.3-д заасан "Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх" асуултад "Үгүй" гэж хариулжээ.

Түүнчлэн 2022 оны 04 сарын 22-ны өдөр батлагдсан Эрдэнэсийн сангийн тухай хуулийн тандан судалгааны зөвлөмж хэсэгт "Эрдэнэсийн сангийн үндсэн санг арвижуулах, соёлын өвийн бүртгэл, түүний дагалдах хэрэглэгдэхүүний бүрдлийг Соёлын өвийн тухай хуульд заасны дагуу бүрдүүлэх, энэ санд байгаа эд зүйлийн талаар ном, хэвлэлд нийтлүүлэх, соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сантай мэдээлэл солилцох, энэ санд бусдын өмчлөлд буй эрдэнэсийг бүртгэх болон гүйлгээ санг арвижуулах, гадаадад цэвэршүүлэх, байршуулах, валютын нөөцийг нэмэгдүүлэх"-тэй холбоотой чиг үүргийг Монгол банканд оногдуулах, "ЗГ-аас Эрдэнэсийн сангийн тайлантай танилцах, түүнд санал өгөх, үндсэн санд нэмж оруулах эрдэнэсийн талаар Монгол банканд санал гаргах харилцааг шинээр тусгах" тухай тус тус дурдсан байна. Гэсэн хэдий ч "Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх" асуулгад мөн л "Үгүй. Тийм зохицуулалт байхгүй" гэж хариулсан нь үр нөлөөний үнэлгээ зохих ёсоор хийгдээгүйг харуулж байна.

Үүнээс гадна аргачлалын 6.3-т "асуултуудад аль болох ерөнхий байдлаар тийм, үгүй" гэж хариулна", мөн 6.4-т "Энэхүү аргачлалын 6.2-т заасан асуултуудад

сөрөг байдлаар хариулах буюу сөрөг үр нөлөө үзүүлэх бол “Тайлбар” хэсэгт энэ талаарх үндэслэл, шалтгааныг тодорхой бичнэ” гэж заасан байдаг. Гэвч үүний дагуу сөрөг нөлөөг бодитой үнэлж, тайлбар, нотолгоо өгөх байдал маш хангалтгүй байна. Тухайлбал, 2024 оны 01 сарын 17-ны өдөр батлагдсан Хүүхэд хамгааллын тухай хуулийн тандан судалгаагаар хууль тогтоомжийн төсөл боловсруулах зохицуулалтын хувилбарыг сонгосон байх бөгөөд тус хувилбарын “Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө”-г үнэлэхдээ “Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх”, “Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарласан тохиолдолд энэ нь хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн эсэх” гэсэн асуултуудад “Тийм” гэж хариулсан байв. Тэрчлэн “Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх” асуултад “Тийм” гэж хариулсан байх боловч ямар нэгэн тайлбар хийгээгүйн улмаас хүний ямар эрхийг, яг ямар хэмжээнд, хэрхэн хязгаарлах, тэр нь яагаад зайлшгүй болох нь тодорхойгүй үлджээ. Зүй нь боловсруулах гэж буй хууль тогтоомжийн төслөөс хүний эрхэд үзүүлэх үр нөлөөг судлахдаа аль болох “бодитой” хандах учиртай. Хүний эрхийг хязгаарлаж магадгүй гэх ерөнхий таамаглалд тулгуурлан дээрх асуулгад “Тийм” гэж хариулах нь алсдаа хүний эрхийг зүй бусаар хязгаарлах, цаашлаад Үндсэн хуулийн зөрчил бий болгохыг ч үгүйсгэхгүй.

Иймд цаашид хууль тогтоомжийн төслийн хүний эрхийн нөлөөллийг үнэлэхдээ “Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх” гэх зэрэг асуулгад “Тийм” гэж хариулсан тохиолдолд үндэслэлийг заавал дэлгэрүүлэн тайлбарлах, ийнхүү тайлбарласан эсэхийг судалгааны захиалагч буюу хууль санаачлагч зайлшгүй шалгаж, хуулийн төсөл боловсруулахад харгалзан үзэж хэвших нь зүйтэй. Ингэхдээ, аль эрхийг, ямар үндэслэлээр, хэр хэмжээнд хэрхэн хязгаарлахыг дэлгэрэнгүй тайлбарлах шаардлагатай.

Хууль тогтоомжийн төслийн хэрэгцээ, шаардлагын тандан судалгааны хүрээнд хийгдэх хүний эрхийн нөлөөллийн үнэлгээнд анхаарах асуудлыг “Хууль тогтоомжийн тухай хуулийн хэрэгжилт: Хүний эрхийн нөлөөллийн үнэлгээ” сэдэвт бодлогын шинжилгээний тайлангаас авч үзнэ үү³⁷.

³⁷ Хүний эрхийг хамгаалах залуу хуульчдын клуб ТББ, “Хууль тогтоомжийн тухай хуулийн хэрэгжилт: Хүний эрхийн нөлөөллийн үнэлгээ”, Нээлттэй нийгэм форум, Бодлогын асуудал цуврал №51 (2025) <https://forum.mn/product/531311>

VI үе шат: Бусад орны эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судалж буй байдал

Эрх зүйн харьцуулсан судалгаа хийж байгаа боловч үр дүн нь тандан судалгааны зөвлөмж болон хуулийн төсөлд тусгалаа олох нь ховор байна.

Шинэ хууль боловсруулах тохиолдолд бусад улс орны ижил төстэй туршлагыг судлах нь чухал. Ингэхдээ харьцуулсан судалгаанд хамруулах улс орныг тухайн улсын нийгэм, эдийн засаг, улс төрийн нөхцөл, өөрийн орны онцлог, бодит нөхцөл байдлыг харгалзан сонгох учиртай. Эдгээрийг үл харгалзан аль нэг гадаад улсын аливаа нэг загварыг шууд хуулбарлах нь хууль зүйн хувьд оновчгүй шийдэлд хүргэх эрсдэлтэй.³⁸

Тандан судалгааны аргачлалын 8.1-т “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбар сонгогдсон тохиолдолд тухайн зохицуулалтын талаарх олон улсын эрх зүйн холбогдох зохицуулалт, бусад улсын адил төстэй хууль тогтоомжийн харьцуулсан судалгааг хийнэ” гэж заасан байдаг. Үүний дагуу судалгааны энэ хэсэгт хамрагдсан нийт 55 судалгааны бараг 80 орчим хувьд харьцуулсан судалгаа хийгдсэн байна. Ингэхдээ дунджаар 4-6 улсын эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судалсан байх ба арваас дээш улсыг харьцуулан шинжилсэн тохиолдол ч байна. Харьцуулсан судалгааны хүрээнд Солонгос, Япон, Хятад, АНУ болон Герман Улсыг сонгон судлах нь түгээмэл байна.

Гэвч эдгээр харьцуулсан судалгааны үр дүнд суурилан хуулийн төсөлд тусгах тодорхой санал зөвлөмж өгөх байдал хангалтгүй. Тухайлбал, 2021 оны 12 сарын 17-ны өдөр батлагдсан Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн тандан судалгаанд холбогдох олон улсын байгууллагуудын стандарт, зөвлөмж болон Австрали, Малайз, ИБУИНВУ, Сингапур Улсын виртуал хөрөнгийн эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан судалсан ч хуулийн төсөлд тусгах тодорхой санал, зөвлөмж өгөөгүй, харин “өөрийн улсын онцлог байдалд нийцүүлэн, бүс нутгийн онцлог байдлыг харгалзан виртуал хөрөнгө, түүнд тавигдах шаардлага болон виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчид тавих шаардлага, тэдгээрийн үйл ажиллагааг хянан зохицуулах этгээд, холбогдох дэд бүтцийг бий болгох зэргийг тодорхойлон зохицуулах” гэсэн ерөнхий зөвлөмж өгчээ.

Нөгөө талаар харьцуулсан судалгааны дүгнэлт, зөвлөмжийг хуулийн төсөлд тусгах байдал мөн хангалтгүй байна. Жишээ нь, 2022 оны 11 сарын 04-ний өдөр батлагдсан Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн

³⁸ EUMAJIS p.15. last accessed on 30 March 2025.

тандан судалгаанд БНСУ, Сингапур, АНУ, Швед болон Тайланд улсуудыг харьцуулан судлаад “барьцаалан зээлдэх үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлд заасан байршил, газраас өөр байршил, газарт эрхлэхийг зөвшөөрөхгүй байх, үйл ажиллагаа эрхлэх этгээдэд тавигдах шаардлага, зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичиг, зөвшөөрлийн хугацаа, зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох үндэслэлийг нарийвчлан зохицуулах болон ломбардаас олгох зээлийн хүүгийн хэмжээнд хязгаар тогтоох” зэрэг зөвлөмж өгсөн боловч хуульд тусгаагүй байна.

Нэгтгэн дүгнэвэл, тандан судалгааны хүрээнд харьцуулсан судалгаа хийж буй нь сайшаалтай боловч судалгааны үр дүнд нарийвчилсан тодорхой зөвлөмж боловсруулах, түүнийг нь хуулийн төсөлд харгалзан үзэж тусгах явдал хангалтгүй байна.

Харин харьцуулсан судалгаа хийгээгүй 11 тайлан байх ба эдгээрийн 7 нь хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл байв (Дэлгэрэнгүйг Хавсралт 6-аас үзнэ үү.). Дээрх 11 хуулийн төслийн тандан судалгааны тайланд харьцуулсан судалгаа гүйцэтгээгүй үндэслэлээ дурдаагүй байна. Гэхдээ эдгээр хууль нь бүгд төсөв, санхүү, татвар зэрэг зөвхөн манай улсын онцлог байдал, бодлоготой холбоотой, нэг удаагийн шинжтэй харилцааг зохицуулж байгааг дурдах нь зүйтэй.

VII үе шат: Зөвлөмж боловсруулж буй байдал

Дийлэнх тандан судалгааны тайланд хуулийн төсөл боловсруулах нь зүйтэй гэсэн ерөнхий зөвлөмж өгсөн байх боловч хуулийн төсөлд тусгах тодорхой зохицуулалтыг санал болгосон, түүнийг нь төсөлд тусгасан байдал хангалтгүй.

Тандан судалгаа нь зөвлөмж боловсруулснаар дуусгавар болно. Зөвлөмж нь судалгааны өмнөх үе шатны үр дүнд үндэслэсэн, зохицуулах шаардлагатай асуудлыг шийдвэрлэх хамгийн үр дүнтэй хувилбарыг санал болгосон байх учиртай. Гэвч дээр дурдсанчлан дийлэнх тохиолдолд нэг л хувилбарыг сонгон судалсан байх тул “хуулийн төсөл боловсруулах” гэсэн зөвлөмж өгөх нь нийтлэг байна.

Хуулийн төслийн агуулгатай холбоотой нарийвчилсан зөвлөмж өгсөн (Дэлгэрэнгүй жишээг Хавсралт 7-оос үзнэ үү.) тохиолдол цөөн буюу 55 тандан судалгааны тайлангийн 40 орчим хувийг эзэлж байна. Тэрчлэн харьцуулсан судалгааны зөвлөмжийг хуулийн төсөл боловсруулахад харгалзан үзэж тусгах байдал төдийлөн хангалтгүй байна.

Зарим судалгааны дүгнэлт ойлгомжгүй, агуулга нь тодорхойгүй байна. Тухайлбал, “Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомж, хүний эрх, нийгэм, эдийн засаг, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөө нь байж болох хэмжээнээс хэтрэхгүй болно”³⁹ гэх мэт дүгнэлт хийсэн тохиолдол ч байв.

Судлаачийн хувьд ирүүлсэн ажлын саналын дагуу тандан судалгааг хараат бусаар, бие даан гүйцэтгэдэг. Гэвч энэ явцад зарим хууль санаачлагчдын зүгээс судлагдсан асуудал, зөвлөмжөөс гадуур өөрсдийн саналыг судалгаанд тусгуулах, зөвлөмжийг тодорхой асуудал руу урьдчилан чиглүүлэх, захиалахыг оролдох тохиолдол гардаг.

Хараат бус судлаачийн байр суурь

Хуулийн төслийн ерөнхий бүтэц, агуулгыг томьёолж буй байдал

Хуулийн төслийн ерөнхий бүтэц, агуулгыг томьёолох ажил нь тандан судалгааны III үе шатанд хамаарах боловч бодит байдал дээр судалгааны сүүлийн шатанд зөвлөмж боловсруулсны дараа хийх эсхүл зөвлөмж хэсэгт тусгах нь түгээмэл байна. Тэрчлэн тандан судалгааны аргачлалын дагуу хуулийн төслийг ерөнхий байдлаар боловсруулан томьёолж буй байдал хангалтгүй.

Тандан судалгааны аргачлалын 5.5-д заасан “асуудалд дүн шинжилгээ хийж, зохицуулалтын хувилбаруудыг сонгож тандан судлах явцад тухайн асуудлыг зөвхөн хууль гаргах замаар шийдвэрлэнэ гэсэн дүгнэлт гарсан тохиолдолд хууль тогтоомжийн төслийн бүтэц, агуулга, нэмэлт, өөрчлөлт оруулах, шинээр боловсруулах шаардлагатай хууль тогтоомжийг ерөнхий байдлаар томьёолж бичнэ” гэх шаардлагын хэрэгжилт хангалтгүй байна. Тодруулбал, дээрх заалтын дагуу хууль гаргах хувилбарыг сонгосон 24 тайлан байв. Үүний 16 нь хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн судалгаа байсан ба эдгээр тайланд хуулийн төслийн агуулгыг тодорхой тусгажээ. Харин үүнтэй харьцуулахад анхдагч хууль болон шинэчилсэн найруулга бүхий хуулийн тандан судалгаанд хуулийн төслийн ерөнхий бүтэц, агуулгыг томьёолох байдал хангалтгүй байна.

Хуулийн төслийн ерөнхий бүтцээс гадна, агуулгыг тодорхойлсон байдлыг авч үзвэл, зарим тохиолдолд “аргачлалд заасны дагуу ерөнхий агуулгыг тодорхойлж байна” хэмээгээд хуулийн төслийн зорилгыг томьёолжээ. Тодруулбал, 2021

³⁹ 2021 оны 10 сарын 29-ний өдөр батлагдсан Таримал ургамлын үр, сортын тухай хуулийн тандан судалгааны тайлан.

оны 12 сарын 17-ны өдөр батлагдсан Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн тандан судалгаанд хуулийн зорилгыг “нийтийн мэдээллийн дэд бүтцийг бүрдүүлж, төрийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулж, иргэний мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангаж, төрийн үйл ажиллагаа, үйлчилгээг хүлээн авах, хүртэх нь нээлттэй ил тод, шуурхай болох асуудлыг зохицуулах” хэмээн тодорхойлсон. Мөн 2022 оны 06 сарын 17-ны өдөр батлагдсан Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн тандан судалгаанд хуулийн зорилгыг “хөрөнгийн үнэлгээ хийх эрх зүй, зохион байгуулалтын үндсийг тогтоож, энэ чиглэлээр төрийн болон мэргэжлийн байгууллага, иргэн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, авч хэрэгжүүлэх арга хэмжээ, үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино” хэмээн тодорхойлжээ.

Харин 2023 оны 07 сарын 07-ны өдөр батлагдсан Техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын тандан судалгааны тайланд хуулийн төслийн бүтцийг бүлгээр нь боловсруулсан байв.

- Нийтлэг үндэслэл
- Мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцоо, удирдлага, зохион байгуулалт, харилцаанд оролцогч талуудын эрх, үүрэг
- Мэргэжлийн боловсрол, сургалтын агуулга, стандарт, хөтөлбөр
- Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын үйл ажиллагаа, чанарын баталгаажилт
- Мэргэжлийн боловсрол, сургалтын төсөв, санхүүжилт
- Мэргэжлийн боловсрол, сургалтын нийгмийн түншлэл
- Бусад зүйл

Түүнчлэн 2024 оны 05 сарын 16-ны өдөр батлагдсан Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын тандан судалгаанд хуулийн төслийн бүтцийг нийт 6 бүлэг, 36 зүйлтэй байна хэмээн тодорхойлсон байна.

Тандан судалгааны хэрэгжилт: Хуулийн төрлөөр

- **Анхдагч хууль:**

- Дээр дурдсанчлан анхдагч хуулийн төслийн тандан судалгааны асуудал шийдвэрлэх зорилгыг нарийвчлан тодорхойлох байдал хангалтгүй байв.
- Тандан судалгааны хүрээнд үр нөлөөний үнэлгээг хэлбэр төдий гүйцэтгэх явдал нийтлэг байгаа нь мөн л анхдагч хуулийн төсөлд давамгайлах хандлагатай байна.
- Тандан судалгаагаар хууль тогтоомжийн төсөл боловсруулах шийдэлд хүрсэн бол тухайн хуулийн төслийн ерөнхий агуулга, бүтцийг тодорхойлох ёстой. Энэ шаардлагын хэрэгжилт анхдагч хуулийн судалгаануудад нэлээд хангалтгүй байв.

- Анхдагч хуулийн төсөлд тандан судалгаа хийгээгүй, өөр хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хавсаргасан тохиолдол байна. Тухайлбал, 2022 оны 12 сарын 09-ний өдөр батлагдсан Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль нь анхдагч хууль байх тул ХТТХ-д заасны дагуу тандан судалгаа хийх ёстой байв. Гэтэл Концессын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг бүрдүүлбэрт хавсарган цахим хуудсанд байршуулсан байв.

- **Шинэчилсэн найруулга:**

- Судалгаанд хамрагдсан шинэчилсэн найруулгын 32 төслөөс 17-д тандан судалгаа, 15-д хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийсэн байна.⁴⁰ Ийнхүү нэг төрлийн хуулийн төсөлд өөр өөр судалгаа хийж байгаа нь ямар тохиолдолд аль судалгаа хийх ёстойг хуулиар нарийвчлаагүйтэй холбоотой байна. Тодруулбал, ХТТХ-ийн 13 дугаар зүйлийн 13.3-т анхдагч хууль болон хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуульд зарчмын шинжтэй зохицуулалт шинээр нэмж оруулах төсөл боловсруулахад хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагын тандан судалгаа хийхээр заасан бол, 51 дүгээр зүйлийн 51.1-д хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийг шинэчлэн найруулахад түүний хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийхээр тусгажээ. Түүнчлэн тандан судалгааны аргачлалын 5.4.4-т “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийх аргачлалын дагуу хийсэн үнэлгээнээс тухайн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэсэн зөвлөмж гарсан бол” хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбарыг шууд сонгоно гэжээ. Үүний дагуу шинэчилсэн найруулгын төсөл боловсруулахад гагцхүү хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийнэ гэж ойлгохоор байгаа ч дээр дурдсанчлан тандан судалгаа гүйцэтгэсэн тохиолдол цөөнгүй

⁴⁰ Хууль тогтоомжийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэгт “Үндсэн чиглэлийн төсөлд санал өгөх байгууллага нь хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсны, эсхүл тухайн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсний үндсэн дээр уг асуудлаар анхдагч хууль болон шинэчилсэн найруулга гаргах, эсхүл хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах үндэслэл, шаардлагыг тодорхойлно” гэж заасан нь ЗГ-аас хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэлийг боловсруулахдаа шинэчилсэн найруулгын хувьд тус 2 судалгааны алийг нь ч гүйцэтгэж болох мэт ойлгогдож байна. Мөн хуулийн 13 дугаар зүйлийн 13.3-т анхдагч хуулийн төслөөс гадна хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуульд зарчмын шинжтэй зохицуулалт шинээр нэмж оруулж байгаа хуулийн төслийг боловсруулахад хэрэгцээ, шаардлагын тандан судалгааг гүйцэтгэхээр заасан бол хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1-д хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуульд өөрчлөлт оруулах, шинэчлэн найруулах, багц хуулийн төсөл боловсруулахад түүний хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийх талаар тус тус заасан байна.

байгаа нь энэ талаар хууль хэрэглээний нэг мөр ойлголт тогтоогүй бөгөөд шинэчилсэн найруулгын хувьд уг хоёр судалгааны зааг ялгаа бүдэг байгааг илтгэж байна.

- ХТХ-ийн 13 дугаар зүйлийн 13.3-т заасан “зарчмын шинжтэй” зохицуулалт гэдэгт юуг ойлгох нь тодорхойгүй байна. Үүний улмаас ийм зохицуулалт агуулсан хуулийн төсөл нь нэмэлт, өөрчлөлт эсхүл шинэчилсэн найруулга аль нь байх ёстой нь ойлгомжгүй. Тухайлбал, 2022 оны 06 сарын 17-ны өдөр батлагдсан Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын тандан судалгааны зөвлөмж хэсэгт “Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд холбогдох нэмэлт, өөрчлөлтийг тусгахдаа шинэчилсэн найруулгын төсөл боловсруулж батлах шаардлагатай” гэж тусгажээ. Уг судалгааны эхлэл хэсэгт хууль хэрэгжээд найман жил өнгөрсөн тухай дурдсан боловч хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ бус тандан судалгааг сонгон гүйцэтгэсэн үндэслэлээ дурдаагүй, харин судалгааны дүнд шинэчилсэн найруулга батлах шаардлагатай гэж дүгнэсэн. Ийнхүү хуулийн зохицуулалт тодорхойгүйгээс ямар судалгаа хийхийг хууль санаачлагч өөрийн үзэмжээр сонгоход хүргэж байна. Тус хоёр судалгаа нь хуулийн төслийн суурь судалгаа болохын хувьд агуулгын хувьд давхцах зүйлс бий боловч судалгааны арга зүй, үе шат, асуудлыг тодорхойлж, үнэлэх болон шийдлийн хувилбар тодорхойлох байдал нь ялгаатай гэдгийг анхаарах нь зүйтэй. Иймд цаашид аль тохиолдолд ямар судалгаа хийхийг тодорхой болгож, хууль хэрэгжээд таван жил өнгөрсөн эсэх, эрх ашиг нь хөндөгдөж буй этгээдүүдээс зайлшгүй өөрчлөлт оруулах санал ирсэн эсэх, нийгмийн хэрэгцээ, шаардлага өөрчлөгдсөн эсэх гэх мэт судалгааны төрлийг тодорхойлоход ач холбогдох бүхий шалгуур бий болгох нь зүйтэй.

- **Хуульд өөрчлөлт оруулах тухай хууль:**

- ХТХ-ийн 13 дугаар зүйлийн 13.3-т 2023 оны 05 сарын 04-ний өдөр орсон нэмэлт, өөрчлөлтөөр хуульд зарчмын шинжтэй зохицуулалт шинээр нэмж оруулах тохиолдолд тандан судалгаа хийхээр тусгасан. Судалгаанд хамрагдсан 17 хуулийн (өөрчлөлт оруулах тухай)⁴¹ 11 нь дээрх өөрчлөлтийн дараа батлагдсан байх боловч чухам зарчмын шинжтэй

⁴¹ Хууль тогтоомжийн тухай хуулийн 24.5-д “Хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөл нь дараах төрөлд хуваагдана:

24.5.1.хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;

24.5.2.хуульд нэмэлт оруулах тухай;

24.5.3.хуульд өөрчлөлт оруулах тухай;

24.5.4.хуулийн зүйл, хэсэг, заалтыг хүчингүй болсонд тооцох тухай.”

ямар зохицуулалт тусгаж байгаагаас тандан судалгаа хийх болсныг дурдаагүй байна.

- Иймд ямар судалгаа хийхийг хууль санаачлагч өөрийн үзэмжээр шийдэх хандлага ажиглагдаж байна. Тухайлбал, 2024 оны 04 сарын 12-ны өдөр батлагдсан Хөрөнгө оруулалтын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн тандан судалгааны тайланд “Иргэн Н.Н-ээс “Газрыг гадаадын иргэн 100 жилээр ашиглах, эзэмшихийг цуцлах” сэдэвтэй нийтийн өргөдлийг УИХ-ын цахим системд 2024 оны 01 сарын 22-ны өдөр гаргасан бөгөөд уг өргөдөл 100167 иргэний дэмжлэг авсан” гэсэн байдлаар асуудлыг тодорхойлжээ. Энэ нь хуульд ямар нэг шинэ зохицуулалт нэмж тусгасан хэрэг биш бөгөөд судалгааны тайланд “зарчмын шинжтэй өөрчлөлт” эсхүл “иргэдээс ирүүлсэн хүсэлт”-ийн алинд үндэслэн тандан судалгаа хийсэн болохыг тодорхойлоогүй.
- Мөн хуулийн хэрэгжиж эхлэх болон дуусах хугацаатай холбоотой зохицуулалтад өөрчлөлт оруулахдаа тандан судалгаа гүйцэтгэсэн тохиолдлууд байна. Тухайлбал, 2024 оны 06 сарын 05-ны өдөр батлагдсан Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн тандан судалгааны тайланд “санхүүгийн салбарын тогтвортой байдлын хүрээнд банкны хувь эзэмшлийн төвлөрлийг бууруулах зохицуулалтыг банкны салбарт амжилттай хэрэгжүүлэх зорилгоор холбогдох зохицуулалтын хэрэгжих хугацааг 2 жилээр сунгах шаардлагатай” гэжээ. Уг хуулийг анх батлахын өмнөх суурь судалгааг гүйцэтгэхдээ нөхцөл байдлыг бодитой үнэлээгүйн улмаас давчуу хугацаа тогтоож, улмаар дагаж мөрдөх журмын тухай хуулийн хугацаатай холбоотой хоёр зохицуулалтад 3 жилийн дотор 2 удаа өөрчлөлт оруулжээ.
- Судалгааг нэр төдий гүйцэтгэх буюу асуудалд бодитой дүн шинжилгээ хийхгүй, бүр зарим тохиолдолд тандан судалгаа гүйцэтгэх шаардлагатай байсан ч зарчмын шинжтэй асуудал бус хэмээн үзэж орхигдуулах явдал байна.

Явцын дүгнэлт: Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагын тандан судалгаа

Судалгааны энэхүү хэсэгт хамаарах 97 хуулийн 70-д нь хуулийн төсөл боловсруулахаас өмнөх шатанд хийгдэх суурь судалгааг гүйцэтгэсэн байх ба үүний 55 нь тандан судалгаа байна. Тандан судалгааны аргачлалын хэрэгжилтийг энэ хүрээнд дүгнэвэл:

- Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагын урьдчилсан тандан судалгаанд ЗГ-аас баталсан холбогдох аргачлалыг хэрэглэж хэвшсэн байна. Гэсэн хэдий ч аргачлалд заасан зарим үе шатыг, тодруулбал, зохицуулалтын хувилбаруудыг тогтоож, эерэг, сөрөг талуудыг харьцуулах, сонгосон хувилбарын үр нөлөөг үнэлэх, харьцуулсан судалгаа зэрэг үе шатыг алгасах эсхүл хэлбэрийн төдий гүйцэтгэж, өнгөц дүгнэлт хийх явдал нийтлэг гарсаар байна.
- Тухайн асуудал болон түүнийг шийдвэрлэх зорилгыг ерөнхий томъёолох хандлага түгээмэл бөгөөд эрх, ашиг сонирхол нь хөндөгдөж буй этгээдүүдийг оролцуулж буй байдал хангалтгүй байна. Өөрөөр хэлбэл, асуудлыг тодорхойлоход холбогдох талуудыг бүрэн оролцуулахгүй, харин өмнө хийгдсэн бусад судалгаа, статистик мэдээлэл, хуулийн хэрэгжилтэд тулгуурлан дүгнэж байна.
- Тандан судалгаанд зохицуулалтын хувилбарыг сонгосон үндэслэл, шалтгааныг тодорхой тайлбарлахгүй, тойм төдий товч дүгнэлт хийх жишиг тогтжээ. Үүний улмаас дийлэнх тохиолдолд хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбарыг “хамгийн үр дүнтэй” хэмээн сонгож, “хууль тогтоомжийн төсөл боловсруулах шаардлагатай” гэх ерөнхий зөвлөмж өгч байна.
- Тандан судалгааны тайланд зардал, үр өгөөжийн харьцааны ерөнхий төсөөллийг гаргах ёстой боловч дүгнэлтийг аргачлалд заасан агуулгаар хийхгүй байна. Энэ нь нөгөө талаар дүгнэлт гаргахад баримтлах шалгуур тодорхой бус байгаатай холбоотой.
- Сонгосон хувилбар тус бүрийн үр нөлөөг үнэлэх ёстой атал зөвхөн хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбарын үр нөлөөг үнэлэх нь нийтлэг бөгөөд үүнээс өөр хувилбарын үр нөлөөг үнэлж, хооронд нь харьцуулсан тохиолдол алга байна. Мөн тус үнэлгээндээ үндэслэл бүхий дүгнэлт, тайлбарыг хангалттай хийхгүй, нэгэнт тогтсон товч хариултыг өгөх жишиг тогтжээ.
- Дийлэнх тохиолдолд тандан судалгааны хүрээнд харьцуулсан судалгаа хийсэн байх боловч үр дүнд нь тулгуурлан нарийн тодорхой зөвлөмж боловсруулах, түүнийг нь хуулийн төсөлд харгалзан үзэж тусгах байдал хангалтгүй.
- Тандан судалгааг хуульд өөрчлөлт оруулах тухай болон шинэчилсэн найруулгын төсөлд аль алинд нь хийж байна. Энэ нь ямар тохиолдолд уг судалгааг хийх нь ойлгомжгүй байгаатай холбоотой.

2.2. Хуулийн төсөлд зардлын тооцоо хийсэн байдал

Зардал, үр өгөөжийн шинжилгээ (Cost-benefit analysis - CBA) нь шийдвэр гаргах үйл явцад түгээмэл хэрэглэгддэг бөгөөд тухайн шийдвэрийн дүнд бий болох үр ашгийг гарах зардалтай нь харьцуулан дүгнэх арга юм. Энэ нь хэдийгээр үр ашиг болон зардлыг тооцож, хооронд нь харьцуулах энгийн арга мэт боловч алхам бүрийг зөв тооцож хийгээгүй тохиолдолд алдаатай, дутуу дүгнэлтэд хөтлөх эрсдэлтэй. Зардал, үр өгөөжийн шинжилгээг бизнесийн салбарт түлхүү ашиглах бөгөөд дараах алхмаар хийдэг. Үүнд:

1. Зардал, үр өгөөжийн шинжилгээний хүрээг тодорхойлох - Энэ хүрээнд зардал, үр өгөөжийн шинжилгээ хийх зорилгыг тодорхойлж, хоорондын харьцааг тооцох хэмжигдэхүүнийг тодорхойлно;
2. Зардал, үр өгөөжид хамруулах зүйлсийг тодорхойлох - Шууд болон шууд бус, биет болон биет бус, боломж болон алдагдсан боломжийн өртөг зэрэг тооцоололд хамруулах үзүүлэлтийн жагсаалтыг гаргана;
3. Зардал, үр өгөөж тус бүрийг эрэмбэлэх буюу үнэлгээ тогтоох — Тухайн асуудлаас шалтгаалан зарим үр өгөөж нь бусдаасаа илүү чухал (тухайн үр өгөөжийг заавал хүртэх шаардлагатай гэх мэт) байх тохиолдол бий тул дээрх үе шатанд тодорхойлсон зардал, үр өгөөж тус бүрийг эрэмбэлнэ;
4. Зардал, үр өгөөж тус бүрийн нийт утгыг тооцож харьцуулна.⁴²

Хууль бүтээх ажиллагаанд зардал, үр өгөөжийн шинжилгээ хийх нь хууль тогтоомжийн зорилгодоо хүрэх чадвар, зохицуулалтууд нь шаардлагатай бөгөөд зохистой эсэхийг тогтооход ач холбогдолтой. Харин бизнест зардал, үр өгөөжийг нэг хэмжигдэхүүнээр буюу мөнгөн дүнгээр хэмжих тул харьцангуй хялбар байдаг. Тэгвэл бодлого, хууль тогтоомжийн үр өгөөж буюу тухайн хуулийг баталснаар бий болох эерэг үр дүн нь ихэвчлэн биет бус, удаан хугацааны дараа биеллээ олох зүйлс байдаг. Мөн зардлыг хувь хүн, нийгмийн тодорхой бүлэг, байгууллага, төр засаг зэрэг олон талт оролцогч тус бүрээр ялгаатай тодорхойлох шаардлага үүснэ. Иймээс хууль боловсруулах шатанд хийгдэх зардал, үр өгөөжийн шинжилгээ нь харьцангуй төвөгтэй бөгөөд нарийн аргачлал шаардана.

Түүнчлэн хуулийн зорилго, түүнийг батлах хэрэгцээ шаардлага болон бусад олон хүчин зүйлээс хамааран үр өгөөж, зардлын харьцаа заавал эерэг байх албагүй тохиолдол бий. Иймд зардал, үр өгөөжийн харьцаа сөрөг гарсан

⁴² Tim Stobierski, "What is cost-benefit analysis and how to do it", 2019. <https://online.hbs.edu/blog/post/cost-benefit-analysis>

боловч, өөр бусад хэрэгцээ шаардлагаар хууль баталж болохыг үгүйсгэхгүй.⁴³

АНУ-ын ХДХВ/ДОХ-ын халдвартай хүмүүсийн цагаачлалын бодлогын өөрчлөлт (2010)

1952 онд батлагдсан АНУ-ын Цагаачлал болон иргэний харьяаллын тухай хуулиар тус улсад нэвтрэхийг хориглох өвчний жагсаалтыг тогтоосон байдаг бөгөөд 1987 онд ХДХВ/ДОХ-ын халдварыг нэмснээр уг өвчний халдвар авсан гадаад улсын иргэд АНУ-д цагаачлах, аялал жуулчлалын зорилгоор нэвтрэх боломжгүй болсон. Харин 2010 онд цагаачлалын шалгах материалын жагсаалтаас ХДХВ/ДОХ-ын шинжилгээг хассан байна.

Уг шийдвэрийг гаргахад нэлээдгүй тооцоо, судалгаа хийжээ. Тухайлбал, тус шийдвэрийг гаргаснаар жилд дунджаар ХДХВ/ДОХ-ын халдвартай 4275 хүн АНУ-д нэвтрэх магадлалтай бөгөөд зөвхөн эрүүл мэндийн үйлчилгээний зардалд л гэхэд жил бүр хэдэн сая ам.долларыг зарцуулах тооцоо хийжээ.⁴⁴

Ийнхүү уг шийдвэрээс улбаалан маш өндөр зардал гарахаар байсан ч гол үр өгөөж нь хүний эрхийн суурь зарчим, ялангуяа ялгаварлан гадуурхахгүй байх зарчмыг хангах явдал байв.

Тухайн үеийн зардлын тооцоо нь ХДХВ/ДОХ-ын халдвартай хүмүүс АНУ-д цагаачлахад визний хураамж, татвар, нийгмийн даатгал, ажиллах хүчний нэмэгдэл зэрэг эерэг утгуудыг төдийлөн анхаараагүй байсныг хожим хүлээн зөвшөөрсөн юм.

Монгол Улсын хувьд ХТХ-ийн 8 дугаар зүйлийн 8.1.1 болон 8.1.13-т заасны дагуу хууль тогтоомжийн төсөл боловсруулахаас өмнө хийгдэх тандан судалгааны явцад сонгон авсан зохицуулалтын хувилбаруудын эерэг, сөрөг талыг тогтоох зорилгоор зардал, үр өгөөжийн харьцааг ерөнхий байдлаар (зардал их гарна, зардал бага гарна, зардал гарахгүй гэх мэт) тодорхойлдог. Уг тооцоо нь хууль тогтоомжийн төсөл боловсруулж эхлэхээс өмнө хийгдэх тул зөвхөн ерөнхий төсөөлөл гаргах түвшинд хийгддэг.

Харин хуулийн төсөл боловсруулсны дараа нарийвчилсан тооцоо дахин хийнэ. ХТХ-ийн 18 дугаар зүйлийн 18.1-т “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр

⁴³ Carey, Maeve P, “Cost-Benefit Analysis in Federal Agency Rulemaking”, 2024, p.1. <https://www.congress.gov/crs-product/IF12058>

⁴⁴ Susanna E Winston, Curt G Beckwith, “The Impact of Removing the Immigration Ban on HIV-Infected Persons”, 2011. <https://pmc.ncbi.nlm.nih.gov/articles/PMC3263303/#:~:text=The%20rule%20was%20accepted%20by,enacted%20on%20January%204%2C%202010.&text=The%20removal%20of%20the%20immigration,for%20those%20living%20with%20HIV.>

гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно” гэж заасан бөгөөд ЗГ-ын 2016 оны 59 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал (**Зардлын тооцоо хийх аргачлал**)-ыг баталсан.


Иймд Зардлын тооцоо хийх аргачлал нь гарах зардал болон үр өгөөж тус бүрийг тогтоож эрэмбэлэх, тэрчлэн зардлыг бууруулах боломжийг судлан тухайн хууль тогтоомжийн төслийг баталснаар гарах зардал нь “үр ашигтай зардал” байж чадах эсэхийг тодорхойлох удирдамж юм.

Хүснэгт 9. Зардлын тооцоо хийх аргачлал

Зорилго	Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гаргах зардлыг тооцож, ачааллыг цаашид аль болох багасгах санал боловсруулах	
Зардлын төрөл ба тодорхойлолт	1. Иргэний зардал	(i) үүрэг биелүүлэх мөнгөн зардал (ii) зарцуулах хугацаа (iii) шаардлагатай бол бусад
	2. Хуулийн этгээдийн зардал	(i) үүрэг биелүүлэх мөнгөн зардал (ii) шаардлагатай бол бусад
	3. Төрийн байгууллагын зардал	хүний нөөц, материаллаг зардал, бусад зардал
Үр, өгөөжийн төрөл ба тодорхойлолт	-	
Зардал ба үр, өгөөжийн эрэмбэ	-	
Харьцуулан дүгнэх	Хялбарчлах боломж буюу зардлыг бууруулах боломжтой хувилбар байгаа эсэхийг шалгана.	

Судалгаанд хамрагдсан нийт 98 хуулийн төсөлд зардлын тооцоо хийсэн байдлыг авч үзвэл 80 орчим хувь буюу 78 хуулийн төсөлд зардлын тооцоо хийжээ. Үлдэх 20 хуулийн төсөлд зардлын тооцоо хийгээгүй эсхүл тайланг нээлттэй болгоогүй байна.

График 8. Зардлын тооцоо хийсэн байдал




Зардлын тооцоо хийгдсэн 78 хуулийн төслийн дийлэнх нь аргачлалд тусгасан бүх элементийг бүрэн хамраагүй байв.

График 9. Зардлын тооцооны аргачлалд заасан элементүүдийг бүрэн хамарсан эсэх



ХТХ-ийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэг, Зардлын тооцоо хийх аргачлалын 1.5-д заасанчлан иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үүсэх зардал гэсэн гурван төрлөөр зардлыг тооцох ёстой. Харин дээрх 78 хуулийн төслийн зөвхөн 23 нь зардлыг дээрх гурван төрлөөр тооцсон бол үлдсэн 55 хуулийн төсөлд нэг эсхүл хоёр төрлөөр тооцож, “бусад төрлийн зардал үүсэхгүй тул зардлыг тооцох шаардлагагүй” гэсэн дүгнэлт хийжээ.


График 10. Зардлыг хувь хүн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үүсэх зардал тус бүрээр тооцсон эсэх



Төрийн байгууллагад үүсэх зардлыг тооцсон байдал харьцангуй өндөр байгаа бол иргэний хувьд зардал үүсэхгүй гэж дүгнэн, тооцоо хийхгүй байх нь түгээмэл байна.


ХТХ-ийн 18 дугаар зүйлийн 18.1-д "... зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг ... аргачлалын дагуу тодорхойлно" гэж заасан байдаг.

График 11. Зардал, үр өгөөжийн харьцааг тодорхойлсон эсэх



Зардлын тооцоо хийгдсэн 78 хуулийн төслөөс ердөө 23-д нь зардал, үр өгөөжийн харьцааг тодорхойлсон бол үлдэх 55 хуулийн төсөлд зардал, үр өгөөжийн харьцааг тодорхойлоогүй.

График 12. Зардал бууруулах санал, түүнийг хуульд тусгасан байдал



Судалгааны энэ хэсэгт хамаарах хуулийн төслүүдийн 20.5 хувь буюу 16 хуулийн төсөлд зардал бууруулахтай холбоотой санал дэвшүүлсэн байх ба тэдгээрийн ердөө 12.5 хувь буюу 2 нь тухайн хуульд агуулгаараа тусжээ.

Зардлын тооцоо хийхэд гарч буй нийтлэг зөрчил, дутагдал

Зардлын тооцооны бүрэн, бодитой бөгөөд үндэслэл бүхий байдал хангалтгүй:

- ХТХ болон Зардлын тооцоо хийх аргачлалд зардлыг хариуцах субъектээр нь иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үүсэх зардал гэж тооцохоор заасан. Гэхдээ хуулийн төрөл, зорилго, агуулга, хамрах хүрээ, зохицуулалтын мөн чанараас шалтгаалан зарим этгээдэд зардал үүсгэхгүй байх тохиолдол бас бий. Судалгаанд хамрагдсан хуулийн төслүүдийн 60 гаруй хувь нь аль нэг эсхүл хэд хэдэн этгээдэд огт зардал үүсгэхгүй тул зардал тооцох боломжгүй, шаардлагагүй гэж дүгнэсэн байв. Энэ тохиолдолд үндэслэл нь бодитой бөгөөд түүнийг тайланд тодорхой тусгах шаардлагатай. Гэвч ийнхүү зардал гарахгүй гэж үзсэн үндэслэлийг тайланд тодорхой тусгахгүй байх нь элбэг бөгөөд зарим тохиолдолд зайлшгүй зардал гарах нөхцөлийг тооцоогүй эсхүл дутуу тооцсон байдал ажиглагдсан болно.
- Түүнчлэн зардлын тооцоололд ашигласан суурь тоо, баримт, мэдээлэл, тэдгээрийн эх сурвалжийг дурдахгүй байгаа нь зардлын тооцооны үнэн зөв байдлыг үнэлэхэд хүндрэл учруулж байна.

Хүснэгт 10. Зардал тооцоогүй шалтгаан ба тооцвол зохих зардал

Хуулийн төслийн нэр	Зардал тооцоогүй шалтгаан	Тооцвол зохих зардал
2021 оны 7 сарын 02-ны өдөр батлагдсан Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл	Хуулийн этгээдийн хувьд тэтгэмж олгох, нэмэгдэл хөлс олгох, эрүүл мэндийн үзлэгт хамруулах, тайлан хүргүүлэхтэй холбогдон үүсэх зардлыг тооцсон.	Уртын ээлжийн зохицуулалтад шилжихэд гарах зардал, хөдөлмөрийн эрхийн маргаан таслах комисс байгуулах, түүний ажиллагаатай холбоотой зардал зэргийг тооцоогүй.
2021 оны 4 сарын 08-ны өдөр батлагдсан Засгийн Газрын тусгай сангийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл	Төрийн байгууллагад үүсэх зардлыг тооцсон боловч дутуу тооцсон.	Уг хуулиар Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг дэмжих сангийн зохицуулалтыг нэмсэн бөгөөд үүнтэй холбоотой төрийн байгууллагад үүсэх зардлыг тооцоогүй.

Түүнчлэн зардлын тооцоололд ашигласан суурь тоо, баримт, мэдээлэл, тэдгээрийн эх сурвалжийг дурдахгүй байгаа нь зардлын тооцооны үнэн зөв байдлыг үнэлэхэд хүндрэл учруулж байна.

Зардлын тооцоо хийх аргачлалд иргэн болон хуулийн этгээдийн зардлыг явцуу хүрээнд тодорхойлсон:

- Зардлын тооцоо хийх аргачлалд иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагаас гарч болох зардлыг ялгаатай тодорхойлсон боловч гарч болох бүх зардлыг тусгаагүй. Энэ нь хуулийн төслийн нөлөөллийг бодитоор тооцоход саад учруулж байна.
- Судалгааны энэ хэсэгт авч үзсэн 78 хуулийн төслийн 66.7 хувь нь иргэнд, 43.6 хувь нь хуулийн этгээдэд зардал гарахгүй гэж дүгнэсэн бол төрийн байгууллагад зардал гарахгүй гэж үзсэн тохиолдол харьцангуй бага буюу 19.2 хувь байна. Ийнхүү иргэн, хуулийн этгээдэд зардал үүсэхгүй гэж үзэх байдал давамгайлж байгаа нь Зардлын тооцоо хийх аргачлалд иргэн, хуулийн этгээдэд үүсэх зардлыг явцуу хүрээнд тодорхойлсонтой холбоотой гэж дүгнэж болохоор байв.

Хүснэгт 11. Аргачлалд заасан зардлын төрөл

Төрөл	Тооцох зардал	Дэлгэрэнгүй
Иргэн	Үүрэг биелүүлэх мөнгөн зардал	Тоо баримт, тайлан, мэдээлэл бэлтгэн төрийн байгууллага буюу гуравдагч этгээдэд гаргаж өгөх үүрэг хамаарна.
	Зарцуулах хугацаа	Дээр дурдсан тоо баримт, тайлан мэдээлэл бэлтгэхэд зарцуулах цаг хугацааг мөнгөн дүнгээр илэрхийлж тооцно.
	Нэмэлт зардал	Шаардлагатай бол нэмэлт зардал тооцож болно.
Хуулийн этгээд	Үүрэг биелүүлэх мөнгөн зардал	Тоо баримт, тайлан, мэдээлэл бэлтгэн төрийн байгууллага буюу гуравдагч этгээдэд гаргаж өгөх үүрэг хамаарна.
	Нэмэлт зардал	Шаардлагатай бол нэмэлт зардал тооцож болно.
Төрийн байгууллага	Хүний нөөц	Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг, ажил үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийн цалин, нэмэгдэл, тусламж зэрэг.
	Материаллаг зардал	Түрээсийн төлбөр, цахилгаан, бичиг хэрэг, урсгал зардал зэрэг.
	Бусад зардал	Бусад дагалдан гарах зардал

- Зардлын тооцоо хийх аргачлалын 2.3-т иргэн, хуулийн этгээдийн хувьд "... үүрэг нэг бүрийг тогтооно. Гүйцэтгэх үүрэг гэж ... тоо баримт, тайлан, холбогдох бусад мэдээллийг бэлтгэн төрийн байгууллага буюу гуравдагч этгээдэд гаргаж өгөх, эсхүл хүргүүлэхийг хэлнэ" гээд эшлэлээр "Үүнд бүх төрлийн өргөдөл, хүсэлт, маягт бөглөх, статистик тоо мэдээ өгөх, бүртгүүлэх, нөхөн олговор, төрөөс тусламж, дэмжлэг, зөвшөөрөл авахыг хүссэн өргөдөл гаргах, зөвшөөрөл хүсэх гэх мэт үүргүүд хамаарна" хэмээн зардлын хүрээг өргөжүүлжээ. Гэвч практикт зардлын тооцоог ийнхүү өргөжүүлсэн хүрээнд хийхгүй байгаа нь нийтлэг.
- Хууль батлагдсанаар үүсэх зардлыг тооцохдоо нөлөөлөлд өртөх этгээдүүдэд хэр хэмжээний зардал үүсгэх, түүнийг хэрхэн бууруулах боломжийг тодорхойлох ёстой. Гэвч Зардлын тооцоо хийх аргачлалд, хууль, тогтоомжийн төслийн нөлөөлөлд өртөх гол этгээд болох иргэн, хуулийн этгээдэд учрах зардлыг явцуу хүрээнд тодорхойлсон нь бодитоор үүсгэх зардлыг дутуу тооцох буюу хуулийн нөлөөллийг бүрэн тооцож чадахгүйд хүргэх, цаашлаад хуулийн хэрэгжилтийг бууруулахад нөлөөлж байна.

Хүснэгт 12. Зардлын тооцооны аргачлалд нэмж тусгавал зохих зардлууд

Зардлын шинж чанар	Жишээ	Тайлбар
Шилжилтийн үеийн зардал	2021 оны 07 сарын 02-ны өдөр батлагдсан Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар уул уурхай, олборлох салбарын ээлжээр ажиллах хуваарийг 14/14 гэж тогтоосон. Энэ нь 21/14, 28/14 гэсэн хуваарийг хэрэгжүүлж байсан уул уурхайн компани болон ажиллагсдад уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой шилжилтийн үеийн томоохон зардал үүсгэсэн. Үүнд: • Ээлжийн хуваарь зохицуулах бүтэц, программ хангамжаа өөрчлөх; • Ажлын төлөвлөгөөг 14/14 хуваарьт тааруулан дахин загварчлах; • Ажилтнуудыг уурхайн талбарт хүргэх, болон буцаан тээвэрлэх зардалд шууд өөрчлөлт оруулах; • Дотоод дүрэм, журам, гэрээ, хэлцлийг өөрчлөх; • Цалингийн тооцоололтой холбоотой санхүү болон хүний нөөцийн бусад зардал. Иргэний хувьд: • 14/14 хуваарьт шилжсэнээр ажиллах цагт өөрчлөлт орох тул үүнтэй холбоотой цалингийн өөрчлөлт • Бага насны хүүхдээ асрах, цэцэрлэг сургуульд хүргэх зэрэг ахуй амьдралаа шинэ хуваарийн дагуу зохицуулах зардал.	Зардлын тооцоо хийх аргачлалд шилжилтийн үеийн зардал тооцох зохицуулалт байхгүй. Хэдийгээр үүнийг нэмэлт зардал хэмээн тооцох боломжтой боловч аргачлалд тодорхой тусгаагүй тул шаардлагатай эсэхийг тооцоо хийж буй этгээд өөрөө шийдэж байна. Тиймээс хуулийн зохицуулалтын өөрчлөлттэй холбоотой энэ мэт шилжилтийн үеийн зардлыг аргачлалд тусгах нь зүйтэй. Хуулийн үйлчлэлд өртөх гол талуудад үүсэх нэмэлт ачаалал, зардлыг бүрэн тооцолгүйгээр хууль баталсан дээрх жишээ нь хуулийн бодит хэрэгжилт болон суурь судалгаа хоорондоо хэр зэрэг зөрүүтэй байгааг харуулж байна.

Зардлын шинж чанар	Жишээ	Тайлбар
Зах зээлийн боломж	2021 оны 01 сарын 29-ний өдөр батлагдсан Банкны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр аливаа этгээд дангаараа болон холбогдох этгээдийн хамтаар банкны 20 ба түүнээс дээш хэмжээний хувийн хувьцааг эзэмшиж болохгүй гэх зохицуулалтыг хуульчилсан боловч тус хуулийн дагаж мөрдөх журмын тухай хуулиар үйлчлэлийг хэд хэдэн удаа хойшлуулсан.	Уг зохицуулалт бүрэн хэрэгжихийн тулд банкнуудын хувьцааны 80 ба түүнээс дээш хувийг анхдагч эсхүл хоёрдогч зах зээлээс худалдан авах чадвартай боломжтой этгээдүүд байх учиртай. Энэ нь хэдийгээр шууд зардал биш боловч хууль хэрэгжүүлэхтэй холбоотой аль нэг талд зайлшгүй үүсэх зардал мөн тул зах зээлийн үнэлгээгээр банкнуудын хувьцааг худалдан авах чадвар бүхий хангалттай тооны этгээд (зах зээлийн боломж) байгаа эсэхийг зардлын тооцоонд харгалзан үзэх шаардлагатай байв. Хэрэв ийм тооцоо хийсэн бол хуулийн хэрэгжиж эхлэх хугацааг анхнаас нь оновчтой тогтоох боломж бүрдэх байжээ.

Хууль тогтоомжийн судалгааны аргачлалуудын уялдаа холбоо тодорхойгүй:

- ХТХХ болон Зардлын тооцоо хийх аргачлалаас үзвэл, зардлын тооцооны зорилго нь хамгийн бага зардалтай зохицуулалтын хувилбарыг сонгож, хамгийн сайн үр ашигт хүрэх явдал юм. Уг тооцоогоор зардал болон үр өгөөж гэсэн хоёр хэмжигдэхүүний харьцааг олох тул тэдгээрт юу хамрахыг тус бүрд нь нарийвчлан тодорхойлох учиртай. Гэвч Зардлын тооцоо хийх аргачлалд зөвхөн зардлын төрөл, агуулгыг тусгасан байх бөгөөд үр өгөөжийг хэрхэн тооцох, зардалтай хэрхэн харьцуулах талаар удирдамж, арга зүй байхгүй. Харин бусад аргачлалуудад хуулийн төслийн үр өгөөжтэй холбоотой дараах зүйлс тусгагдсан байна. Үүнд: Хэрэгцээ шаардлагын тандан судалгааны аргачлалд “зохицуулалтын хувилбарын эерэг үр нөлөө”, Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөний үнэлгээнд “хууль тогтоомжийн тухай хуулийн зорилгод хүрэх байдал”, Түүнчлэн хууль тогтоомжийн үзэл баримтлалд “үр өгөөж” нь агуулгаараа туссан. Хуулийн төслийн үр өгөөжийг тодорхойлсон дээрх судалгааны дүгнэлтүүдийг зардлын тооцоо хийхэд харгалзан үзэх байдал хангалтгүй байна.

- Судалгааны энэ хэсэгт хамаарах 78 хуулийн ердөө 28.2 хувьд л зардал, үр өгөөжийн харьцааг тодорхойлсон. Зардал, үр өгөөжийн харьцааг ийнхүү тодорхойлохдоо (i) ямар нэг тооцоолол хийхгүйгээр “зардал нь үр өгөөжтэй харьцуулахад бага эсхүл их” гэж шууд дүгнэх; (ii) бодит хэмжигдэхүүн, тодорхой тоо баримтад үндэслэхгүй буюу дээр дурдсан бусад судалгаанаас эшлэхгүйгээр ерөнхий дүгнэлт хийх хандлага ажиглагдаж байна. Энэ нь зардлын тооцоо гэх бие даасан судалгааны ач холбогдол, шинжлэх ухааны үндэслэлийг бууруулж байна.

Хүснэгт 13. Зардал, үр өгөөжийн харьцааг тодорхойлсон байдал

Зардал, үр өгөөжийн харьцааг шууд тодорхойлсон жишээ		
Хуулийн төслийн төрөл	Хуулийн төслийн нэр	Зардал, үр өгөөжийн харьцааг тодорхойлсон байдал
Шинэчилсэн найруулга	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай	Тус хуулийн төсөл батлагдсанаар гарах зардал нь үр өгөөжтэй харьцуулахад үлэмж бага буюу үр ашиг зардлын харьцаа өндөр байна. ⁴⁵
Шинэчилсэн найруулга	Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай	Тус хуулийн төсөл батлагдсанаар гарах зардал нь үр өгөөжтэй харьцуулахад үлэмж бага буюу үр ашиг зардлын харьцаа өндөр байна. ⁴⁶
Анхдагч хууль	Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай	Хуулийн төсөл батлагдсанаар төрийн байгууллагуудад үүсэж болох зардал нь хуулийн үр өгөөжтэй харьцуулахад үлэмж бага буюу үр ашиг өндөр байна гэж үзлээ. ⁴⁷
Анхдагч хууль	Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай	Хуулийн төсөл батлагдсанаар иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үүсэх зардлын үр өгөөж нь зардлаасаа их байна. Учир нь хуулийн төсөл батлагдсанаар 1300 орчим барьцаалан зээлдүүлэх газар татвараа шударгаар төлөх, байнга, ашиг олох зорилгоор мөнгөн зээл олгодог иргэд зээлийн үйл ажиллагаанаас олсон орлогоос татвараа шударгаар төлөх, хулгай, залилангийн хэргийн тоо буурч, цагдаагийн байгууллагад ачаалал буурах, мөнгө угаах гэх зэрэг эдийн засгийн гэмт хэрэг үүсэх, далд явагдаж буй мөнгөний эргэлт ил, хяналттай болох зэрэг үр өгөөжтэй байна. ⁴⁸

⁴⁵ Нийтийн мэдээллийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн Хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцооны тайлан, 2020, 26 дахь тал.

⁴⁶ Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухайн анхдагч хуулийн төсөлд хийсэн зардлын тооцооны тайлан, 2020, 18 дахь тал.

⁴⁷ Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөлд хийсэн зардлын тооцооны тайлан, 4 дэх тал.

⁴⁸ Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн төслийн Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо, 2020, 30 дахь тал.

Зардал, үр өгөөжийн харьцааг шууд тодорхойлсон жишээ		
Хуулийн төслийн төрөл	Хуулийн төслийн нэр	Зардал, үр өгөөжийн харьцааг тодорхойлсон байдал
Анхдагч хууль	Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай	Түгжрэл үүсгэж буй одоогийн нөхцөл байдлыг арилгахын тулд хуулийн төсөлд тусгасан арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхэд бий болох зардлууд нь дээр дурдсан алдагдсан боломжийн өртөгтэй харьцуулахад зардал, үр өгөөжийн харьцаа эерэг түвшинд байна гэж үзлээ. ⁴⁹
Шинэчилсэн найруулга	Банк, эрх бүхий этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай	Хуулийн төслийг баталснаар тус үйлчилгээг авч байгаа хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах эрх зүйн орчин сайжрах бөгөөд хуулийн этгээд үйл ажиллагааг одоо байгаа хүний нөөцөөр гүйцэтгэх боломжтой байх тул ... хуулийн этгээдэд үүсэж болох зардал үр өгөөжтэй харьцуулахад үлэмж бага буюу үр ашиг өндөр байна гэж үзэж байна. ⁵⁰

- Ийнхүү зардал, үр өгөөжийн талаар хэт ерөнхий дүгнэлт хийж байгаа нь нэг талаас Зардлын тооцоо хийх аргачлалд үр өгөөж, түүний зардалтай харьцах харьцааг тооцох аргачлал, хэмжүүр үзүүлэлт байхгүйтэй холбоотой. Нөгөө талаас бусад судалгаанд тусгагдсан үр өгөөж тооцохтой холбоотой баримт мэдээлэл, дүгнэлтийг харгалзан үзээгүйтэй холбоотой.

Зардал бууруулах санал, түүнийг хуулийн төсөлд тусгах байдал хангалтгүй:

- Нийт 78 хуулийн төслийн Зардлын тооцооны тайлангийн дөнгөж 16 нь зардал бууруулахтай холбоотой санал, зөвлөмж агуулсан байх ба тэдгээрийг хуулийн төсөлд тусгасан тохиолдол зөвхөн хоёр байна. Тэрхүү 2 тохиолдол нь хуулийн аль заалтыг хэрхэн өөрчилж болохыг тодорхой томъёолсноороо бусад тайлангаас ялгаатай байв.

⁴⁹ Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төслийн Хууль, тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцооны тайлан, 2023, 25 дахь тал.

⁵⁰ Банк, эрх бүхий этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд хийсэн зардлын тооцооны тайлан, 2020, 8 дахь тал.

Хүснэгт 14. Зардал бууруулах саналыг тусгасан хуулиуд

Хуулийн нэр	Зардал бууруулах санал	Санал тусгагдсан байдал
Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай	Хуулийн төслийн 13.2-т “... Хорооны ажлын албаны үүргийг ХЭҮК-ын ажлын албаны бүтцэд бие даасан нэгж гүйцэтгэнэ” гэж заасанд үндэслэн Ажлын албыг бие даасан байдлаар шинээр үүсгэн байгуулахаас илүүтэй ХЭҮК-ын ажлын албанд давхар хариуцуулан, хүний нөөцийг нэмэх зайлшгүй шаардлагатай тохиолдолд ХЭҮК бүтэц орон тоогоо УИХ-аар дахин хэлэлцэж батлуулах замаар одоо байгаа нөөц бололцоондоо тулгуурлан асуудлыг шийдвэрлэвэл төрөөс гарах зардлын хэмжээг багасгах боломжтой. ⁵¹	12.1. Хорооны гишүүнд туслах чиг үүрэг бүхий орон тооны нэгж ажиллах бөгөөд бүтэц, орон тоог Комисс батална. 12.3.Хорооны нэгж нь Комиссын Тамгын газарт харьяалагдана.
Монгол Улсын шүүхийн тухай	Хуулийн төслийн 47.2-т “Тухайн шүүгчийн үндсэн цалингийн хэмжээ шүүгчээр ажилласан тав дахь жилээс эхлэн жил бүр өмнөх оныхоос хоёр хувиар нэмэгдэнэ.” гэж заасан нэмэгдлийг нэмбэл улсын төсөвт үүсэх зардал нэмэгдэхээр байх тул хуулийн төслийн 47.2 дахь хэсгийг төслөөс хасаж, дээрх нэмэгдлийг агуулсан 47.3 дахь хэсгийг л хуулийн төсөлд үлдээх нь зүйтэй гэсэн зөвлөмжийг өгч байна. ⁵²	46.3.Ерөнхий зөвлөл шүүгчийн албан тушаалын цалин, нэмэгдлийн хэмжээг өөрийн батлагдсан төсвийн хүрээнд тогтоож, нэмэгдэл олгох журмыг батална.

Харин зардлыг бууруулах санал өгсөн ч хуулийн төсөлд тусгагдаагүй 14 тохиолдолд дараах нийтлэг дутагдал ажиглагдлаа.

Хүснэгт 15. Зардал бууруулах саналыг тусгаагүй тохиолдол (нийтлэг дутагдал)

Нийтлэг дутагдал	Зардал бууруулах санал	Дүгнэлт
Санал нь хэт ерөнхий, хэлбэр төдий	Төрийн байгууллагын үйл ажиллагааг цахимжуулах, бүртгэлийн мэдээллийн тогтолцоог шинэчлэх, нэг цонхны үйлчилгээг нэвтрүүлснээр зардлыг бууруулах боломжтой.⁵³	Хуулийн төслийн зардлыг бууруулахад “цахимаар үйл ажиллагаа явуулж зардал бууруулах” гэсэн санал өгөх нь элбэг байна.

⁵¹ Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлд хийсэн зардлын тооцоо, 2020, 30 дахь тал

⁵² Монгол Улсын шүүхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийсэн тайлан, 2020, 21 дэх тал.

⁵³ Хоршооны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн санал

Нийтлэг дутагдал	Зардал бууруулах санал	Дүгнэлт
	- Мэдээлэл хүлээн авах хэлбэрийг цахимжуулах зэрэг арга хэмжээг дүрэм, журмаар зохицуулан хэрэгжүүлэх боломжтой бөгөөд ингэснээр зардлыг бууруулах боломжтой.⁵⁴ - Мэдээллийг 100 хувь цахим хэлбэрээр хүргүүлэх, бичиг баримтын үнэн зөв байдлыг цахим хэлбэрээр шалгах боломжийг судлах шаардлагатай.⁵⁵	Зардал бууруулах саналыг тусгаагүй 14 хуулийн төслийн хувьд санал нь бүгдээрээ аль нэг тодорхой зохицуулалтыг өөрчлөх, сайжруулах хэмжээнд нарийвчлан боловсруулагдаагүй байгааг онцлууштай.
Санал нь бодитой бус, бусад боломжит хувилбар санал болгоогүй	Төрийн байгууллагад 1 жилд 7.5 орчим тэрбум төгрөгийн зардал, 221 хүний нөөцийн хэрэгцээ үүсэхээр байна. Төрийн байгууллагад үүсэх голлох зардал нь хороонд биеийн тамирын арга зүйч авч ажиллуулах үйл ажиллагаатай холбоотой үүсэж байна. Тус үйл ажиллагаа нь хуулийн зорилтыг биелүүлэхэд ач холбогдол өндөртэй тул хэрэгжүүлэх нь чухал юм. Харин эхний жил нийт шаардагдах хүний нөөцийн 30 хувийг авах зэргээр үе шаттай хэрэгжилтийг зохион байгуулах тохиолдолд эхний жилүүдэд шаардагдах зардлын дүн буурна. ⁵⁶	Биеийн тамир, спортын тухай хуулийн зорилго нь биеийн тамир, спортоор дамжуулан сэтгэл, оюуны болон бие бялдрын боловсрол олгох, идэвхтэй хөдөлгөөн, амьдралын зөв дадал хэвшлийг дэмжих явдал гэжээ. Уг хуулийн дагуу сум, дүүрэг, хороонд орон тооны биеийн тамирын арга зүйч ажиллахаар зохицуулсан бөгөөд ийнхүү 221 арга зүйчийг ажиллуулахад 1 жилд 7.5 тэрбум төгрөгийн зардал гарах боловч биеийн тамир, спортыг дэмжихэд өндөр ач холбогдолтой гэж зардлын тооцоонд дүгнэжээ. Гэвч энэ хэмжээний зардлаар бүх нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэхэд чиглэсэн нийтийн спортын талбай, байгууламж барих зэрэг бусад боломжит хувилбарыг тооцож, харьцуулалт хийгээгүй нь өрөөсгөл байна.

- Зардлын тооцоогоор зардал бууруулах саналыг тодорхой хэмжээнд дэвшүүлж байгаа нь сайшаалтай боловч санал нь ихэнх тохиолдолд хуулийн төслийн зохицуулах харилцааны онцлогт тохирсон, бодитой бөгөөд үндэслэлтэй байж чадахгүй байна.

⁵⁴ Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн санал

⁵⁵ Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийн санал

⁵⁶ Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд хийсэн зардлын тооцооны тайлан, 2023, 17 дахь тал.

- Түүнчлэн зардал бууруулахад чиглэсэн санал өгөөгүй тохиолдлууд нь “байж болох хамгийн бага зардал гарах хувилбар байна”, “одоогийн гарч буй зардлыг бууруулна” гэх зэрэг зардлын тооцооны бусад хэсгүүдэд дурдагдаагүй, нотлогдоогүй, үндэслэл нь тодорхойгүй дүгнэлтийг шууд хийх байдал нийтлэг ажиглагдав.
- Зардлын тооцоог хуулийн төсөл санаачлагч нь өөрөө гүйцэтгэх нь түгээмэл байгаа тул зардал бууруулах бусад боломжит хувилбарыг эрэлхийлэхгүй, тооцоог хараат бусаар хийхгүй байна хэмээн дүгнэх боломжтой.

Явцын дүгнэлт: Зардлын тооцоо

- Зардлын тооцоо хийгээгүй цөөн тохиолдлыг эс тооцвол хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой зардлыг тооцох ажил хийгдэж хэвшсэн байна. Зардлын тооцоо хийгээгүй цөөн тохиолдол нь институтын хяналтын гадуур өнгөрсөн нь анхаарал татаж байна.
- Гэвч зардлын тооцоог аргачлалд тусгасан бүх шаардлагын дагуу бүрэн гүйцэд, бодит үндэслэлтэйгээр хийх байдал дутмаг байна. Энэ нь нэг талаар Зардлын тооцоо хийх аргачлал нь хангалттай удирдамж болж чадахгүй байгаатай, нөгөө талаар зардлын тооцооны чанарт тавих хяналт дутмаг, тооцоог хараат бусаар гүйцэтгэх нөхцөл бүрдээгүйтэй холбоотой байна.
- Зардлын тооцоо хийх аргачлалд иргэн, хуулийн этгээдэд учрах зардлыг явцуу хүрээнд тодорхойлж, гарч болох зардлуудыг бүрэн тусгаагүй нь хуулийн төслийн нөлөөлөл (зардал, үр өгөөж)-ийг бодитоор үнэлж чадахгүйд хүргэж байна. Тэрчлэн Зардлын тооцоо хийх аргачлалыг тухайн нөхцөл байдалд тохируулан уян хатан байдлаар хэрэглэх боломжийг хязгаарлаж байна.
- Зөв шийдвэр гаргахад зардал, үр өгөөжийн харьцааг оновчтой тодорхойлох нь чухал. Гэвч Зардлын тооцоо хийх аргачлалд үр өгөөжийг хэрхэн тооцохыг тусгаагүй бөгөөд үр өгөөжийг тодорхойлох бусад судалгааны аргачлалтай уялдаа холбоо байхгүйгээс үр өгөөжийг үндэслэлтэй тогтоох боломж хомс байна.
- Зардлын тооцоо хийх аргачлалын дагуу зардлыг бууруулах, хялбарчлах боломжийг тодорхойлох ёстой. Гэвч ийнхүү зардал бууруулах боломж тодорхойлох байдал хангалтгүй. Дэвшүүлж буй саналууд нь ихэнхдээ

хэт ерөнхий, хуулийн төслийн зохицуулалтад суурилаагүй, бодитой, үндэслэлтэй гэхээс илүүтэй “зардал бууруулах санал боловсруулах” гэсэн аргачлалын шаардлагыг хэлбэр төдий байдлаар хангасан шинжтэй байна. Иймээс ч зардлыг бууруулах саналууд нь ихэвчлэн хуулийн төсөлд тусаагүй байв.

2.3. Хуулийн төсөлд үр нөлөөний үнэлгээ хийсэн байдал

ХТТХ-ийн 17 дугаар зүйлийн 17.3-т “Хууль тогтоомжийн төслийг батлан хэрэгжүүлснээр гарах үр нөлөөг тооцсоны үндсэн дээр шаардлагатай бол тухайн хууль тогтоомжийн төсөл, эсхүл түүний зарим зүйл, заалтыг дахин боловсруулна” гэснээс үзэхэд үр нөлөөний үнэлгээ нь хуулийн хэрэгжих чадамжийг урьдчилан тодорхойлж, цаашид сайжруулах нэн чухал алхам болж байна. Ийнхүү хуулийн төслийг батлахын өмнө хийх энэхүү үнэлгээ (prospective - ex ante) нь тухайн хуулийн үзүүлэх нөлөөллийн талаар төсөөлөл бүрдүүлэх, аль зүйл заалтын хэрэгжилтэд ямар эрсдэл үүсэж болохыг тогтоох ач холбогдолтой. Ингэснээр хуулийн хэрэгжилтэд тулгарч болзошгүй асуудлыг урьдчилан шийдвэрлэх, засаж сайжруулах эсхүл хүлээн зөвшөөрөх зэрэг хувилбараас сонгон хуулийн хэрэгжилтийг нэмэгдүүлэх гарц болдог.

ХТТХ-ийн 17 дугаар зүйлийн 17.1-т “Хууль санаачлагч хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг энэ хуулийн 12.1.3-т заасан аргачлалын дагуу үнэлнэ” гэж заасан бөгөөд тус заалтыг хэрэгжүүлэх хүрээнд ЗГ-ын 2016 оны 59 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралтаар Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал (Үр нөлөөний үнэлгээний аргачлал)-ыг баталсан.

График 13. Үр нөлөөний үнэлгээ хийсэн байдал



Судалгаанд хамаарах нийт 98 хуулийн дийлэнх буюу 81 хуульд үр нөлөөний үнэлгээ хийгдсэн байх бол үлдэх 17 хуулийн үр нөлөөний үнэлгээний тайлан олдоогүй болно. Энэ нь нэг бол үнэлгээ огт хийгээгүй, эсвэл хийсэн боловч тайланг нийтэд нээлттэй болгоогүй байж болох юм. Иймд тоон болон чанарын үнэлгээг цаашид үр нөлөөний үнэлгээний тайлан бүхий 81 хуулийн төсөлд хийсэн болно.

График 14. Үр нөлөөний үнэлгээний үе шат



I үе шат: Шалгуур үзүүлэлтийг сонгох


Тухайн боловсруулж байгаа хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан аргачлалд заасан дараах зургаан шалгуур үзүүлэлтээс нэг эсхүл хэд хэдийг сонгон хуулийн төслийг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн үр нөлөөг үнэлнэ.

Хүснэгт 16. Үр нөлөөний үнэлгээний шалгуур үзүүлэлт

Шалгуур үзүүлэлт	Зорилго	Шалгах хэрэгсэл
Зорилгод хүрэх байдал	Тухайн хуулийн төслөөр тавьж байгаа зорилгодоо хүрч чадах эсэх	Зорилгод дүн шинжилгээ хийх
Практикт хэрэгжих боломж	Тухайн хуулийн төслийн зохицуулалтыг дагаж мөрдөх буюу хэрэгжүүлэх боломжтой эсэх	Практикт турших
Ойлгомжтой байдал	Хуулийн төслийн зохицуулалт түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх субъектүүдийн хувьд ойлгомжтой, логик дараалалтайгаар боловсруулагдсан эсэх	Ойлгомжтой байдлыг шалгах
Хүлээн зөвшөөрөгдөх байдал	Тухайн хуулийн төслийн зохицуулалт иргэд, байгууллагад хэрхэн нөлөөлөх, түүнийг эдгээр этгээдүүд (хуулийн төсөл шууд нөлөөлөх иргэн, хуулийн этгээд) хүлээн зөвшөөрөх эсэх	Хүлээн зөвшөөрөгдөх байдлын судалгаа хийх
Зардал	Хуулийн төслийн зохицуулалт иргэн, аж ахуйн нэгж, байгууллага болон улсын төсөвт ачаалал, хөнгөлөлтийг үүсгэх, төрийн байгууллагад хуулийн төслийг хэрэгжүүлэхэд үүсэх зардал, уг зардлын улмаас үүсэх үр дагавар	Зардлын тооцоо хийх

Шалгуур үзүүлэлт	Зорилго	Шалгах хэрэгсэл
Харилцан уялдаа	Тухайн хуулийн төслийн зүйл, заалт өөр хоорондоо болон хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хууль тогтоомжтой нийцсэн эсэх, мөн төрийн байгууллагын чиг үүрэгтэй давхардсан, зөрчилдсөн эсэх, тухайн чиг үүргийг төрийн байгууллага зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай эсэх, уг чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх боломжтой эсэх	Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах


График 15. Үр нөлөөний үнэлгээний шалгуур үзүүлэлтийг сонгосон байдал



Судалгааны энэ хэсэгт хамаарах 81 хуулийн төсөлд дээрх зургаан шалгуур үзүүлэлтийг бүгдийг нь сонгож үнэлгээ хийсэн тохиолдол байхгүй. Харилцан уялдаа болон зорилгод хүрэх байдал гэсэн шалгуур үзүүлэлтүүд хамгийн их сонгогдсон байна. Харин зардалтай холбоотой шалгуурыг хамгийн цөөн сонгосон нь зардлын тооцоог тусгайлан аргачлалаар бие даан хийдэгтэй холбоотой байж болох юм.

Шалгуур үзүүлэлтийг сонгохдоо хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулах талаар аргачлалд заасан. Гэхдээ энэхүү шаардлага хэт ерөнхий томъёологдсоноос үүдэн шалгуур үзүүлэлтийг объектив байдлаар оновчтой сонгоход хүндрэлтэй байна.

График 16. Үр нөлөөний үнэлгээний аль нэг шалгуур үзүүлэлтийг сонгоогүй тохиолдолд үндэслэлээ тайлбарласан байдал



Тухайн шалгуур үзүүлэлтийг сонгоогүй үндэслэлээ тайлбарлах байдал хангалтгүй байна. (Дэлгэрэнгүйг Хавсралт 8-аас үзнэ үү.) Зорилгод хүрэх байдал гэсэн шалгуур үзүүлэлтийг сонгоогүй 21 тохиолдлоос 18 буюу 86 орчим хувьд ямар нэгэн тайлбар өгөөгүй бол ойлгомжтой байдал гэсэн үзүүлэлтийн хувьд 96, зорилгод хүрэх байдал 85, практикт хэрэгжих боломж 84, хүлээн зөвшөөрөгдөх байдал 82, зардлын тооцоо 55 хувьд эдгээр үзүүлэлтийг яагаад сонгоогүйгээ тайлбарлаагүй.

Харин тодорхой шалгуур үзүүлэлтийг сонгоогүй үндэслэлээ тайлбарласан байдлыг авч үзвэл:

- Зардлын тооцоо: Бүх тохиолдолд “Хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардлын тооцоог тусгайлан хийх/хийсэн тул цаг хугацаа, нөөцийн хэмнэлт хийх үүднээс зардлыг тооцох шалгуур үзүүлэлтийг сонгоогүй” гэсэн тайлбар хийсэн байв.
- Хүлээн зөвшөөрөгдөх байдал: Дийлэнхдээ “иргэн, аж ахуйн нэгжид шинээр үүрэг хүлээлгээгүй” гэж тайлбарласан.
- Практикт хэрэгжих боломж: “Хугацаа давчуу байсан”⁵⁷, “шинэ

⁵⁷ Генетик нөөцийн тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээний тайлан

заалтуудын хувьд үзэл баримтлалд тусгагдсан практик үндэслэл, шаардлагуудаас урган гарч ирсэн хэрэгцээ нь тодорхой тул бусад шалгуур үзүүлэлттэй харьцуулахад бага ач холбогдолтой”,⁵⁸ “шинээр хуульчлагдах зохицуулалт, арга хэмжээ нь нэгэнт олон улсад хүлээн зөвшөөрөгдөж, туршигдсан тул уг үнэлгээг хийх ач холбогдолгүй”⁵⁹ зэрэг тайлбар хийсэн байна. Харин анхдагч хуулийн төсөлд “энэ төрлийн зохицуулалт өмнө нь Монгол Улсад хэрэгжиж байсан туршлага бий”⁶⁰ гэж тайлбарласан тохиолдол гарсан нь анхаарал татаж байна. Мөн “өмнө нь төсөөтэй зохицуулалтыг хэрэглэж байсан практик туршлага бий” гэх тайлбар нийтлэг байв.

- Ойлгомжтой байдал: Уг шалгуурыг сонгоогүй шалтгаанаа “хуулийн төслийн зорилгод хүрэх байдал, харилцан уялдаа шалгуур үзүүлэлтийн хүрээнд зохицуулалтуудын ойлгомжтой байдлыг хамтатган судалж байгаа тул ойлгомжтой байдал гэсэн шалгах хэрэгслийг сонгон авч давхардуулан судлах шаардлагагүй”⁶¹ гэж тайлбарласан байв.

Дээрхээс харахад шалгуур үзүүлэлтүүдийг тодорхой шалтгаан үндэслэлгүйгээр сонгодог байдал давамгайлж байна. Тухайлбал, 2024 оны 04 сарын 19-ний өдөр батлагдсан Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн үнэлгээний тайланд “Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд төсөлд тодорхой этгээдүүдэд үүрэг хүлээлгэсэн, аж ахуйн байгууллагын салбарт хүндрэл үүсгэх зохицуулалтыг тусгаагүй тул хүлээн зөвшөөрөгдөх байдал гэсэн шалгуур үзүүлэлтийг сонгон авах шаардлагагүй гэж үзсэн” гэжээ. Гэвч уг хуулийн 12 дугаар зүйлд мэргэжлийн нэгдсэн холбооны чиг үүрэгт нийт арван хоёр, 13 дугаар зүйлд төрийн байгууллагатай хамтран ажиллах талаар найман чиг үүргийг тусгасан байна.

II үе шат: Хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоох

Аргачлалын дагуу сонгон авсан шалгуур үзүүлэлт тус бүрээр үнэлгээ хийх хэсгийг хуулийн төслөөс сонгон авна. Ингэхдээ хуулийн төслийг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн сонгон авч болно. Гэхдээ үүнд ямар үндэслэл, шалгуур баримтлахыг аргачлалд тусгаагүй.

⁵⁸ Зохиогчийн эрхийн тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээний тайлан

⁵⁹ Патентын тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээний тайлан

⁶⁰ Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээний тайлан

⁶¹ Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээний тайлан

График 17. Хуулийн төслөөс үр нөлөөг тооцох хэсгээ тогтоосон байдал, үнэлгээний шалгуур үзүүлэлт тус бүрээр




Ойлгомжтой байдал болон харилцан уялдаа шалгуур үзүүлэлтийг ашиглахад дийлэнх буюу 90 ба түүнээс дээш хувьд хуулийн төслийг бүхэлд нь хамарсан байх бол практикт хэрэгжих боломж, зорилгод хүрэх байдал, хүлээн зөвшөөрөгдөх байдал зэрэг үзүүлэлтийн хувьд ихэнхдээ хуулийн төслийг хэсэгчлэн хамарсан байна.

Шалгуур үзүүлэлт ашигласан байдлыг хуулийн төслийн төрлөөр авч үзвэл, анхдагч хуулийн төслийн хувьд ойлгомжтой байдал болон харилцан уялдаа, шинэчилсэн найруулгын хувьд ойлгомжтой байдал, хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хувьд зорилгод хүрэх байдал, ойлгомжтой байдал, харилцан уялдаа гэсэн гурван шалгуур үзүүлэлтийг сонгон хуулийн төслийг бүхэлд нь үнэлсэн байна. Тэрчлэн үр нөлөөний үнэлгээнд анхдагч болон шинэчилсэн найруулгын төслийг хэсэгчлэн, хуульд өөрчлөлт оруулах төслийг бүхэлд хамруулах төлөв ажиглагдаж байна.

IV үе шат: Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх

Үр нөлөөний үнэлгээ хийсний эцэст тухайн хуулийн төслийн практикт хэрэгжих чадамжийг урьдчилан тодорхойлж, цаашид сайжруулах чиглэлийг тогтоох учиртай.

График 18. Үр дүнг үнэлж, зөвлөмж өгөх үе шат



Аргачлалд зааснаар үнэлгээний үр дүнг нэгтгэн зөвлөмж боловсруулах ажлыг дээрх үе шатаар гүйцэтгэнэ. Хамгийн эхний үе шат нь баримт, тоон мэдээ, ярилцлага зэрэг эх сурвалжаар үнэлгээний үр дүнг баримтжуулах юм.

Үр дүнг баримтжуулах

Хүснэгт 17. Үр нөлөөний үнэлгээний IV үе шатанд үр дүнг баримтжуулсан байдал

Үр дүнг баримтжуулсан байдал	Нийт хуулийн төсөл	Эшлэл зүүлт авсан байдал		Эх сурвалж жагсаасан байдал	
		Тоо	Хувь	Тоо	Хувь
Анхдагч хуулийн төсөл	21	12	57.1 хувь	15	71.4 хувь
Шинэчилсэн найруулга	38	18	47.4 хувь	20	52.6 хувь
Хуульд өөрчлөлт оруулах тухай	22	7	31.8 хувь	12	54.5 хувь
Нийт хуулийн төсөл	81	37	45.7 хувь	47	58 хувь

Судалгааны энэ хэсэгт хамаарах 81 хуулийн төслийн 58 хувь нь үр нөлөөний үнэлгээнд ашигласан мэдээллийн эх сурвалжийн жагсаалтыг тайланд хавсаргажээ. Үүнийг хуулийн төслийн төрлөөр задлан авч үзвэл, анхдагч хуулийн төслийн 71 хувь, шинэчилсэн найруулга болон хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 50 гаруй хувьд үр нөлөөний үнэлгээний үр дүнг баримтаар баталгаажуулсан байна.

Харин эх сурвалжийг тухай бүр эшлэл аван дурдсан байдлыг нэгдсэн жагсаалт гаргасантай харьцуулахад 13 орчим хувиар бага байв. Үр дүнг баримтжуулаагүй буюу эшлэл зүүлт аваагүй, эх сурвалж дурдаагүй 34 хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээний тайланг бүрэн үндэслэлтэй гэж үзэхэд эргэлзээтэй бөгөөд энэ үе шатанд аргачлалын хэрэгжилт дулимаг байгааг харуулж байна.

Хүснэгт 18. Үр нөлөөний үнэлгээний үр дүнг баримтжуулсан байдал, эшлэл, эх сурвалжийн тоогоор

Үр дүнг баримтжуулсан байдал	Эшлэлийн тоо (дунджаар)	Эх сурвалжийн тоо (дунджаар)
Анхдагч хуулийн төсөл	9.6	16.1
Шинэчилсэн найруулга	7.6	17.6
Хуульд өөрчлөлт оруулах тухай	5.2	8.8
Нийт хуулийн төсөл	8	14.5

Үнэлгээний тайлангуудад дунджаар 8 эшлэл авч, эх сурвалжийн жагсаалтад 14.5 орчим материал дурдсан байна. Үүнийг хуулийн төслийн төрлөөр авч үзвэл, хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд баримтжуулалт хамгийн хангалтгүй хийгдэж байна. (Хамгийн олон эх сурвалж ашигласан хуулийн төслүүдийг Хавсралт 9-өөс үзнэ үү.)

Үр дүнг үнэлэх

Энэхүү үе шатанд хуулийн төслийн үр нөлөөг сонгон авсан шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үнэлнэ. Судалгаанд хамрагдсан тайлангуудыг харвал, үнэлгээг шалгуур үзүүлэлт тус бүрээр нарийвчлан гүйцэтгэж, нарийн тодорхой дүгнэлт хийсэн сайн жишээ байхад доорх байдлаар ерөнхийлөн дүгнэсэн тохиолдол ч байна.

Хүснэгт 19. Хуулийн төслийн үр дүнг ерөнхийлөн үнэлсэн жишээ

Хуулийн төслийн нэр	Дүгнэлтийн агуулга
2021 оны 01 сарын 29-ний өдөр батлагдсан Музейн тухай хууль	Энэхүү хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх хүрээнд сонгон авсан зүйл заалтууд нь хуулийн үзэл баримтлал, бусад хууль тогтоомж болон нийтээр хэрэглэж хэвшсэн агуулгатай зөрчилдсөн утга бүхий зохицуулалт агуулаагүй байна.
2021 оны 12 сарын 17-ны өдөр батлагдсан Кибер аюулгүй байдлын тухай хууль	Хуулийн төсөл нь тавьсан зорилтдоо хүрэх боломжтой, хуулийн төсөл боловсруулах шаардлагад нийцсэн байдлаар боловсруулагдсан байна.
2023 оны 4 сарын 21-ний өдөр батлагдсан Төрөөс олгох урамшууллаас эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэл суутган төлөх тухай хууль	Хуулийн төсөл дэмжигдэх болон хэрэгжих бүрэн боломжтой гэж дүгнэж байна.

Хуулийн төслийн нэр	Дүгнэлтийн агуулга
2021 оны 5 сарын 06-ны өдөр батлагдсан Хоршооны тухай хууль	Хуулийн төслийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандсан тухай тайлан, үнэлгээний дүгнэлт, хуулийн төслийн үзэл баримтлал, бусад холбогдох бүрдлийн хамт хуулийн төслийг өргөн мэдүүлэх нь зүйтэй байна.
2023 оны 5 сарын 16-ны өдөр батлагдсан Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль	Хуулийн төслийн хүрээнд төрөөс үзүүлэх бүртгэл, мэдээллийн санг үүсгэх, улмаар дэмжлэгийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хуулийн өөрчлөлтийг дагалдах бусад хуулийн төсөлд тусгах замаар шийдвэрлэх шаардлагатай гэж үзлээ.
2024 оны 6 сарын 05-ны өдөр батлагдсан Малчны тухай хууль	Малчны тухай хуулийн төслийг дагалдан нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай хуулийн төслийг боловсруулж, өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.

Үр нөлөөний үнэлгээг ийнхүү хэлбэр төдий гүйцэтгэх нь хуулийн төслийн нөлөөлөл, хэрэгжих чадамжийг бодитоор үнэлж чадахгүйд хүргэж, хууль хэрэгжих явцад урьдчилан тооцоогүй хүндрэл бэрхшээл үүсэх, цаашлаад иргэд, хуулийн этгээдийн эрх, ашиг сонирхол зөрчигдөх эрсдэл дагуулж байна.

Зөвлөмж өгөх

График 19. Үр нөлөөний үнэлгээний дүнд зөвлөмж өгсөн байдал



Үр нөлөөний үнэлгээний тайлан бүхий нийт 81 хуулийн төслийн ердөө 51 хувьд нь тухайн үнэлгээндээ суурилан зөвлөмж боловсруулжээ. Анхдагч хуулийн төслийн 71 хувь, шинэчилсэн найруулгын 93 хувь, нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 24 хувьд үнэлгээний дүнд үндэслэн ямар нэг зөвлөмж боловсруулсан байна.

Үүнээс үзэхэд, үр нөлөөний үнэлгээний үр дүнд үндэслэн хуулийн төслийг сайжруулахад чиглэсэн зөвлөмж өгөх байдал хангалтгүй байна.

Зөвлөмж өгөөгүй тохиолдлуудад ажиглагдсан онцлох зүйлс

- Үр нөлөөний үнэлгээгээр хуулийн төслийг сайжруулах, өөрчлөлт оруулах зөвлөмж өгөөгүй үндэслэлийг авч үзвэл, “Хуулийн төслийн үнэлгээний дүгнэлтэд тулгуурлан хуулийн төслийн зохицуулалтыг хасах, нэмэх, өөрчлөх, тодруулах шаардлагагүй гэж үзлээ”,⁶² “Хуулийн төсөл нь хуулийн төслөөр тавьсан зорилтдоо хүрэх боломжтой, хуулийн төсөл боловсруулах шаардлагад нийцсэн байдлаар боловсруулагдсан байна” гэх мэт дүгнэлт нийтлэг байна.
- Түүнчлэн таван хуулийн төсөлд “Санхүү, эдийн засаг, хууль зүйн шинжлэх ухаан харилцан шүтэлцээтэй хөгждөг салбарууд бөгөөд хуулийн төсөлд тухайн чиглэлээр мэргэшсэн судлаач эрдэмтэд, бизнес эрхлэгчид өөрсдийн санал дүгнэлтийг гаргах нь хууль тогтоомжийн хэрэгжилт, үр нөлөөнд чухал ач холбогдолтой гэсэн зөвлөмжийг өгч байна”⁶³ гэсэн нэгэн ижил ерөнхий тайлбар өгсөн нь анхаарал татаж байна.

Зөвлөмж өгсөн тохиолдолд ажиглагдсан онцлох зүйлс

- Үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийг шалгуур үзүүлэлт тус бүрээр биш нэгтгэж, тоймлож гаргах нь нийтлэг байна. Энэ нь үнэлгээний чанар, үндэслэл, шалгуур үзүүлэлт тус бүрээр нарийвчилсан үнэлгээ хийсэн эсэхэд эргэлзээ төрүүлж байна. Жишээлбэл, 2024 оны 06 сарын 05-ны өдөр батлагдсан Шүүх байгуулах тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээнд “зардлын тооцоо” гэсэн шалгуур үзүүлэлтийг сонгож аваагүй атлаа “хуулийн төсөлтэй холбогдуулан хүний нөөц, барилга байгууламж, төсөв хөрөнгөтэй холбоотой зардал гарахаар байгааг анхаарч хуулийн төсөл батлагдсаны дараа хэрэгжих хугацааг бодитоор тооцох” гэсэн зөвлөмж өгчээ.
- Харин шалгуур тус бүрээр зөвлөмж өгсөн цөөн тохиолдол байгаа нь Хууль зүйн туслалцааны тухай, Хүний эрхийг хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай, Нийслэл Улаанбаатар хотын автозамын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулиуд байв.

⁶² Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай хуулийн төсөл

⁶³ Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай, Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай, Хөрөнгийн үнэлгээний тухай, Үйлдвэрлэл технологийн эрх зүйн байдлын тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулиуд

- Түүнчлэн 2024 оны 06 сарын 05-ны өдөр батлагдсан Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн үнэлгээний хүрээнд нийт дөрвөн төрлийн санал дэвшүүлсэн боловч “уг үр нөлөөний судалгааны хүрээнд дэвшүүлсэн дээрх саналууд нь хуулийн төслийн үр нөлөөг сайжруулахад чиглэсэн хараат бус судалгааны байр суурь бөгөөд одоогийн хуулийн төслийн үнэ цэн, ач холбогдлыг бууруулахгүй болохыг дурдах нь зүйтэй” гэсэн нэгдсэн дүгнэлт хийсэн нь өгсөн зөвлөмжийнхөө ач холбогдлыг сулруулжээ.
- Мөн эсрэгээрээ зөвлөмжийн дагуу арга хэмжээ авах шаардлагатайг анхааруулсан тохиолдлууд цөөнгүй байв. Жишээ нь, 2021 оны 07 сарын 07-ны өдөр батлагдсан Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн үнэлгээний тайланд “Зөвлөмж хэсэгт дурдсан хуулийн төслийн зарим зүйл, заалтыг дахин нягтлах, боловсруулалт хийх, шаардлагатай зохицуулалтыг нэмж оруулах шаардлагатай гэж дүгнэлээ” гэж, 2023 оны 07 сарын 07-ны өдөр батлагдсан Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн төслийн тайланд “хуулийн нэр томъёоны тодорхойлолтод нэмэлт оруулах асуудлыг судлах” гэж, 2024 оны 06 сарын 05-ны өдөр батлагдсан Хүннү хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн үнэлгээнд “судалгааны зөвлөмж хэсэгт дурдсан хуулийн төслийн зарим зүйл, заалтыг дахин нягтлах, боловсруулалт хийх, зөрчилтэй зүйл заалтын зөрчлийг арилгах шаардлагатай” гэж, 2021 оны 07 сарын 07-ны өдөр батлагдсан Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн тайланд “зарим заалтад нэмэлт зохицуулалт хийх, ойлгомжгүй үгийг өөрчлөн засварлах зэрэг санал гарсан тул хуулийн төслийн зарим зүйл, заалтыг дахин боловсруулах” гэж, 2023 оны 05 сарын 04-ний өдөр батлагдсан Аялал жуулчлалын тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээний тайланд “хуулийн төслийг боловсронгуй болгох, чанарыг сайжруулах чиглэлээр өөрчлөлт оруулах нь зүйтэй” гэсэн зөвлөмжийг тус тус өгсөн байна.
- Хуулийн төсөл боловсруулж буй байгууллага үр нөлөөний үнэлгээг өөрөө хийж, өөрийн эрх хэмжээг нэмэгдүүлэхэд чиглэсэн зөвлөмж өгсөн тохиолдлууд байв. Тухайлбал, 2021 оны 05 сарын 21-ний өдөр батлагдсан Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн

төслийн үр нөлөөний үнэлгээг Монгол банк хийсэн байх бөгөөд “Хуулийн төсөлд эрх бүхий байгууллагаас баталсан ерөнхий нөхцөлийн агуулга, шаардлагад нийцүүлэн банк, эрх бүхий хуулийн этгээдээс баталсан ерөнхий нөхцөлийг холбогдох хууль тогтоомж, олон улсын стандартад нийцээгүй тохиолдолд хэрэглэгч, хадгаламж эзэмшигчийн эрх ашгийг хамгаалах зорилгоор Монгол банк, Санхүүгийн зохицуулах хороо өөрчлөх боломжтой байх зохицуулалтыг хуулийн төсөлд тусгах” гэж, 2021 оны 07 сарын 02-ны өдөр батлагдсан Кино урлагийг дэмжих тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам хийсэн байх бөгөөд “Киноны салбарын дүн мэдээг нэгтгэх, статистикийн мэдээллийг боловсруулах, киноны хөгжлийг дэмжих судалгаа, шинжилгээ хийх, киноны мэдээллийн сан үүсгэх зэрэг хууль хэрэгжих явцад гарч болох хүндрэлтэй асуудал байгааг анхаарч, төрийн болон төрийн бус байгууллага, хуулийн этгээдийн хоорондын хамтын ажиллагааг сайжруулахад Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага бодлогоор дэмжлэг үзүүлэх” гэжээ. Нэг талаас үр нөлөөний үнэлгээг тухайн салбарын зохицуулах байгууллага эсхүл аль нэг төрийн байгууллага, түүний нэгж гүйцэтгэх нь судалгааны бодитой, үндэслэлтэй байдлыг хангах ач холбогдолтой байж болох ч нөгөө талаас ашиг сонирхлын зөрчил үүсгэж болзошгүйг анхаарах хэрэгтэй.

- Тэрчлэн үр нөлөөний үнэлгээгээр тухайн хууль нь зөрчил, сөрөг үр дагавар үүсгэж болзошгүй гэж үзсэн боловч үүний дагуу төсөлд өөрчлөлт оруулаагүй тохиолдол байна. Тодруулбал, 2024 оны 04 сарын 12-ны өдөр батлагдсан Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн үнэлгээний тайланд “1. Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид газар ашиглуулахгүй байх зохицуулалтыг Газрын тухай, Ашигт малтмалын тухай, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай болон холбогдох бусад хуулиудад оруулах тохиолдолд гадаад, дотоодын хөрөнгө оруулагчийг ялгаварласан, эрх зүйн байдлыг дордуулсан үндэслэлээр Монгол Улсын олон улсын гэрээ, Монгол Улсын Үндсэн хуулийн зарим заалтыг хөндөж болзошгүй байна. 2. Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид газар ашиглуулахтай холбоотой хуулийн зохицуулалтыг хүчингүй болгох тохиолдолд Газрын тухай, Ашигт малтмалын тухай хуулийн дагуу газар ашиглаж байсан гадаадын хөрөнгө оруулагчтай байгуулсан гэрээ тусгай зөвшөөрлийн хугацаа дуусмагц тухайн газар дээрх барилга байгууламж, бусад эд хөрөнгийг тухайн газар

дээр ашиглах эрх мөн дуусгавар болох тул өмчлөгч нь гэрээнд заасны дагуу арга хэмжээ авах эсхүл шүүх арбитра хандах боломжтой болно. 3. Гадаадын хөрөнгө оруулагчид газар ашиглуулахгүй болох нь хууль зүйн болон эдийн засгийн зарим сөрөг үр дагавар үүсгэж болзошгүй байх тул гадаадын хөрөнгө оруулагчид зөвхөн ЗГ-ын шийдвэрээр тодорхой нөхцөл, болзолтойгоор газар ашиглуулах, гэрээний хэрэгжилтэд хяналт сайн тавих, хэрэв гэрээний үүргээ биелүүлээгүй бол гэрээг хугацаанаас нь өмнө цуцалдаг байх, газар ашиглуулах гэрээний ерөнхий хугацааг Хөрөнгө оруулалтын тухай хуульд зааснаас богиносгох нь зүйтэй гэж үзэж байна” гэсэн зөвлөмж өгсөн нь батлагдсан хуулийн төсөлд тусаагүй байна.

- Хуулийн төслийг хүчин төгөлдөр үйлчилж буй бусад хууль тогтоомжид нийцүүлэх зөвлөмж өгсөн тохиолдлуудыг Хавсралт 12-оос үзнэ үү.
- Зөвлөмж оновчгүй буюу үр нөлөөний үнэлгээ хуулийн төсөлд шууд хамааралгүй тохиолдол мөн гарав. (Дэлгэрэнгүйг Хавсралт 10-аас үзнэ үү.) Түүнчлэн ерөнхий гэж болохуйц зөвлөмж өгсөн тохиолдлуудыг дурдвал, 2024 оны 06 сарын 05-ны өдөр батлагдсан Малчны тухай хуулийн үр нөлөөний үнэлгээний тайланд “хуулийн төсөлд туссан бэлчээрийн газар, отрын бүс нутгийн ашиглалттай холбоотой зарим зохицуулалтыг Газрын тухай хуультай уялдуулахад илүү анхаарах нь зүйтэй; Малчны санаачилгаар хуримтлалын сан үүсгэх, төвлөрүүлсэн орлогоос зарцуулалт хийх асуудлыг санхүү, хөрөнгө оруулалтын холбогдох хууль тогтоомжтой уялдуулан нягталж үзэх нь зохистой гэж зөвлөж байна” гэжээ.
- Дагалдах хуулийн төслийн асуудлаар үр нөлөөний үнэлгээний хүрээнд зөвлөмж өгсөн цөөн тохиолдол байна. Гэвч эдгээр нь зарчмын шинжтэй өөрчлөлт оруулах агуулгатай бус зөвхөн хэлбэрийн шинжтэй өөрчлөлтийг түлхүү санал болгожээ. (Дэлгэрэнгүйг Хавсралт 11-ээс үзнэ үү.) Иймд цаашид үр нөлөөний үнэлгээнд дагалдах хууль хамаарах эсэх, хэрэв тийм бол хэр хэмжээнд хамаарахыг тодорхой болгон хуульчлах нь зүйтэй.
- Түүнчлэн зөвлөмжид олон нийтийн хэлэлцүүлэгтэй холбоотой асуудлыг хөндсөн тохиолдол байгаа нь 2021 оны 07 сарын 02-ны өдөр батлагдсан Хөдөлмөрийн тухай хуулийн үнэлгээний тайланд өгсөн “Санал авах, хэлэлцүүлэг явуулах явцад ирүүлсэн санал, хэлэлцүүлэгт оролцсон

этгээдүүдээс хуулийн төслийг ойлгомжтой болгох талаар гарсан саналыг бусад хуулийн зүйл заалттай уялдуулан тусгах талаар хамгийн боломжтой зохицуулалтыг томьёолох” гэсэн зөвлөмж байв. (Дэлгэрэнгүйг Хавсралт 13-аас үзнэ үү.)

Үнэлгээний зөвлөмжийг хуулийн төсөлд тусгасан байдал

2022 оны 12 сарын 16-ны өдөр батлагдсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээгээр “харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд уг хуулийн төслийг хүчин төгөлдөр үйлчилж буй бусад хууль тогтоомж болон Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцтой нийцүүлэхтэй холбоотой зөвлөмж өгчээ. Тодруулбал, “Монгол Улсын нэгдэн орсон Олон улсын конвенц, зөвлөмжид бүрэн нийцүүлэхэд анхаарах. Тухайлбал, Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц, зөвлөмжтэй Эрүүгийн хуулийн 21.12 дугаар зүйлд заасан Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн шинжийг бүрэн нийцүүлж тодорхойлж чадсан эсэх, Арьс үндсээр алагчлах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай конвенц болон конвенцыг хэрэгжүүлэхтэй холбоотой конвенцын хорооноос өгсөн зөвлөмжид Эрүүгийн хуулийн 14.1 дүгээр зүйлд заасан Ялгаварлан гадуурхах гэмт хэргийн тодорхойлолтыг бүрэн нийцүүлэх, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 19 дүгээр зүйл, Пактын хорооноос зөвлөмжид “Гүтгэлгийг бүрэн утгаар нь Эрүүгийн хуулиас хасаж, гэмт хэрэгт тооцохгүй байх, гүтгэлэг нь эрх чөлөөг хязгаарлах үндэслэл болохгүй байх, Эрүүгийн хуульд хэвээр байх гүтгэлэгтэй холбоотой бусад заалт нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг боогдуулж байгааг анхаарах.” гэснийг анхаарах, Авлигын эсрэг НҮБ-ын конвенцод авлигын гэмт хэргийн субъектийг нийцүүлэхэд анхаарах” гэсэн зөвлөмж өгсөн боловч хуулийн төсөл тусгагдаагүй байна.

Явцын дүгнэлт: Үр нөлөөний үнэлгээ

- Энэхүү судалгаанд хамрагдсан нийт 98 хуулийн төслийн 82.7 хувьд нь үр нөлөөний үнэлгээ хийгдсэн нь хуулийн төсөл боловсруулах шатанд уг судалгааг хийж хэвшсэнийг илтгэж байна.
- Гэвч үнэлгээний хүрээнд аргачлалд заасан шалгуур үзүүлэлтийг сонгон авахдаа тухайн хуулийн зохицуулах асуудлын онцлогт нийцүүлэн бодитой, үндэслэлтэйгээр оновчтой сонгох байдал хангалтгүй байв. Түүнчлэн, аль нэг шалгуур үзүүлэлтийг сонгон авах шаардлагагүй гэж үзсэн тохиолдолд түүний үндэслэлийг тайлбарлах явдал хангалтгүй

байна. Үүнээс харахад үр нөлөөний үнэлгээний аргачлалыг эргэн харж, шалгуур үзүүлэлтүүд, түүнийг сонгоход баримтлах шаардлагыг илүү тодорхой болгох нь зүйтэй байна.

- Сонгосон шалгуур үзүүлэлтүүдийн хүрээнд үр нөлөөг үнэлэхдээ дийлэнх тохиолдолд хуулийн төслийн зөвхөн тодорхой хэсгийг сонгон авч байгаа нь хуулийн төслийн үр нөлөөг тэр бүр бүхэлд нь үнэлж чадахгүй байгааг харуулж байна.
- Судалгааны үр дүнг баримтжуулах шатанд үнэлгээнд ашигласан мэдээлэл, тоо баримт, дүгнэлт, оролцогчид, мэргэжилтнүүдийн санал зэрэг материалыг хавсаргах, эх сурвалжийг дурдах байдал хангалтгүй байна. Энэ нь үр нөлөөний үнэлгээний бодитой, үнэн зөв, үндэслэлтэй байдлыг бууруулж байна.
- Үр нөлөөний үнэлгээ хийсэн болон хуулийн төслийг сайжруулахтай холбоотой ямар нэг санал, зөвлөмж өгсөн боловч тэр нь үнэлгээний үр дүнтэй холбоогүй, эсвэл хэт ерөнхий, хэлбэрийн төдий байгаагаас ач холбогдол багатай байна.
- Нарийн тодорхой зөвлөмж өгсөн ч тэдгээрийг хуулийн төсөлд тэр бүр тусгахгүй байгаа нь эргээд үнэлгээний ач холбогдлыг бууруулах эрсдэлтэй.
- Түүнчлэн үр нөлөөний үнэлгээ хийхээс өмнө хуулийн төслийн анхны хувилбарыг нийтэд ил тод болгодоггүй тул үнэлгээний үр дүнд ямар өөрчлөлт оруулж, хэрхэн сайжруулсныг мэдэх боломжгүй байна.
- Үр нөлөөний үнэлгээг хуулийн төслийг боловсруулсан этгээд болон хуулийн хэрэгжилтийг хариуцах төрийн байгууллага өөрөө гүйцэтгэж, өөрийн бүрэн эрхийг өргөжүүлэх зөвлөмж өгсөн тохиолдол гарч байгаа тул хууль тогтоомжийн судалгаа, шинжилгээг гүйцэтгэхэд сонирхлын зөрчлөөс сэргийлэх зохицуулалт бий болгох нь зүйтэй.
- Хуулийн төслийг зөвлөмжийн мөрөөр сайжруулсан, өөрчлөлт оруулсан эсэхийг хянах тогтолцоо байхгүй байна. Зөвлөмжийг тусгаагүй нөхцөлд тухайн хуулийн төслийг шаардлага хангасан гэж үзэх үү, ийм төслийг өргөн мэдүүлж болох уу гэдэг асуудал бүрхэг байна. Үүний улмаас хуулийн төсөл холбогдох шаардлагад нийцсэн эсэхийг ерөнхийлөн дүгнэх жишиг тогтсон байна. Иймд цаашид зөвлөмжийг хуулийн төсөлд

заавал тусгах, тусгаагүй тохиолдолд түүний шалтгаан, үндэслэлийг тайлбарлах шаардлагыг хуульчилж, үүнд хяналт тавих механизмыг бүрдүүлэх шаардлагатай.

- Ямар тохиолдолд хуулийн төслийг өргөн мэдүүлж болохгүй талаар ХТХ-д тодорхой заагаагүй тул хуулийн төслийн чанарыг үнэлэх гол судалгаа болох үр нөлөөний үнэлгээний шалгуур үзүүлэлтийн нийт хэдэн хувийг ямар түвшинд хангасан тохиолдолд тухайн хуулийн төслийг өргөн мэдүүлж болохыг нарийвчлах шаардлагатай байна.
- Мөн судалгааны баг хуулийн төслийг өргөн мэдүүлэх, батлах нь зүйтэй гэсэн дүгнэлт гаргах нь зохистой эсэхийг анхаарах нь зүйтэй. Учир нь хуулийн төслийг өргөн мэдүүлэх нь хууль санаачлагчийн, батлах нь хууль тогтоогчийн бүрэн эрх бөгөөд үр нөлөөний үнэлгээний гол зорилго нь хуулийн төслийг сайжруулах санал боловсруулах юм.

ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛИЙН СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭНД ТАВИХ ХЯНАЛТ

Хуулийн төсөл боловсруулах ажиллагаанд тавих хяналт, үнэлгээ нь хууль тогтоох ажиллагааны ил тод, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэх, хуулийн төслийн чанарыг сайжруулах хүчин зүйл болдог.⁶⁴

Хуулийн төслийн судалгаа, шинжилгээний чанарт хууль санаачлагчаас эхлээд төсөл боловсруулах шатанд хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон ЗГ-ын Хэрэг эрхлэх газар, өргөн мэдүүлэх шатанд УИХТГ хяналт тавих үүрэгтэй.

Судалгааны өмнөх хэсгүүдэд дурдсанчлан хуулийн төсөл боловсруулахад холбогдох судалгаа, шинжилгээ хийх байдал нэмэгдэж байгаа нь сайшаалтай ч судалгааны чанар төдийлөн хангалттай бус хэвээр байна. Энэ нь нэг талаараа хуулийн төслийг боловсруулах болон өргөн мэдүүлэх шатанд хэрэгжиж буй институтийн хяналт сул байгаатай холбоотой.

Өргөн мэдүүлсэн хуулийн төслийн бүрдүүлбэрийг зөвхөн баримт бичгийг бүрэн хавсаргасан эсэх хүрээнд шалгахад бус тэдгээрийн агуулга, чанарыг үнэлдэг эсэх нь тодорхойгүй байв. Ялангуяа, хууль тогтоомжийн төсөл боловсруулах шатанд хийгдэх судалгааны хувьд зохих ёсоор хийгдсэн эсэх буюу холбогдох аргачлалыг бүрэн баримталсан эсэхийг шалгадаггүй байна.

Хууль тогтоомжийн судалгаа шинжилгээний агуулгын хяналт сул байгаа энэ нөхцөлд олон нийтийн хяналт чухал болохыг харгалзан хууль тогтоомжийн төслийн судалгааны тайланг ил тод болгож хэвших нь чухал. Мөн тайланд судалгаа гүйцэтгэсэн этгээд болон хугацааг тусгах нь зүйтэй.

⁶⁴ Government's analysis, assessment and research activities (Finnish Government), Towards, High-Quality Law Drafting: Quality Indicators of the Law Drafting Process in Finland – English Summary (2023) p.7. https://julkaisut.valtioneuvosto.fi/bitstream/handle/10024/164973/VNTEAS_2023_37.pdf?sequence=1&isAllowed=y last accessed on 9 February 2025.


Иймд судалгааны энэ бүлэгт хуулийн төслийн судалгаа гүйцэтгэсэн этгээд болон хугацааг тодорхойлох замаар институтийн хяналттай холбоотой зарим асуудлыг хөндөхийг зорилоо.

Судалгаа гүйцэтгэж буй этгээдийн тухайд

Хуулийн төслийн тооцоо, судалгаа гүйцэтгэсэн этгээдийг холбогдох тайланд тусгах нь олон нийтийг мэдээллээр хангах, судлаачийг хариуцлагажуулах, судлаач нь тухайн судалгааг гүйцэтгэх бие даасан, хараат бус, сонирхлын зөрчилгүй этгээд мөн эсэхийг тодорхойлоход ач холбогдолтой. Улмаар судалгаа гүйцэтгэгчийн туршлага, чадвар, хараат бус байдал зэрэг нь судалгааны чанар болон судалгааны үр дүнд хүргүүлэх зөвлөмжид шууд нөлөөтэй юм.

Дунджаар нийт судалгааны 71 хувьд судалгаа гүйцэтгэсэн этгээдийн мэдээллийг дурдаагүй бөгөөд тэдгээрийг судалгааны төрлөөр ялган доорх графикт харуулав.

График 20. Тайланд судалгаа гүйцэтгэсэн этгээдийг дурдсан байдал



Судалгааны төрлөөр ялган харвал, тандан судалгааны 67, зардлын тооцооны 86, үр нөлөөний үнэлгээний 61 хувьд судалгааг гүйцэтгэгчийн мэдээлэл тодорхойгүй байна. Харин судалгааг гүйцэтгэсэн этгээдийг дурдсан тайлангууд нь агуулгын хувьд гүйцэтгэгчийн мэдээллийг дурдаагүй тайлангуудаас илүү өргөн бөгөөд илүү олон баримт мэдээлэлд тулгуурласан, холбогдох аргачлалуудын алхам тус бүрийг баримталсан шинжтэй байгааг анхаарах нь зүйтэй.

График 21. Судалгаа гүйцэтгэсэн этгээд




Гүйцэтгэгчийг дурдсан тайлангийн дунджаар 71 хувийг хуулийн төсөл санаачлагч, тухайн хуулийн хэрэгжилтийг хариуцдаг төрийн байгууллага болон салбарын зохицуулагч гүйцэтгэсэн байх бол үлдэх 30 орчим хувийг хараат бус судлаач, судалгааны болон төрийн бус байгууллага гүйцэтгэжээ. Хууль тогтоомжийн судалгааг тухайн хуулийг санаачлагч, хууль хэрэгжүүлэгч, тухайн салбарын зохицуулагч байгууллага зэрэг төрийн байгууллага гүйцэтгэх нь сонирхлын зөрчил үүсгэж болзошгүй талаар судалгааны өмнөх хэсэгт дурдсан болно.

Судалгаа гүйцэтгэсэн этгээдийг судалгааны төрлөөр авч үзвэл хэрэгцээ шаардлагын тандан судалгааны 78, зардлын тооцооны 54, үр нөлөөний үнэлгээний 81 хувийг төрийн байгууллага гүйцэтгэсэн байна. 2025 оны 06 сарын 27-ны өдөр Хууль тогтоомжийн тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр Хууль санаачлагч хууль тогтоомжийн төслийн үр нөлөөний үнэлгээг хөндлөнгийн судлаач, хуулийн этгээдээр гүйцэтгүүлэхээр заасан нь хуулийн төслийн үр нөлөөг хараат бусаар тодорхойлоход ач холбогдолтой зохицуулалт болжээ.

Судалгаа гүйцэтгэж буй хугацааны тухайд

Судалгааг яг тухайн хуулийн төсөлд зориулж, ХТтХ болон аргачлалд заасан хугацаанд гүйцэтгэх нь тоо, баримт хуучраагүй, тухайн нөхцөл байдал, чиг хандлагыг зөв тодорхойлоход чухал нөлөөтэй. Гэтэл судалгаа гүйцэтгэсэн хугацааг тайланд дурдаагүйгээс тухайн судалгаа хэзээ хийгдсэнийг мэдэх боломжгүй нөхцөл гарч байна.

График 22. Тайланд судалгаа гүйцэтгэсэн хугацааг дурдсан байдал



Судалгааны тайлангийн дунджаар 49 хувьд нь судалгаа гүйцэтгэсэн хугацааг дурдаагүй байгаа нь судалгааг яг тухайн хуулийн төсөлд зориулан, цаг хугацааны хувьд хэт түрүүлж эсхүл хоцрогдолгүйгээр гүйцэтгэсэн эсэхийг тодорхойлох боломжийг хязгаарлаж байв.

Судалгааны төрлөөр авч үзвэл, тандан судалгааны 26, зардлын тооцооны 87, үр нөлөөний үнэлгээний 34 хувийг яг хэзээ хийснийг мэдэх боломжгүй байна.

Судалгаа гүйцэтгэсэн хугацааг хууль батлагдсан хугацаатай ерөнхийлөн харьцуулж үзэхэд дунджаар 16.3 сарын өмнө хийгдсэн байна. Үүнийг хуулийн төслийн төрлөөр харвал, анхдагч хуулийн төслийн хувьд дунджаар 7.8 сар, шинэчилсэн найруулгын хувьд 25.2 сар, хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хувьд 16.3 сарын өмнө судалгаа хийгдсэн байна.

Судалгаа нь хуулийн төсөл батлагдахаас даруй гурав ба түүнээс олон жилийн өмнө хийгдсэн хуулийн төсөл байгаа нь бүгд шинэчилсэн найруулгын төсөл байв.

Хүснэгт 20. Судалгаа нь хуулийн төсөл батлагдахаас гурав ба түүнээс олон жилийн өмнө хийгдсэн хуулиуд

№	Хуулийн төслийн нэр	Баталсан огноо	Судалгаа хийгдсэн огноо			Дундаж хугацаа жилээр
			Суурь судалгаа	Зардлын тооцоо	Үр нөлөөний үнэлгээ	
1	Зохиогчийн эрхийн тухай хууль	2021.05.06	2017	2019	2017	3,3
2	Патентын тухай хууль	2021.05.06	2017	2018	Тодорхойгүй	3.5
3	Хөдөлмөрийн тухай хууль	2021.07.02	2017	2017	Тодорхойгүй	4
4	Таримал ургамлын үр, сортын тухай хууль	2021.10.29	2018	Тодорхойгүй	Тодорхойгүй	3
5	Эрдэнэсийн сангийн тухай хууль	2022.04.22	2019	2019	Тодорхойгүй	3
6	Далай ашиглах тухай хууль	2022.06.03	2018	2018	Тодорхойгүй	4
7	Хөрөнгийн үнэлгээний тухай хууль	2022.06.17	2018	Тодорхойгүй	Тодорхойгүй	4
8	Хууль зүйн туслалцааны тухай хууль	2022.07.01	2018	Тодорхойгүй	Тодорхойгүй	4
9	Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих тухай хууль	2022.07.05	2018	2018	Тодорхойгүй	4
10	Шүүх шинжилгээний тухай хууль	2022.12.23	2018	Тодорхойгүй	Тодорхойгүй	4
11	Боловсролын ерөнхий хууль	2023.07.07	2020	Тодорхойгүй	Тодорхойгүй	3

Судалгааг хуулийн төсөл батлагдахаас гурав ба түүнээс дээш жилийн өмнө гүйцэтгэсэн дээрх тохиолдолд нийтлэг ажиглагдаж буй дутагдал нь судалгаанд ашигласан статистик, мэдээлэл хуучирсан байх бөгөөд энэ нь судалгааны цаг үедээ нийцсэн, үндэслэл бүхий байдлыг сулруулж, зохицуулах харилцаа, эрх ашиг нь хөндөгдөж буй этгээдүүдэд тулгарч буй асуудлыг оновчтой тодорхойлох боломжийг бууруулж байна. Тухайлбал, 2021 оны 07 сарын 02-ны өдөр батлагдсан Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын тандан судалгааны тайланд Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2013-2015 оны хяналт шалгалтын тайлан, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооноос гаргасан 2003 оны Хүүхдийн хөдөлмөрийн талаарх судалгааны тайлан, 2014

онд хийгдсэн Туслах малчны хөдөлмөрийн харилцааны судалгааны тайлан зэргийг ашиглажээ.

Ийнхүү судалгааг гүйцэтгэж буй этгээд болон хугацааг судалгааны тайланд дурдах байдал хангалтгүй бөгөөд энэ нь судалгааны бодитой, үнэн зөв байдалд эргэлзээ төрүүлж, ил тод, хариуцлагатай байдал, сонирхлын зөрчлөөс ангид байх зэрэгт сөргөөр нөлөөлж байна.

Хуулийн төслийн бүрдүүлбэр, түүний ил тод байдал

Улсын Их Хурлын албан ёсны хуудас forum.parliament.mn болон Улсын Их Хурлын Тамгын газрын dparliament.mn цахим хуудас дахь хуулийн төслийн бүрдүүлбэр, түүнд агуулагдах баримт бичгийн нэршил болон формат харилцан адилгүй байв. Мөн холбогдох судалгаа шинжилгээний цэсэд тайлангийн урьдчилсан төсөл буюу эцэслэгдээгүй хувилбар хавсаргасан⁶⁵, огт өөр тайлан байршуулсан, тайланг хэвлэмэл хэлбэрээр гаргасан тул цахимд байршуулах шаардлагагүй гэж үзсэн⁶⁶ тохиолдол цөөнгүй байв.

Хуулийн төслийн бүрдүүлбэр бүрэн бөгөөд ойлгомжтой, нэг стандарт бүхий цэгцтэй байх нь нэг талаар иргэдийн мэдэх эрхийг хангах, нөгөө талаар судалгаа шинжилгээний эргэлтийг нэмэгдүүлэх ач холбогдолтойн зэрэгцээ ийнхүү цахим хуудсанд байршуулсан мэдээлэл нь хууль тогтоомжийн төслийн архив, цахим мэдээллийн сан болох тул нэгдсэн стандарт баримтлах учиртай.

Судалгааны энэхүү бүлэгт товч дурдсанчлан хуулийн төслийн судалгаа шинжилгээнд үндэслэсэн байх зарчмын хэрэгжилтэд институтийн хяналт чухал үүрэгтэйг анхаарч цаашид нарийвчлан судалж, хэрэгжилтийн байдлыг тодорхойлох шаардлагатай байна.

⁶⁵ 2024 оны 01 сарын 17-ны өдөр батлагдсан Органик бүтээгдэхүүний тухай хуулийн шинэчилсэн найруулгын Зардлын тооцооны тайлан.

⁶⁶ 2020 оны 12 сарын 24-ний өдөр батлагдсан Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн Зардлын тооцооны тайлан.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Хууль тогтоомж нь хүний эрхийг хангах, нийгмийн харилцааг зохицуулах гол баримт бичиг болохын хувьд судалгаа, шинжилгээнд үндэслэсэн, бодит хэрэгцээ, нөхцөл байдалд тохирсон, үр нөлөөтэй хэрэгжих чадамжтай байх учиртай. Монгол Улсын хувьд 2015 оны 05 сарын 29-ний өдөр батлагдсан Хууль тогтоомжийн тухай хуульд хуулийн төсөл санаачлан боловсруулах үйл ажиллагаанд баримтлах зарчмуудыг тодорхойлсны нэг нь судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх зарчим юм. Уг зарчмын бодит хэрэгжилтийг хангах хүрээнд Засгийн газар 2016 оны 01 сарын 16-ны өдрийн тогтоолоор хууль тогтоомжийн судалгаа, шинжилгээний аргачлалуудыг баталсан билээ.

Ийнхүү Хууль тогтоомжийн тухай хууль болон Багц аргачлал мөрдөгдөж эхлээд даруй 10 жилийн хугацаа өнгөрч, тэдгээрийн хэрэгжилт, үр нөлөөг үнэлэн сайжруулах цаг иржээ.

Иймд хууль тогтоомжийн судалгаа, шинжилгээний чанар, үр нөлөөг Хууль тогтоомжийн тухай хууль болон уг зарчмын хэрэгжилтийг хангах гол удирдамж болох Багц аргачлалын хүрээнд үнэллээ. Энэ хүрээнд Улсын Их Хурлын 2020-2024 оны бүрэн эрхийн хугацаанд батлагдсан нийт 1838 хуулиас 98 хуулийн төслийг сонгон авч, судалгаа, шинжилгээний тайланд дүн шинжилгээ хийв. Хуулийн төслийн судалгаа, шинжилгээний тайланг Улсын Их Хурал болон түүний Тамгын газраас эрхлэн хөтөлдөг forum.parliament.mn, dparliament.mn цахим хуудас дахь хуулийн төслийн цахим хувийн хэргээс авч танилцлаа.

Дээрх 98 хуулийн төслийн 55-д нь хэрэгцээ, шаардлагын тандан судалгаа, 15-д хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, 78-д зардлын тооцоо, 81-д үр нөлөөний үнэлгээ тус тус хийгдсэн байна.

Судалгаа хийх шаардлагатай болон шаардлагагүй нөхцөлүүдийн ялгаа төдийлөн тодорхойгүй эсхүл зохион байгуулалтын шинжтэйгээр институтийн хяналтын гадуур өнгөрснөөс холбогдох судалгаа хийгээгүй цөөн хэдэн тохиолдлыг эс тооцвол хууль тогтоомжийн төсөл боловсруулахад судалгаа шинжилгээ хийх соёл төлөвшин тогтжээ. Энэ бол Хууль тогтоомжийн тухай хууль болон Багц

аргачлал хэрэгжиж эхэлснээс хойших 10 гаруй жилд манай улсын хууль тогтоох үйл ажиллагаанд гарсан нэг гол дэвшил мөн.

Гэсэн хэдий ч судалгаа шинжилгээний чанар буюу бүрэн бүтэн, үндэслэл бүхий, хараат бус байдалтай холбоотой анхаарах зүйлс цөөнгүй байгааг судалгааны үр дүн харуулж байна. Эдгээр асуудлыг судалгааны төрөл тус бүрээр багцлан холбогдох бүлэг тус бүрийн төгсгөлд явцын дүгнэлт болгон томъёолсон болно.

Тэрчлэн цаашид хууль тогтоомжийн судалгааны чанар, үр нөлөөг сайжруулахад чиглэсэн дүгнэлт, зөвлөмж боловсруулсан. Зөвлөмжийг агуулгаар нь зохион байгуулалтын асуудлаар, Хууль тогтоомжийн тухай хуулийг сайжруулахад чиглэсэн болон Багц аргачлалыг боловсронгуй болгохтой холбоотой хэмээн ангилан томъёолов.

Энэхүү судалгааг гүйцэтгэх явцад 2025 оны 06 сарын 27-ны өдөр Хууль тогтоомжийн тухай хуульд зарчмын шинжтэй хэд хэдэн асуудлаар нэмэлт, өөрчлөлт оруулсныг дурдах нь зүйтэй. Хуулийн тус өөрчлөлтөд нийцүүлэн Багц аргачлалыг сайжруулах, боловсронгуй болгох хэрэгцээ шаардлага хэвээр байгаа бөгөөд үүнд энэхүү судалгааны дүгнэлт, зөвлөмж зохих хувь нэмэр оруулна гэж найдаж байна.

Зохион байгуулалтын асуудлаар:

Дүн шинжилгээний явцад зохион байгуулалтын шинжтэй арга хэмжээгээр засан сайжруулах боломжтой дараах асуудлууд ажиглагдсан болно. Үүнд:

1. Хуулийн төслүүдийн судалгаа шинжилгээнд багц аргачлалыг ерөнхийд нь баримталсан байх боловч зарим үндсэн үе шат, шаардлагыг алгасах, дутуу гүйцэтгэх явдал нийтлэг байна. Иймд аргачлалыг нэг мөр ойлгож, бүрэн хэрэгжүүлэх чиглэлээр хууль санаачлагчид болон судалгаа шинжилгээний байгууллага, мэргэжилтнүүдэд тогтмол сургалт хийж хэвших нь зүйтэй.
2. Хууль тогтоомжийн төслийн судалгаанд тавих чанарын хяналт буюу захиалагч, бусад институт (хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Засгийн газар, Улсын Их Хурлын Тамгын газар)-ын хяналтыг сайжруулах чиглэлээр холбогдох удирдамж, зааврыг улам нарийвчлан тодотгох хэрэгтэй. Эдгээр удирдамж, зааврыг нийтэд ил тод болгох нь олон нийтийн зүгээс дээрх хяналтын хэрэгжилт, үр нөлөөг үнэлэхэд ач холбогдолтой байна.
3. Улсын Их Хурлын албан ёсны хуудас forum.parliament.mn болон Улсын Их Хурлын Тамгын газрын dparliament.mn цахим хуудсанд байршуулсан

мэдээлэл нь хууль тогтоомжийн төслийн архив, цахим мэдээллийн сан болох тул нэгдсэн стандарт баримтлах нь зүйтэй. Иймд Улсын Их Хурлын Тамгын газар нь өргөн мэдүүлсэн хуулийн төслийн бүрдлийг шалган хүлээн авч, цахимд байршуулах чиг үүргийнхээ хүрээнд хуулийн төслийн бүрдэл тус бүрд тавих шаардлага буюу бүрэн бүтэн байдал, нэршил, хэлбэр (pdf файл гэх мэт)-ийн шаардлагыг багтаасан нэгдсэн стандарт гарган мөрдүүлж болох юм.

4. Энэхүү судалгаанд хамрагдсан хууль тогтоомжийн судалгааны тайлангийн 70 гаруй хувь нь гүйцэтгэгч этгээдийг дурдаагүй байв. Харин судалгаа гүйцэтгэгч этгээдийг дурдсан тайлангууд нь агуулгын хувьд илүү өргөн, баримт мэдээлэлд үндэслэсэн, аргачлалын шаардлагыг илүү баримталсан байгааг дурдах нь зүйтэй. Тайланд судалгааны гүйцэтгэгчийг дурдах нь ил тод байдал, хариуцлагыг нэмэгдүүлэх, сонирхлын зөрчлөөс сэргийлэх ач холбогдолтой.
5. Судалгааг хууль батлагдахаас гурав буюу түүнээс дээш жилийн өмнө хийсэн тохиолдол цөөнгүй байв. Энэ нь судалгаа хийх хугацаанд тавих шаардлага тодорхойгүйтэй холбоотой бөгөөд мэдээлэл хуучраагүй байж тухайн цаг үеийн нөхцөл байдлыг үнэн зөв, бодитой тодорхойлох боломжийг бууруулж байгааг анхаарах нь зүйтэй.
6. Аливаа хуулийн өргөн баригдсан, батлагдсан эсэхээс үл хамааран судалгааны тайланг ил тод болгох нь цаашдын хэлэлцүүлэг, судалгаа шинжилгээнд чухал ач холбогдолтой юм.

Хууль тогтоомжийн тухай хуулийг сайжруулах чиглэлээр:

7. Шинэчилсэн найруулга, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хувьд “зарчмын шинжтэй өөрчлөлт” гэх ойлголтыг нарийвчилж, тандан судалгаа хийх нөхцөлийг нэг мөр тодорхой болгох нь зүйтэй.
8. Хуулийн төслийн эх бичвэр боловсруулагдсаны дараа хийгдэх, тухайн хуулийн хэрэгжих чадамж, хүлээн зөвшөөрөгдөх байдлыг урьдчилан тодорхойлдог зардлын тооцоо болон үр нөлөөний үнэлгээг хууль санаачлагч өөрөө хийж буй практикийг халж, хөндлөнгийн хараат бус этгээдээр гүйцэтгүүлэх нь зүйтэй.

Багц аргачлалыг сайжруулах чиглэлээр:

9. Тандан судалгааны аргачлалыг сайжруулахтай холбоотой санал:

- Хуулийн төслийн судалгааны хүрээнд харьцуулсан судалгаа хийх байдал харилцан адилгүй байна. Харьцуулсан судалгаа гүйцэтгээгүй тохиолдлуудыг харвал, зөвхөн манай улсын онцлогтой холбоотой (тухайлбал, мал аж ахуй, малчдын эрх зүйн байдал гэх мэт) эрх зүйн харилцаа байх тул эдгээр тохиолдолд харьцуулсан судалгаа шаардлагагүй байх нөхцөлийг аргачлалд тусгах боломжтой байна. Тэрчлэн харьцуулсан судалгаа хийсэн дүгнэлт, зөвлөмж нь хэт ерөнхий байх, эсхүл ихэнх тохиолдолд өгсөн зөвлөмж саналыг хуулийн төсөлд харгалзан үзэж тусгадаггүй нь тус судалгааны ач холбогдлыг бууруулж байна.
- Тандан судалгааны хүрээнд хүний эрхийн нөлөөллийг үнэлэхдээ “хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх” гэсэн асуулгад “тийм” гэж хариулсан бол үндэслэлээ заавал тайлбарлах шаардлага тавих нь зүйтэй. Тодруулбал, хүний чухам аль эрхийг, ямар үндэслэл, зүй ёсны зорилгод үндэслэн хэр хэмжээнд хязгаарлах хэрэгцээ шаардлага үүссэнийг тайлбарлах шаардлагыг аргачлалд тусгах;

10. Зардлын тооцоо хийх аргачлалыг сайжруулахтай холбоотой санал:

- Аргачлалд тодорхойлсон иргэн, хуулийн этгээдэд үүсэх зардлын хүрээ хэт явцуу байгааг өргөжүүлэх, түүнчлэн хууль тогтоомжийн өөрчлөлтийг хэрэгжүүлж эхлэхтэй холбоотой шилжилтийн үеийн зардал, зах зээлийн боломж зэрэг бусад боломжит зардлыг нэмж тусгах замаар хуулийн төслийн нөлөөллийг бүрэн, бодитойгоор тооцох, тухайн нөхцөл байдалтай уялдуулан аргачлалыг уян хатан байдлаар хэрэглэх боломжийг бүрдүүлэх нь зүйтэй.
- Зардлын тооцоо хийх аргачлалд үр өгөөжийг хэрхэн тооцохыг заагаагүйгээс тус үзүүлэлт орхигдох нь элбэг байна. Иймд үр өгөөж тооцох дараах хувилбарыг судлан аргачлалд тусгах нь зүйтэй: (i) зардлын тооцооны хүрээнд үр өгөөжийг тусгайлан тооцох, эсхүл (ii) тандан судалгаа, үр нөлөөний үнэлгээ гэх мэт бусад судалгааны хүрээнд тодорхойлогдсон үр өгөөжийг эшлэх замаар зардал, үр өгөөжийн харьцааг заавал тооцох. Тэрчлэн зардал, үр өгөөжийг хооронд нь харьцуулах аргачлалыг нарийвчлан тодорхойлох шаардлагатай байна.

- Зардлын тооцоо хийх аргачлалд зардлыг бууруулах санал боловсруулахад харгалзах нарийвчилсан удирдамж тусгах. Тухайлбал, аргачлалд зардал хуулийн төслийн агуулгатай холбоотой ерөнхий саналаас гадна зардлыг бууруулахтай холбогдуулан тодорхой зүйл, заалтыг өөрчлөхөд чиглэсэн нарийвчилсан санал дэвшүүлж болохыг тусгаж болох юм. Түүнчлэн, зардлыг хуулийн төсөл батлахаас өмнөх шатанд болон хууль хэрэгжүүлэх явцад хэрхэн бууруулах боломжийг тодорхойлох гэх мэт өөрчлөлтийг Зардлын тооцоо хийх аргачлалд тусгах боломжтой.

11. Үр нөлөөний үнэлгээ хийх аргачлалыг сайжруулахтай холбоотой санал:

- Үр нөлөөний үнэлгээний аргачлалд тусгасан шалгуур үзүүлэлтийг сонгоогүй үндэслэлээ тайлбарлах шаардлагыг нэмэх, хуулийн төслийн аль хэсгийг, яагаад, ямар үзүүлэлтээр үнэлэх болсноо заавал тайлбарлах шаардлагыг бий болгох нь зүйтэй.
- Үр нөлөөний үнэлгээ хийсний эцэст хуулийн төслийг сайжруулахад чиглэсэн санал зөвлөмж өгөөгүй тохиолдол түгээмэл байна. Иймд үнэлгээний үр дүнд тулгуурлан хуулийн төслийг сайжруулахтай холбоотой санал зөвлөмж өгөх, түүнийг хуулийн төсөлд тусгах, хэрэв тусгаагүй тохиолдолд шалтгаан, үндэслэлээ тайлбарлах шаардлагыг аргачлалд нэмэх нь зүйтэй.
- Үр нөлөөний үнэлгээ хийхээс өмнөх хуулийн төслийн анхны хувилбарыг нээлттэй болгох замаар үр нөлөөний үнэлгээнд үндэслэн хуулийн төслийг хэрхэн сайжруулсныг харьцуулан дүгнэх боломж бүрдүүлэх нь чухал байна.

ЭХ СУРВАЛЖ

Хууль тогтоомж

1. Монгол Улсын Үндсэн хууль (1992). <https://legalinfo.mn/mn/detail?lawId=367>
2. Хууль тогтоомжийн тухай хууль (2015). <https://legalinfo.mn/mn/detail?lawId=11119>
3. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль (2024). <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17140612614151>
4. "Аргачлал батлах тухай", ЗГ-ын 2016 оны 59 дүгээр тогтоол. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=11993>
5. "Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай" МУИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоол.
6. "Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай" МУИХ-ын 2020 оны 02 дугаар тогтоол. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=14950>
7. "Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлттэй холбогдуулан авах арга хэмжээний тухай" МУИХ-ын 2023 оны 44 дүгээр тогтоол. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16759787858911>
8. "Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай" МУИХ-ын 2021 оны 106 дугаар тогтоол. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16390082532431&type=3>
9. "Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай" МУИХ-ын 2021 оны 12 дугаар тогтоол. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16147375266521>
10. "Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай" МУИХ-ын 2024 оны 181 дүгээр тогтоол. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17333392407821>
11. "Монгол Улсын Их Хурлын 2024-2028 оны Стратеги төлөвлөгөө батлах тухай" МУИХ-ын 2024 оны 42 дугаар тогтоол. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17333367603711>

Дотоод эх сурвалж

12. Р.Оюундэлгэр, Б.Ариунзаяа, “Хууль, тогтоомжийн төслийн ил тод байдал ба олон нийтээр хэлэлцүүлэх шаардлагын хэрэгжилт”, Нээлттэй нийгэм форум, (2025) <https://forum.mn/product/459176>

Гадаад эх сурвалж

13. European Assistance Mission to the Albanian Justice System, Law Drafting Manual: A Guide to the Legislative Process in Albania (2006) <https://ial-online.org/wp-content/uploads/2018/05/Rep.-Albania.pdf>
14. Victoria E. Aitken, An exposition of legislative quality and its relevance for effective development (2013) <https://research.luc.edu/media/lucedu/prolaw/documents/AITKEN%20FINAL%20ARTICLE.pdf>
15. Carey, Maeve P, Cost-Benefit Analysis in Federal Agency Rulemaking (2024) <https://www.congress.gov/crs-product/IF12058>
16. Government’s analysis, assessment and research activities (Finnish Government), Towards, High-Quality Law Drafting: Quality Indicators of the Law Drafting Process in Finland – English Summary (2023) https://julkaisut.valtioneuvosto.fi/bitstream/handle/10024/164973/VNTEAS_2023_37.pdf?sequence=1&isAllowed=y

Цахим эх сурвалж

17. <https://legalinfo.mn/mn>
18. <https://lawforum.parliament.mn/>
19. <https://forum.parliament.mn/>
20. <https://d.parliament.mn/>
21. <https://www.parliament.mn/> v
22. <https://online.hbs.edu/blog/post/cost-benefit-analysis>

Бусад эх сурвалж

23. Монгол Улсын Их Хурлын Тамгын газар, 2023.03.06, ТГ-02/250 тоот Хариу хүргүүлэх тухай албан бичиг
24. Монгол Улсын Их Хурлын Тамгын газар, 2025.04.30, Хариу хүргүүлэх тухай цахим шуудан
25. Монгол Улсын Их Хурлын Тамгын газар, 2025.04.03, Хариу хүргүүлэх тухай цахим шуудан

Хавсралт 1. Судалгаанд хамрагдсан хуулиуд

№	Хуулийн нэр	Хууль санаачлагч	Баталсан огноо
Анхдагч хууль			
1	Музейн тухай хууль	Засгийн газар	2021.01.29
2	Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай хууль	Засгийн газар	2021.01.29
3	Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль	Засгийн газар	2021.04.02
4	Кино урлагийг дэмжих тухай хууль	Засгийн газар	2021.07.02
5	Өршөөл үзүүлэх тухай хууль		2021.07.02
6	Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль	Засгийн газар	2021.12.17
7	Кибер аюулгүй байдлын тухай хууль	Засгийн газар	2021.12.17
8	Генетик нөөцийн тухай хууль	Засгийн газар	2021.12.30
9	Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль	Засгийн газар	2022.11.04
10	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль	Засгийн газар	2022.12.09
11	Уур уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль	Засгийн газар	2022.12.23
12	Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны тухай хууль	УИХ-ын гишүүн	2023.01.20
13	Төрөөс олгох урамшууллаас эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэл суутган төлөх тухай хууль	УИХ-ын гишүүн	2023.04
14	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль	УИХ-ын гишүүн	2023.05.04
15	Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль	Засгийн газар	2023.12.07
16	Гэрийн тэжээвэр амьтны тухай хууль	УИХ-ын гишүүн	2023.12.08
17	Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хууль	УИХ-ын гишүүн	2024.01.12
18	Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хууль	УИХ-ын гишүүн	
19	Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль	Засгийн газар	2024.07.16
20	Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль	Засгийн газар	2024.06.05
21	Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хууль	УИХ-ын гишүүн	
22	Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хууль	Засгийн газар	2024.06.05
23	Малчны тухай хууль	УИХ-ын гишүүн	
24	Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хууль	Засгийн газар	2024.06.05

№	Хуулийн нэр	Хууль санаачлагч	Баталсан огноо
Шинэчилсэн найруулга			
25	Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль	УИХ-ын гишүүн	2020.12.24
26	Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль	Засгийн газар	2020.12.24
27	Монгол Улсын шүүхийн тухай хууль	Засгийн газар	2021.01.15
28	Хоршооны тухай хууль	УИХ-ын гишүүн	2021.05.06
29	Зохиогчийн эрхийн тухай хууль	Засгийн газар	2021.05.06
30	Патентын тухай хууль	Засгийн газар	2021.05.06
31	Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль	УИХ-ын гишүүн	2021.05.21
32	Хөдөлмөрийн тухай хууль	Засгийн газар	2021.07.02
33	Соёлын тухай хууль	Засгийн газар	2021.07.02
34	Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль	Засгийн газар	2021.07.07
35	Таримал ургамлын үр, сортын тухай хууль	Засгийн газар	2021.10.29
36	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль	Засгийн газар	2021.12.17
37	Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хууль	Засгийн газар	2021.12.17
38	Цахим гарын үсгийн тухай хууль	Засгийн газар	2021.12.17
39	Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль	Засгийн газар	2021.12.24
40	Эрдэнэсийн сангийн тухай хууль	УИХ-ын гишүүн	2022.04.22
41	Далай ашиглах тухай хууль	Засгийн газар	2022.06.03
42	Хөрөнгийн үнэлгээний тухай хууль	Засгийн газар	2022.06.17
43	Зөвшөөрлийн тухай хууль	УИХ-ын гишүүн	2022.06.17
44	Үндэсний их баяр наадмын тухай хууль		2022.06.28
45	Хууль зүйн туслалцааны тухай хууль	Засгийн газар	2022.07.01
46	Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль	УИХ-ын гишүүн	2022.07.05
47	Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих тухай хууль	Засгийн газар	2022.07.05
48	Шүүх шинжилгээний тухай хууль	Засгийн газар	2022.12.23
49	Аялал жуулчлалын тухай хууль	Засгийн газар	2023.05.04
50	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль	Засгийн газар	2023.06.16
51	Иргэний нисэхийн тухай хууль	Засгийн газар	2023.07.07
52	Нийгмийн даатгалын ерөнхий хууль	Засгийн газар	2023.07.07
53	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль 2023	Засгийн газар	2023.07.07

№	Хуулийн нэр	Хууль санаачлагч	Баталсан огноо
54	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль	Засгийн газар	2023.07.07
55	Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль	Засгийн газар	2023.07.07
56	Төмөр замын тээврийн тухай хууль	Засгийн газар	2023.07.07
57	Боловсролын ерөнхий хууль	Засгийн газар	2023.07.07
58	Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль	Засгийн газар	2023.07.07
59	Дээд боловсролын тухай хууль	Засгийн газар	2023.07.07
60	Техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль	Засгийн газар	2023.07.07
61	Улс төрийн намын тухай хууль	Ерөнхийлөгч	2023.07.07
62	Хүүхэд хамгааллын тухай хууль	Засгийн газар	2024.01.17
63	Органик бүтээгдэхүүний тухай хууль	УИХ-ын гишүүн	2024.01.17
64	Шинжлэх ухаан, технологийн тухай хууль	Засгийн газар	2024.05.16
65	Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль	Засгийн газар	2024.06.05
66	Шүүх байгуулах тухай хууль	Засгийн газар	2024.06.05
67	Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хууль	Засгийн газар	2024.06.05
68	Биеийн тамир, спортын тухай хууль	Засгийн газар	2024.06.05
69	Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль	Засгийн газар	2024.06.05
70	Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль	Засгийн газар	2024.06.05
71	Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хууль	Засгийн газар	2024.06.05
Хуульд өөрчлөлт оруулах тухай хууль			
72	Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль	УИХ-ын гишүүн	2024.04.12
73	Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль	УИХ-ын гишүүн	2024.06.05
74	Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль	УИХ-ын гишүүн	2024.06.05
75	Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль	УИХ-ын гишүүн	2024.06.05
76	Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль	УИХ-ын гишүүн	2024.06.05
77	Улс төрийн хилст хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах тэдэнд нөхөх олговор олгох тухай өөрчлөлт оруулах тухай хууль	УИХ-ын гишүүн	2024.05.16
78	Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль		2023.07.07

№	Хуулийн нэр	Хууль санаачлагч	Баталсан огноо
79	Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль	УИХ-ын гишүүн	2022.11.11
80	Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль	УИХ-ын гишүүн	2023.01.06
81	Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль	УИХ-ын гишүүн	2022.01.18
82	Донорын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль	УИХ-ын гишүүн	2022.06.17
83	Төрийн албан тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль	УИХ-ын гишүүн	2022.07.05
84	Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль	УИХ-ын гишүүн	2022.12.09
85	Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль	Засгийн газар	2024.06.05
86	Үнэт цаасны зах зээлийн тухай хууль	Засгийн газар	2024.05.16
87	Засгийн газрын тусгай сангийн тухай хууль	Засгийн газар	2021.04.08
88	Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль	Засгийн газар	2023.01.20
89	Шүүх байгуулах тухай хуулийн төсөлтэй хамт багцаар нь өргөн мэдүүлэх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль	Засгийн газар	2024.01.17
90	Шүүх байгуулах тухай хуулийн төсөлтэй хамт багцаар нь өргөн мэдүүлэх Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль	Засгийн газар	2024.01.17
91	Засгийн газрын тусгай сангийн тухай хууль	Засгийн газар	2023.04.21
92	Дархлаажуулалтын тухай хууль	Засгийн газар	2023.10.27
93	Төсвийн тухай хууль	Засгийн газар	2023.07.07
94	Засгийн газрын тусгай сангийн тухай хууль	Засгийн газар	2023.12.08
95	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль	Засгийн газар	2024.06.05
96	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль	Засгийн газар	2023.07.07
97	Гаалийн тариф, гаалийн татварын тухай (цахилгаан, эрчим хүч) хууль	Засгийн газар	2023.07.07
98	Эрүүгийн хууль	Засгийн газар	2022.12.16

Хавсралт 2. ХТтХ-д заасны дагуу судалгаа, шинжилгээ хийх шаардлагагүй хуулийн төсөл

№	Хуулийн төслийн төрөл	Тоо	Судалгаа, шинжилгээ хийхгүй байх үндэслэл
1	Тухайн жилийн улсын төсөв, төсвийн тодотголтой холбоотой	15	ХТтХ-ийн 12.2.2 дахь заалт
2	Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл	5	ХТтХ-ийн 12.2.3 дахь заалт
3	Албан тушаалтныг томилох, чөлөөлөхтэй холбоотой	1	ХТтХ-ийн 12.2.16-д заасан Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрөх тухай хууль (2021.06.11)
4	Улсын Их Хурлын чуулганаар хуулийн төслийг яаралтай хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн	13	ХТтХ-ийн 12.2.17-д зааснаар Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 21.1-д заасан хууль тогтоомжийн төсөл буюу тус хуулийн 33 дугаар зүйлд зааснаар ЗГ-ын хуралдааны шийдвэрийг үндэслэн хуулийн төслийг яаралтай хэлэлцүүлэхээр УИХ-д бичгээр хүсэлт тавьсан бол УИХ-ын дарга төслийг чуулганаар яаралтай хэлэлцэх эсэхийг нэгдсэн хуралдаанд оруулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ.
5	Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль	4	ХТтХ-ийн 12.2.22-д хамаарах Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль (2021.12.24)
6	Олон улсын гэрээ, конвенц, хэлэлцээр соёрхон батлах тухай хууль	37	2020-2024 онд энэ төрөлд хамаарах 37 хууль батлагдсан байна. Гэсэн хэдий ч ХТтХ-ийн 12 дугаар зүйлийн 12.2-т “зээлийн хэлэлцээрээс бусад олон улсын гэрээ соёрхон батлах тухай хуулийн төсөлд судалгаа хийх шаардлагагүй” ⁶⁷ гэж заасны дагуу энэхүү судалгаанд хамруулаагүй.
	Нийт	75	ХТтХ-д заасны дагуу судалгаа шинжилгээ хийх шаардлагагүй анхдагч болон шинэчилсэн найруулсан хуулийн нийт тоо

⁶⁷ Уг заалтыг 2024 оны 05 сарын 16-ны өдөр Хууль тогтоомжийн тухай хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр хүчингүй болгосон.

Хавсралт 3. Хуульд заасан зарим судалгааг хийгээгүй хуулийн төслийн жагсаалт, энэ талаарх УИХТГ-ын тайлбар

1. Бүх судалгаа байхгүй хуулийн төслийн жагсаалт

№	Хуулийн төслийн нэр	Баталсан огноо	Тайлбар	Цахим холбоос
1	Малын тоо толгойн албан татварын тухай	2020.11.13	Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуультай хамт батлагдсан. Төслийн бүрдэл хянасан хуудсанд “Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.2.2-т зааснаар шаардлагагүй” гэж тэмдэглэсэн.	https://forum.parliament.mn/projects/11262
2	Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны тухай	2023.01.20	Төслийн бүрдэл хянасан хуудсанд “Шаардлагагүй” гэж тэмдэглэсэн”	https://lawforum.parliament.mn/project/295/
3	Төрийн хэмнэлтийн тухай	2022.04.29	Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дагалдуулан баталсан.	https://lawforum.parliament.mn/project/162/
4	Нийгмийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлсөн зарим даатгуулагчийн шимтгэлийн 50 хувийг буцаан олгох тухай	2022.04.29	Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дагалдуулан баталсан.	https://lawforum.parliament.mn/project/162/
5	Засгийн газар дахь хяналтын тухай	2022.11.11	Монгол Улсын 2023 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоол, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дагалдуулан батлагдсан.	https://lawforum.parliament.mn/project/318/
6	Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль	2023.07.07	Боловсролын ерөнхий хуультай хамт өргөн мэдүүлсэн.	https://lawforum.parliament.mn/project/257/
7	Дээд боловсролын тухай хууль	2023.07.07	Боловсролын ерөнхий хуультай хамт өргөн мэдүүлсэн.	https://lawforum.parliament.mn/project/259/

№	Хуулийн төслийн нэр	Баталсан огноо	Тайлбар	Цахим холбоос
8	Хотын албан татварын тухай хууль	2024.06.05	Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлж баталсан.	https://lawforum.parliament.mn/project/591/

2. Хэрэгцээ, шаардлагын тандан судалгаа эсхүл хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан байхгүй хуулийн төслүүд

№	Хуулийн төслийн нэр	Батлагдсан огноо	Тайлбар	Цахим холбоос
1	Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль	2020.12.24	Төслийн бүрдэл хянасан хуудсанд “Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.3.1-д зааснаар шаардлагагүй” гэж тэмдэглэсэн.	
2	Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль	2020.12.24	Хуулийн хувийн хэрэгт байхгүй.	https://forum.parliament.mn/projects/10869-д байршуулаагүй.
3	Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль	2021.12.24	Хуулийн хувийн хэргийн 1-р ботийн 50-152-р хуудсанд байна.	https://forum.parliament.mn/projects/10833-д байршуулаагүй.
4	Үндэсний их баяр наадмын тухай хууль	2022.06.28	Хуулийн хувийн хэргийн 1-р ботийн 43-71-р хуудсанд байна.	https://forum.parliament.mn/projects/21282-д байршуулсан. Уг цахим холбоос ажиллахгүй байсан.
5	Аялал жуулчлалын тухай хууль	2023.05.04	Хуулийн хувийн хэргийн 1-р ботийн 99-156-р хуудсанд байна.	https://lawforum.parliament.mn/project/345/ -д байршуулаагүй.
6	Нийгмийн даатгалын ерөнхий хууль	2023.07.07	Хуулийн хувийн хэргийн 1-р ботийн 169-188-р хуудсанд байна.	https://lawforum.parliament.mn/project/381/ -д байршуулсан.
7	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль	2023.07.07	Хуулийн хувийн хэргийн 1-р ботийн 103-124-р хуудсанд байна.	https://lawforum.parliament.mn/project/372/ -д байршуулсан.

№	Хуулийн төслийн нэр	Батлагдсан огноо	Тайлбар	Цахим холбоос
8	Улс төрийн намын тухай хууль	2023.07.07	Хуулийн хувийн хэргийн 1-р ботийн 113-138-р хуудсанд байна.	https://lawforum.parliament.mn/project/408/ -д байршуулсан.
9	Органик бүтээгдэхүүний тухай хууль	2024.01.17	Хуулийн хувийн хэргийн 1-р ботийн 77-235-р хуудсанд байна.	https://lawforum.parliament.mn/project/394/ -д байршуулсан.
10	Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль	2024.06.05	Хуулийн хувийн хэргийн 1-р ботийн 136-252-р хуудсанд байна.	https://lawforum.parliament.mn/project/593/ -д байршуулсан.
11	Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хууль	2024.06.05	Хуулийн хувийн хэргийн 1-р ботийн 58-127-р хуудсанд байна.	https://lawforum.parliament.mn/project/498/ -д байршуулсан.
12	Биеийн тамир, спортын тухай хууль	2024.06.05	Хуулийн хувийн хэргийн 1-р ботийн 62-201-р хуудсанд байна.	https://forum.parliament.mn/projects/177 -д байршуулаагүй.
13	Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль	2024.06.05	Хуулийн хувийн хэргийн 1-р ботийн 34-78-р хуудсанд байна.	https://lawforum.parliament.mn/project/591/ -д байршуулсан.

3. Зардлын тооцооны тайлангүй хуулийн төслүүд

№	Хуулийн төслийн нэр	Батлагдсан огноо	Тайлбар	Цахим холбоос
1	Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль	2021.12.17	Хуулийн хувийн хэргийн 1-р ботийн 99-101-р хуудсанд байна.	https://forum.parliament.mn/projects/11100 -д байршуулаагүй.
2	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль	2023.05.04	Төслийн бүрдэл хянасан хуудсанд “Шаардлагагүй гэж тэмдэглэсэн”	
3	Малчны тухай хууль	2024.06.05	Хуулийн хувийн хэргийн 1-р ботийн 134-139-р хуудсанд байна.	https://lawforum.parliament.mn/project/583/ -д байршуулсан.

№	Хуулийн төслийн нэр	Батлагдсан огноо	Тайлбар	Цахим холбоос
4	Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль	2020.12.24	Тусдаа ном хэлбэрээр гарсан.	https://forum.parliament.mn/projects/10869-д байршуулаагүй.
5	Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль	2021.07.07	Хуулийн хувийн хэргийн 3-р ботийн 158-189-р хуудсанд байна.	https://forum.parliament.mn/projects/11151-д байршуулаагүй.
6	Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль	2021.12.24	Хуулийн хувийн хэргийн 1-р ботийн 157-206-р хуудсанд байна.	https://forum.parliament.mn/projects/10833-д байршуулаагүй.
7	Үндэсний их баяр наадмын тухай хууль	2022.06.28	Хуулийн хувийн хэргийн 1-р ботийн 72-81-р хуудсанд байна.	https://forum.parliament.mn/projects/21282-д байршуулсан. Уг цахим холбоос ажиллахгүй байсан.
8	Аялал жуулчлалын тухай хууль	2023.05.04	Хуулийн хувийн хэргийн 1-р ботийн 157-177-р хуудсанд байна.	https://lawforum.parliament.mn/project/345/ -д байршуулаагүй.
9	Органик бүтээгдэхүүний тухай хууль	2024.01.17	Хуулийн хувийн хэргийн 1-р ботийн 194-235-р хуудсанд байна.	https://lawforum.parliament.mn/project/394/ -д байршуулсан.
10	Шинжлэх ухаан, технологийн тухай хууль	2024.05.16	Хуулийн хувийн хэргийн 1-р ботийн 194-205-р хуудсанд байна.	https://lawforum.parliament.mn/project/578/ -д байршуулаагүй.
11	Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль	2024.06.05	Төслийн бүрдэл хянасан хуудсанд “Нууцаар хүргүүлнэ” гэж тэмдэглэсэн.	https://lawforum.parliament.mn/project/599/ -д байршуулаагүй.

4. Үр нөлөөний үнэлгээний тайлангүй хуулийн төслүүд

№	Хуулийн төслийн нэр	Батлагдсан огноо	Тайлбар	Цахим холбоос
1	Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль	2021.12.17	Хуулийн хувийн хэргийн 1-р ботийн 72-98-р хуудсанд байна.	https://forum.parliament.mn/projects/11100 -д байршуулаагүй.
2	Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль	2020.12.24	Төслийн бүрдэл хянасан хуудсанд “Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.3.1-д зааснаар шаардлагагүй гэж тэмдэглэсэн”	
3	Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль	2020.12.24	Хуулийн хувийн хэрэгт байхгүй.	https://forum.parliament.mn/projects/10869 -д байршуулаагүй.
4	Соёлын тухай хууль	2021.07.02	Хуулийн хувийн хэргийн 1-р ботийн 71-98-р хуудсанд байна.	https://forum.parliament.mn/projects/10650 -д байршуулаагүй.
5	Үндэсний их баяр наадмын тухай хууль	2022.06.28	Хуулийн хувийн хэргийн 1-р ботийн 82-99-р хуудсанд байна.	https://forum.parliament.mn/projects/21282 -д байршуулсан. Уг цахим холбоос ажиллахгүй байсан.
6	Шинжлэх ухаан, технологийн тухай хууль	2024.05.16	Хуулийн хувийн хэргийн 1-р ботийн 237-253-р хуудсанд байна.	https://lawforum.parliament.mn/project/578/ -д байршуулаагүй.
7	Биеийн тамир, спортын тухай хууль	2024.06.05	Хуулийн хувийн хэргийн 1-р ботийн 62-79-р хуудсанд байна.	https://forum.parliament.mn/projects/177 -д байршуулаагүй.

Хавсралт 4. Хэрэгцээ, шаардлагын тандан судалгааны хүрээнд асуудлыг тодорхойлсон байдал

Хуулийн төслийн нэр	Асуудлыг тодорхойлсон байдал
2020 оны 11 сарын 13-ны өдөр батлагдсан Музейн тухай хууль	Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, эрх зүйн баримт бичгүүд нь музейн өмнө тулгамдаад байгаа хөрөнгө оруулалт, үйл ажиллагааны зохион байгуулалт, салбар дундын түншлэл, техник технологийн хөгжүүлэлт, хүний нөөцийн хангамж, гадаад харилцааг хөгжүүлэх зэрэг олон асуудлыг шийдвэрлэж, музейн тогтвортой хөгжлийг дэмжих хөшүүрэг болж чадахгүй байна.
2023 оны 4 сарын 21-ний өдөр батлагдсан Төрөөс олгох урамшууллаас эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэл суутган төлөх тухай хууль	Малчин, саальчин, мал бүхий иргэд, тариаланчид зэрэг иргэд байнгын ажлын байргүй, байнгын орлогогүй тул нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ төлөх нь тогтмол төлөх нь хүндрэлтэй байдаг, иргэд нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ төлөхгүй байх нь ирээдүйд тэдний амьдралын баталгаанд сөрөг нөлөөтэй, эрүүл мэндийн хувьд, цаг хугацааны хувьд эрсдэлтэй.
2021 оны 4 сарын 02-ны өдөр батлагдсан Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль	Тус хуулийн тандан судалгааны тайланд хүний эрх хамгаалагч буюу хүний эрхийн активисттай ярилцлага хийсэн.
2023 оны 12 сарын 08-ны өдөр батлагдсан Гэрийн тэжээвэр амьтны тухай хууль	Тус хуулийн тандан судалгааны тайланг холбогдох чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага боловсруулсан зэргээр олон этгээдийн оролцоог хангасан
2021 оны 12 сарын 17-ны өдөр батлагдсан Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль	Тус хуулийн тандан судалгааны тайланд асуудлыг тодорхойлохдоо 500 гаруй иргэд, 100 гаруй төрийн болон хувийн хэвшлийн байгууллагаас асуулга авах замаар оролцоог хангасан зэрэг сайн жишээнүүд ч байгааг тэмдэглэх нь зүйтэй.
2023-ны 7 сарын 07-ны өдөр батлагдсан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль	1.3.Тухайн суудал үүссэн шалтгаан нөхцөл” хэсэгт Тэтгэмжийн болон ажилгүйдлийн даатгалын тулгамдсан асуудлыг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар тухай бүр шийдвэрлэсэн боловч нийгмийн хөгжлийн явцад засаж залруулах, сайжруулах, зайлшгүй өөрчлөн шинэчлэх зүйлүүд олон байгаа нь хуулийг хэрэгжүүлэх явцад бодит амьдралд нотлогдож байна
2021 оны 5 сарын 21-ны өдөр батлагдсан Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулга	Монголын банкны холбоо нь 2015 оноос хойш тус хуулийг Үндэсний төлбөрийн системийн тухай хуульд нийцүүлэх, шинэчлэх шаардлагатайг дурдсан албан бичгийг удаа дараа хүргүүлж байсан буюу тус хуулийг хэрэгжүүлэгч этгээдүүдээс хуулийг шинэчлэх шаардлагатайг дурдсан. Дэлхийн банкны техник туслалцааны хүрээнд зөвлөмж өгсөн

Хавсралт 5. Хэрэгцээ, шаардлагын тандан судалгааны хүрээнд асуудал шийдвэрлэх зорилгыг тодорхойлсон байдал

№	Хуулийн төслийн төрөл	Хуулийн нэр	Асуудал шийдвэрлэх зорилгыг тодорхойлсон байдал
1	Анхдагч хуулийн төсөл	Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай хууль /2021.01.29/	Газрын тос боловсруулах үйлдвэр болон түүхий тос дамжуулах хоолой, тэдгээрийн үндсэн ба дагалдах байгууламжийг барьж байгуулах, ашиглалтад оруулах үйл ажиллагааг шуурхай, чирэгдэлгүй, хялбаршуулсан горимоор зохицуулах, үйлдвэрийн түүхий эдийн нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах хууль, эрх зүйн орчин бүрдүүлэх.
2	Анхдагч хуулийн төсөл	Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль /2021.04.02/	Хүний эрхийн төлөө тэмцэж буй этгээдийг бусдын халдлагаас хамгаалах, үйл ажиллагаагаа тогтвортой явуулах боломжоор хангах.
3	Анхдагч хуулийн төсөл	Кино урлагийг дэмжих тухай хууль /2021.07.02/	Хуулийн төслийг боловсруулах зорилго нь киноны салбарын хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх, орчин үеийн дэвшилтэт техник, технологи бүхий кино үйлдвэрлэлийн дэд бүтцийг бий болгож монгол киног дэлхийн зах зээлд гарган өрсөлдүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, хүүхэд, залуучуудад эх оронч үндэсний үзэл, ёс суртахууныг төлөвшүүлэхэд чиглэсэн кино бүтээлийг улсын захиалга, санхүүжилтээр бүтээх, киног эдийн засгийн хөшүүрэг болгон хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх.
4	Шинэчилсэн найруулга	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль /2023.07.07/	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах замаар тэтгэмжийн харилцааг нэг хуулиар зохицуулан тэтгэмжийн болон ажилгүйдлийн даатгалын сангаас даатгуулагчид олгох тэтгэмжийн төрлийг тодорхойлох, тэтгэмж тогтоох, олгох, зогсоох, буцаан төлүүлэх, ажил олгогчид дэмжлэг үзүүлэх, даатгуулагчийг ажилгүй болохоос урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа тодорхой болох юм.

№	Хуулийн төслийн төрөл	Хуулийн нэр	Асуудал шийдвэрлэх зорилгыг тодорхойлсон байдал
5	Шинэчилсэн найруулга	Боловсролын ерөнхий хууль /2023.07.07/	Хуулийн төслийг боловсруулах зорилго нь боловсролын байгууллагын удирдлага, үйл ажиллагааг улс төрөөс ангид, тогтвортой байлгах, боловсролыг тогтворшуулан хөгжүүлэх нөхцөлийг хангах, боловсролын харилцаанд оролцогчдын эрх, үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх, боловсролын талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлж түүний үр дүн, сурлагын чанар, төгсөгчдийн ажил эрхлэлт, ажил олгогчийн эрэлт хэрэгцээ цаашдын төлөв байдлыг харгалзан олгоход эрх зүйн орчныг боловсронгуй болгох, боловсролыг тогтворшуулан хөгжүүлэх нөхцөлийг хангах, хөдөлмөрийн зах зээлийн өнөөгийн болон цаашдын эрэлтэд нийцсэн мэргэжилтэн бэлдэх, практикт үүсэж буй тодорхой асуудлуудыг шийдвэрлэх замаар практикт үүсэж буй тодорхой асуудлуудыг шийдвэрлэх, хууль тогтоомж хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгахад оршино.

Хавсралт 6. Хэрэгцээ, шаардлагын тандан судалгааны хүрээнд харьцуулсан судалгаа гүйцэтгээгүй хуулиудын төсөл

№	Хуулийн төслийн төрөл	Хуулийн төслийн нэр	Батлагдсан огноо
1	Анхдагч хууль	Төрөөс олгох урамшууллаас эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэл суутган төлөх тухай хууль	2023.04.21
2	Анхдагч хууль	Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хууль	2024.06.05
3	Анхдагч хууль	Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хууль	2024.06.05
4	Шинэчилсэн найруулга	Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хууль	2024.06.05
5	Нэмэлт, өөрчлөлт	Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль	2024.04.12
6	Нэмэлт, өөрчлөлт	Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль	2024.06.05

№	Хуулийн төслийн төрөл	Хуулийн төслийн нэр	Батлагдсан огноо
7	Нэмэлт, өөрчлөлт	Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах тэдэнд нөхөх олговор олгох тухай өөрчлөлт оруулах тухай хууль	2024.05.16
8	Нэмэлт, өөрчлөлт	Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль	2023.07.07
9	Нэмэлт, өөрчлөлт	Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль	2022.11. 11
10	Нэмэлт, өөрчлөлт	Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль	2024.06.05
11	Нэмэлт, өөрчлөлт	Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль	2023.07.07

Хавсралт 7. Хэрэгцээ, шаардлагын тандан судалгааны зөвлөмжийг хуульд тусгасан байдал

№	Тандан судалгааны зөвлөмж	Хуульд туссан байдал
1	Боловсролын хууль нэгдмэл байх зарчим баримтлах. Энэхүү зарчмын хүрээнд Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль, Бага дунд боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, Дээд боловсролын санхүүжилт, нийгмийн баталгааны тухай хууль, Багшийн хөгжлийн тухай хуулийг нэгтгэн “Боловсролын тухай” хуулийн төсөл боловсруулна.	Энэхүү зөвлөмж нь батлагдсан хуульд бүрэн тусаагүй байна. Тодруулбал, 2023 оны 7 сарын 07-ны өдөр батлагдсан Боловсролын ерөнхий хуулийн хамтаар Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль тус тус батлагдсан байх бөгөөд 2018 оны 6 сарын 27-ны өдөр батлагдсан Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль хүчин төгөлдөр хэвээр байна.
2	Хуулийн зорилт болон боловсролын зорилго, үндсэн зарчимд дэлхий нийтийн боловсролын хөгжлийн чиг хандлага болон тогтвортой хөгжлийн боловсролын үзэл санааг тусгах.	Хуулийн 1 дүгээр зүйл буюу зорилтод энэ талаар тусгаагүй байх бол харин хуулийн 4 дүгээр зүйлд “Боловсролын зорилго” гээд “хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлэх” тогтвортой хөгжлийн агуулгыг тусгасан байна.
3	Бүх шатны боловсролын сургалтын байгууллагын сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний агуулга, бүтцийг зөвхөн боловсролын хуулиар зохицуулж байхаар тусгах.	Энэхүү зөвлөмж нь батлагдсан хуульд тусаагүй байна. Тодруулбал, Боловсролын ерөнхий хуулиас гадна Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулиар тухайн шатны боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөрийг зохицуулсан байна.

№	Тандан судалгааны зөвлөмж	Хуульд туссан байдал
4	Төрөөс боловсролын талаар үзүүлж буй зарим үйлчилгээний үр ашиг, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор боловсролын удирдлагын тогтолцоонд орон нутгийн эрх барих байгууллагын эрх мэдлийг оновчтой тодорхойлох, хариуцлагыг нэмэгдүүлэх замаар орон нутагт зарим чиг үүргийг бүрэн хариуцуулах.	Энэхүү зөвлөмжийн хүрээнд хуулийн 29-32 дугаар зүйлд орон нутгийн эрх барих байгууллага болох аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх, Аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрх, Сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх, Баг, хорооны Засаг даргын бүрэн эрхийг тус тус тодорхойлсон байна.
5	Боловсрол эзэмших хэлбэр / өдөр, орой, зайн сургалт, нээлттэй боловсрол/-ийг тодорхой зохицуулж, бүх нийтийн насан туршдаа суралцах боломжийг дэмжих зохицуулалтыг тусгах.	Энэхүү зөвлөмжийн хүрээнд хуульд "зайн сургалт"-ыг тодорхойлж, боловсрол эзэмшүүлэх сургалтын хэлбэрт оруулсан байна /хуулийн 8.2/.
6	Нийтийн тээврийн үйлчилгээ хөгжсөн хот, суурин газрын ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг хичээлийн жилийн хугацаанд сургуульдаа ирэх, буцахад нийтийн тээврээр үнэ төлбөргүй зорчих зохицуулалтыг бий болгох	Энэхүү зөвлөмж нь батлагдсан хуульд тусаагүй буюу хуульд үүнтэй холбоотой зохицуулалт байхгүй байна.
7	Хувийн өмчийн ерөнхий боловсролын сургуульд нэг хүүхдэд ногдох хувьсах зардлыг төрөөс санхүүжүүлж байгаа зохицуулалтыг өөрчилж, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийг суралцуулж байгаа тохиолдолд тухайн сургуульд хүүхдийн тооноос хамаарч нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын дэмжлэгийг төрөөс үзүүлдэг байхаар зохицуулалт хийх.	Энэхүү зөвлөмж нь батлагдсан хуульд тусаагүй байна. Тодруулбал, хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.6-д төрийн болон хувийн өмчийн ерөнхий боловсролын сургууль болон цэцэрлэгт олгох хувьсах зардлын санхүүжилтийг 2 жил тутам ЗГ-аас шинэчлэн тогтоохоор заажээ.

Хавсралт 8. Үр нөлөөний үнэлгээний хүрээнд зарим шалгуур үзүүлэлтийг сонгоогүй шалтгааныг тайлбарласан байдал

1. Хүлээн зөвшөөрөгдөх байдал шалгуур үзүүлэлт

Анхдагч хууль	
Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай хууль	Энэхүү шалгуур үзүүлэлтээр тухайн хуулийн төслийн зохицуулалтыг иргэд, байгууллага хэрхэн хүлээн авах, тэдгээрт шинээр үүрэг хүлээлгэсэн эсэхийг шалгадаг. Тус хуулийн төсөл нь зөвхөн төрөөс хэрэгжүүлж буй газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төсөлд хамаарах тул иргэд болон бусад аж ахуйн нэгжид шинээр ямар нэгэн чиг үүргийг нэмж хүлээлгэхгүй тул "хүлээн зөвшөөрөгдөх байдал" шалгуур үзүүлэлтээр үнэлгээ хийх шаардлагагүй гэж үзсэн болно.
Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль	Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд зөвхөн аж ахуйн байгууллагад үүрэг хүлээлгэсэн, мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэхэд хүндрэл үүсгэх зохицуулалтыг тусгаагүй тул хүлээн зөвшөөрөгдөх байдал гэсэн шалгуур үзүүлэлтийг сонгон авах шаардлагагүй гэж үзсэн.
Малчны тухай хууль	Малчны тухай хуулийн төслийн үзэл баримтлал, төслийн зорилт, зохицуулалтаас үзэхэд малчин хүний эрхэлж байгаа мал аж ахуйн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа хэвээр хадгалагдахаар байгаа тул хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалтын хүрээнд хамрагдах этгээд хүлээн зөвшөөрөх эсэхийг тодруулах зорилт бүхий "хүлээн зөвшөөрөгдөх байдал" шалгуур үзүүлэлтээр үнэлгээ хийх шаардлагагүй гэж үзсэн болно.
Шинэчилсэн найруулга	
Патентийн тухай хууль	тухайн хуулийн төслийн зохицуулалт иргэд, байгууллагад хэрхэн нөлөөлөх, түүнийг эдгээр этгээдүүд (хуулийн төсөл шууд нөлөөлөх иргэн, хуулийн этгээд) хүлээн зөвшөөрөх эсэхийг шалгана. Өөрөөр хэлбэл, тухайн зохицуулалтаар иргэдийн эрх чөлөөг хязгаарлаж байгаа эсэх, аж ахуйн нэгжүүдэд шинээр үүрэг хүлээлгэсэн эсэх, эсхүл тухайн хуулийн төслийг хэрэгжүүлэх байгууллагын үйл ажиллагаанд нийцэх эсэхийг шалгана. Энэхүү үнэлгээний хүрээнд хүлээн зөвшөөрөгдөж байдал гэсэн шалгуур үзүүлэлтийг сонгон үнэлгээ хийх шаардлагагүй гэж үзлээ. Учир нь уг хуулийн төслийг ХЗДХЯ-ны зүгээс боловсруулж, ажлын хэсэгт уг хуулийг хэрэгжүүлэх үүрэг хүлээлгэсэн төрийн байгууллагууд орж ажилласан, нөгөө талаас хуулийн зорилт нь шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварын эрхийн хамгаалалт, ашиглалттай холбогдсон харилцааг зохицуулж, шинийг санаачлах үйл ажиллагааг хөгжүүлэх, аж үйлдвэрийн хөгжлийг дэмжихэд оршиж байгаа бөгөөд иргэдийн эрх чөлөөг хязгаарлаж байгаа эсхүл аж ахуйн нэгжүүдэд шинээр үүрэг хүлээлгэсэн асуудал байхгүй тул уг үнэлгээг хийх нь ач холбогдолгүй гэж үзлээ.
Хөрөнгийн үнэлгээний тухай хууль	Хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалтын хүрээнд хамрагдах этгээд / иргэн, хуулийн этгээд/ хүлээн зөвшөөрөх эсэхийг тодруулах зорилт бүхий "хүлээн зөвшөөрөгдөх байдал" шалгуур үзүүлэлтээр үнэлгээ хийх шаардлагагүй гэж үзсэн болно.

Зөвшөөрлийн тухай хууль	Хуулийн төсөл эцэслэн боловсруулагдаж холбогдох этгээдүүдээс санал авах үед аргачлалд заасны дагуу уг шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн холбогдох заалтуудыг үзэх боломжтой байх тул энэхүү шалгуур үзүүлэлтийг сонгоогүй болно.
Хууль зүйн туслалцааны тухай хууль	Энэхүү шалгуур үзүүлэлтээр тухайн хуулийн төслийн зохицуулалтыг иргэд, байгууллага хэрхэн хүлээн авах, тэдгээрт шинээр үүрэг хүлээлгэсэн эсэхийг шалгадаг. Тус хуулийн төслөөр иргэд, аж ахуйн нэгжид шинээр ямар нэгэн чиг үүргийг шинээр нэмж хүлээлгэхгүй тул “хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлгээ хийх шаардлагагүй гэж үзсэн болно.
Шүүх шинжилгээний тухай хууль	Хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалтын хүрээнд хамрагдах этгээд (иргэн, хуулийн этгээд) хүлээн зөвшөөрөх эсэхийг тодруулах зорилт бүхий “хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлгээ хийх шаардлагагүй гэж үзсэн болно.
Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль	Хуулийн төсөлд тодорхой этгээдүүдэд үүрэг хүлээлгэсэн, аж ахуйн нэгж, байгууллагын салбарт хүндрэл үүсгэх зохицуулалтыг тусгаагүй тул энэ шалгуур үзүүлэлтийг сонгон авах шаардлагагүй гэж үзсэн болно.
Төрийн албаны тухай хууль	Хуулийн төсөлд иргэдийн эрх чөлөөг хязгаарлах, аж ахуйн нэгжүүдэд шинээр үүрэг хүлээлгэсэн, эсхүл тухайн хуулийн төслийг хэрэгжүүлэх байгууллагын үйл ажиллагаанд нийцэхгүй зохицуулалт агуулаагүй тул хүлээн зөвшөөрөгдөх байдал шалгуур үзүүлэлтээр үнэлгээ хийх шаардлагагүй гэж үзсэн болно.
Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль	Энэхүү шалгуур үзүүлэлтээр тухайн хуулийн төслийн зохицуулалтыг иргэд, байгууллага хэрхэн хүлээн авах, тэдгээрт шинээр үүрэг хүлээлгэсэн эсэхийг шалгадаг. Тус хуулийн төслөөр иргэд, аж ахуйн нэгжид шинээр ямар нэгэн чиг үүргийг нэмж хүлээлгэхгүй тул “хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлгээ хийх шаардлагагүй гэж үзсэн болно.

2. Практикт хэрэгжих боломж шалгуур үзүүлэлт

Анхдагч хууль	
Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай хууль	Энэхүү шалгуур үзүүлэлтээр тухайн хуулийн төслийн зохицуулалтыг дагаж мөрдөх буюу хэрэгжүүлэх боломжтой эсэх, хэрэгжүүлэх этгээд байгаа эсэх, санхүү болон хүний нөөцийн байдал зэргийг тогтоодог. Өмнө нь энэ төрлийн монгол улсад хэрэгжиж байсан туршлага бий бөгөөд түүний алдаа сургамжид үндэслэн илүү нарийвчлах зохицуулахаар хуулийн төсөлд тусгагдсан байна.
Генетик нөөцийн тухай хууль	Генетик нөөц нь өөрөө байгалийн нөөцийн нэг хэсэг хэмээгдэх тул тус хуулийн төслийг хэрэгжүүлэх төрийн захиргааны төв байгууллага Байгаль орчин, аялал жуулчлалын яам, түүний харьяа аймаг нийслэлийн байгаль хамгаалах албадууд байна. Үр нөлөөний үнэлгээ хийх ажлын хугацаа давчуу байсан тулд “практикт хэрэгжих боломж” гэсэн шалгуур үзүүлэлтийг сонгоогүй орхив.

Шинэчилсэн найруулга	
Зохиогчийн эрхийн тухай хууль	Тус хуулийн шинэчилсэн найруулгад өмнөх хуулийн заалтуудаас хадгалагдан орж буй хэсгийн "Практикт хэрэгжих боломж" болон "Хүлээн зөвшөөрөгдөх байдал" нь Зохиогчийн эрхийн болон түүнд хамаарах эрхийн тухай" хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний 2017 оны тайлангаар баталгаажиж харагдсан. Харин шинэ заалтуудын хувьд хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалд тусгагдсан практик үндэслэл, шаардлагуудаас урган гарч ирсэн хэрэгцээ нь тодорхой тул тэдгээрийн "Практикт хэрэгжих боломж" болон "Хүлээн зөвшөөрөгдөх байдал"-ыг үнэлэх нь бусад шалгуур үзүүлэлтүүдтэй нь харьцуулахад бага ач холбогдолтой гэж үзсэнтэй холбоотой болно.
Патентийн тухай хууль	тухайн хуулийн төслийн зохицуулалтыг дагаж мөрдөх буюу хэрэгжүүлэх боломжтой эсэхийг, тухайлбал, хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээд байгаа эсэх, тэдгээр этгээдэд тухайн хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж, бололцоо (санхүү, хүний нөөц зэрэг) байгаа эсэхийг шалгаж тооцно. Энэхүү үнэлгээний хүрээнд практикт хэрэгжих боломж гэсэн шалгуур үзүүлэлтийг сонгон үнэлгээ хийх шаардлагагүй гэж үзлээ. Учир нь Монгол улс нь оюуны өмчийн хамгаалах чиглэлээр 10 орчим олон улсын гэрээнд нэгдсэн орсон байдаг. Патентын тухай хууль өмнө нь манай улсад 1993 оноос хэрэгжиж эхэлсэн, шинээр хуульчлагдах зохицуулалт, арга хэмжээ нь нэгэнт олон улсад хүлээн зөвшөөрөгдөж, туршигдсан тул уг үнэлгээг хийх ач холбогдолгүй гэж үзлээ. Монгол Улсын Их Хурлын 2017 оны 01 сарын 12-ны өдрийн 11-р тогтоолоор батлагдсан "Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл"-ийн 141-т "Патентын тухай хуульд Дэлхийн оюуны өмчийн байгууллагын гэрээ, хэлэлцээрт нийцүүлэн боловсронгуй болгох" гэж тусгасан байдаг.
Хууль зүйн туслалцааны тухай хууль	тухайн хуулийн төслийн зохицуулалтыг дагаж мөрдөх буюу хэрэгжүүлэх боломжтой эсэх, хэрэгжүүлэх этгээд байгаа эсэх, санхүү болон хүний нөөцийн байдал зэргийг тогтоодог. Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хууль 2013 оны 7 сарын 05-ны өдөр батлагдаж, 2014 оны 01 сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн. Хуулийн дагуу төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тогтолцоог бүрдүүлэн ажиллаж байгаа бүтэц, туршлага байгаа бөгөөд түүний хэрэгжилтийн үр дагаварт үндэслэн илүү нарийвчлан зохицуулахаар хуулийн төсөлд тусгагдсан байна.
Иргэний нисэхийн тухай хууль	хуулийн төслийн зохицуулалтыг дагаж мөрдөх буюу хэрэгжүүлэх боломж байгаа эсэхийг, мөн хэрэгжүүлэх субъект, байгууллага нь хэн байх вэ гэдгийг тогтоох бөгөөд энэхүү шалгуур үзүүлэлтийг холбогдох байгууллагууд дунд зохион байгуулсан, цаашид зохион байгуулах хэлэлцүүлгүүдээс харагдах бөгөөд ихээхэн хэмжээний цаг хугацаа шаарддаг тул энэхүү шалгуур үзүүлэлтийг сонгоогүй болно.

Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль	Хуулийн төслийн зохицуулалтыг дагаж мөрдөх буюу хэрэгжүүлэх боломж байгаа эсэхийг, мөн хэрэгжүүлэх субъект, байгууллага нь хэн байх вэ гэдгийг тогтоох, тэдгээр байгууллагад тухайн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж, бололцоо байгаа эсэхийг урьдчилан үнэлэх шалгуур үзүүлэлт юм. Төрийн тусгай хамгаалалтын газар нь 1995 онд байгуулагдсан, хуулийн төслөөр тус байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт ороогүй тул практикт хэрэгжих боломж гэсэн шалгуур үзүүлэлтийг сонгон авах шаардлагагүй гэж үзлээ.
Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль	ухайн хуулийн төслийн зохицуулалтыг дагаж мөрдөх буюу хэрэгжүүлэх боломжтой эсэх, хэрэгжүүлэх этгээд байгаа эсэх, санхүү болон хүний нөөцийн байдал зэргийг тогтоодог. Энэ төрлийн хууль газрын тосны салбарт хэрэгжиж байсан туршлага бий бөгөөд түүний алдаа, сургамжид үндэслэн илүү нарийвчлан зохицуулахаар хуулийн төсөлд тусгагдсан байна. Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулиар Монгол Улсын ЗГ-тай Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан аж ахуйн нэгжүүд тус хуулийн 21.1.4-т заасан "газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу тус улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа албан татвар төлөгчийн өөрт нь ногдох бүтээгдэхүүний борлуулалтаас олсон энэ хуулийн 18.6.2, 20.1-д заасан орлого"-ын татвараас чөлөөлөгдөхөөр тусгагдсан байдаг. Иймд шинээр боловсруулсан хуулийн төсөлд хууль эрх тэгш үйлчлэх зарчмын дагуу газрын тос боловсруулах төрийн өмчит үйлдвэртэй хамтран ажиллах этгээдийг ЗГ-тай Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан аж ахуйн нэгжийн нэгэн адил хуулийн дээрх хөнгөлөлт, чөлөөлөлтийг эдлэх зохицуулалтыг тусгасан. Иймд тус хууль батлагдсанаар практикт хэрэгжих боломж одоогийн хүчин төгөлдөр хуулийн нэгэн адил юм. Иргэн, хуулийн этгээд хууль, шүүхийн өмнө тэгш эрхтэй байх зарчмыг баримтлан Монгол улсад БХГ-ний дагуу газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй бусад аж ахуйн нэгжүүдийн нэгэн адил төрийн өмчит газрын тосны компанитай хамтран ажиллах этгээдийг орлогын албан татвараас чөлөөлөх эрхзүйн орчныг бүрдүүлэх үндэслэлтэй байна.

3. Ойлгомжтой байдал шалгуур үзүүлэлт

Анхдагч хууль	
Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль	Хуулийн төслийн зорилгод хүрэх байдал, харилцан уялдаа шалгуур үзүүлэлтийн хүрээнд зохицуулалтуудын ойлгомжтой байдлыг хамтагтан судалж байгаа тул ойлгомжтой байдал гэсэн шалгах хэрэгслийг сонгон авч давхардуулан судлах шаардлагагүй гэж үзсэн.

Хавсралт 9. Үр нөлөөний үнэлгээний үр дүнг баримтжуулах хүрээнд хамгийн олон эшлэл зүүлт авсан болон эх сурвалжийн жагсаалт хавсаргасан хуулийн төслийн жагсаалт

1. Хамгийн олон эшлэл зүүлт авсан тохиолдлууд

№	Хуулийн төслийн төрөл	Хуулийн төслийн нэр	Эшлэлийн тоо
1	Анхдагч хууль	Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль	22
2	Анхдагч хууль	Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хууль	50
3	Шинэчилсэн найруулга	Монгол Улсын шүүхийн тухай хууль	51
4	Шинэчилсэн найруулга	Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль	26
5	Хуульд өөрчлөлт оруулах тухай	Шүүх байгуулах тухай хуулийн төсөлтэй хамт багцаар нь өргөн мэдүүлэх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль	11

2. Хамгийн эх сурвалж ашигласан тохиолдлууд

№	Хуулийн төслийн төрөл	Хуулийн төслийн нэр	Эх сурвалжийн тоо
1	Анхдагч хууль	Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хууль	40
2	Анхдагч хууль	Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль	31
3	Анхдагч хууль	Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хууль	31
4	Шинэчилсэн найруулга	Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль	37
5	Шинэчилсэн найруулга	Далай ашиглах тухай хууль	45
6	Шинэчилсэн найруулга	Шүүх шинжилгээний тухай хууль	35

Хавсралт 10. Үр нөлөөний үнэлгээний шалгуур үзүүлэлттэй шууд хамааралгүй асуудлаар зөвлөмж өгсөн жишээ

№	Хуулийн нэр	Зөвлөмж
Анхдагч хууль		
1	Музейн тухай хууль	Хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн тохиолдолд Соёлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон дагаж өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдтэй уялдуулах, хэлэлцүүлгийг хамтад нь зохион байгуулах талаар бодлогын зохицуулалтын арга хэмжээ авахыг зөвлөж байна.
2	Кино урлагийг дэмжин тухай хууль	Нэг. Хууль батлагдсантай холбогдуулан дагалдан гарах ЗГ-ын тогтоол, хөтөлбөр, төрийн захиргааны төв байгууллагын дүрэм, журмуудыг шинэчлэн боловсруулах. Хоёр. Киноны салбарын дүн мэдээг нэгтгэх, статистикийн мэдээллийг боловсруулах, киноны хөгжлийг дэмжих судалгаа, шинжилгээ хийх, киноны мэдээллийн сан үүсгэх зэрэг хууль хэрэгжих явцад гарч болох хүндрэлтэй асуудал байгааг анхаарч, төрийн болон төрийн бус байгууллага, хуулийн этгээдийн хоорондын хамтын ажиллагааг сайжруулахад Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага бодлогоор дэмжлэг үзүүлэх. Гурав. “Кино урлагийг дэмжих тухай” хуулийн хэрэгжилтийг хангахын тулд хуулийг олон нийтэд сурталчлан таниулах, хуулийн үйлчлэлд хамаарах кинотой холбогдох мэдлэг, мэдээллийг тухай бүр хүргэх, мөн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх төрийн байгууллагын ажилтан, албан хаагч нарт сургалт, семинарыг тогтмол зохион байгуулах нь зүйтэй.
3	Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль	Хуулийн төслийн хүрээнд төрөөс үзүүлэх бүртгэл, мэдээллийн санг үүсгэх, улмаар дэмжлэгийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хуулийн өөрчлөлтийг дагалдах бусад хуулийн төсөлд тусгах замаар шийдвэрлэх шаардлагатай гэж үзлээ.
4	Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хууль	Хуулийн төслийг хэрэгжүүлэхэд бэлтгэл ажил хангах тодорхой цаг хугацаа шаардлагатай байх тул хуулийн төсөлд хууль хүчин төгөлдөр үйлчлэх хугацааны талаарх зохицуулалт тусгах нь зүйтэй байна.
Шинэчилсэн найруулга		
5	Эрдэнэсийн сангийн тухай хууль	Үр нөлөөг тооцох ажиллагааны явцад гарсан дараах асуудлын талаар дахин анхаарах шаардлагатай байна гэсэн зөвлөмжийн хууль санаачлагчид өгч байна. Үүнд: 1. Хууль хүчин төгөлдөр болох хугацааг тогтоох; 2. Энэхүү хууль тогтоомжийн төсөлтэй холбоотойгоор өөрчлөгдөж буй эрх зүйн зохицуулалтыг нийтэд мэдээлэх, танилцуулах;

№	Хуулийн нэр	Зөвлөмж
6	Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хууль	Үзэл баримтлал болон хуулийн төслөөр тавьсан зорилгодоо хүрэх боломжтой, хуулийн төсөл боловсруулах шаардлагад нийцсэн байна.
7	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль	Хуулийн төслийн үр нөлөөг үнэлж “тэтгэврийн хэмжээг тооцохдоо өнөөдрийн хүрсэн түвшингээс бууруулахгүй байх” зөвлөмжийг хууль санаачлагчид өгч байна.
8	Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль	Хуулийн төслийн үр нөлөөг үнэлж дараах зөвлөмжийг хууль санаачлагчид өгч байна: Хуулийн нэр томьёоны тодорхойлолтод нэмэлт оруулах асуудлыг судлах;
Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль		
9	Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль	Оёмол бүтээгдэхүүний түүхий эд, үндсэн болон туслах материалыг гаалийн татвараас чөлөөлөх барааны жагсаалтыг ЗГ батлахад мэргэжлийн холбоод, салбарын компаниуд, хувиараа хөдөлмөр эрхлэгчдээс санал авч, барааны жагсаалт, нэр төрлийг ойлгомжтой, тодорхой заах нь зүйтэй гэсэн зөвлөмж гаргаж байна.
10	Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль	Хуулийн төсөл батлагдсаны дараа Монгол Улсын ЗГ-аас мөнгөн урамшууллыг олгох нөхцөл, журмын төслийг боловсруулан батлуулах шаардлагатай байна.

Хавсралт 11. Үр нөлөөний үнэлгээний хүрээнд дагалдах хуультай холбоотой зөвлөмж өгсөн жишээ

Хуулийн төслийн нэр	Зөвлөмжийн агуулга
Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль	Практикт хэрэгжих боломж шалгуур үзүүлэлтийн хүрээнд Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслөөр тус хуулийн 58 дугаар зүйлийн 58.3 дахь хэсэгт “Замын хөдөлгөөний түгжрэлийн төлбөртэй бүсийн төлбөрийн орлогыг нийтийн тээврийг хөгжүүлэхэд зарцуулна” гэсэн нэмэлт оруулж байгаа бөгөөд тус 58 дугаар зүйл нь Орон нутгийн чиг үүргийг санхүүжүүлэх буюу орон нутгийн төсвийн суурь зарлагыг санхүүжүүлэхэд чиглэсэн зохицуулалт байгаа тул төсөв батлахтай холбоотой, төсвийн зарлагатай холбоотой нэмэлт оруулж байгааг дахин нягтлах, тухайлбал, Төсвийн тухай хуулийн 18.4-т “Орон нутгийн тусгай санг байгуулах, түүний үйл ажиллагааны зарчим, хэрэгжүүлэх чиг үүрэг, уг сангийн орлого, түүний зарцуулалтын талаарх харилцааг энэ хуулиар зохицуулна.” гэж заасны дагуу орон нутгийн тусгай сангийн хөрөнгийн зарцуулалтыг тусгайлан зохицуулсан нийтлэг зохицуулалт байхгүй, харин тус хуулийн 59, 60 дугаар зүйлд орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан, орон нутгийн хөгжлийн сангийн зохицуулалтыг зөвхөн тусгасан байх тул орон нутаг дээрхээс өөр тусгай сан байгуулж болох эсэх, эх үүсвэр, сангийн удирдлага, орлого, зарцуулалтын талаарх харилцааг хэрхэн шийдвэрлэх талаар нарийвчлан судалж, хуулийн тохирох хэсэгт нэмэлт, өөрчлөлт хийх нь зүйтэй гэж үзэж байна. Ойлгомжтой байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд: 5. Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2/14.6 дугаар зүйлийн 15 дахь заалтад оруулж буй “Хуулиар хориглосон хүрдтэй тээврийн хэрэгслээр замын хөдөлгөөнд оролцсон бол зөрчлийг арилгуулж, хууль зөрчиж олсон хөрөнгө орлогыг хураан, хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэх нэмэлтийн хэрэгжих хугацааг Автотээврийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 4 дэх хэсэгт заасан “Баруун гар талдаа жолооны хүрдтэй суудлын авто машиныг ... 2030 оноос нийслэл хотод замын хөдөлгөөнд оролцуулахыг хориглох” зохицуулалтын хугацаа буюу 2030 оноос эхлэн хүчин төгөлдөр үйлчлэхээр зааж өгөх. 3. 6. Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг дагаж мөрдөх хугацааг бусад хуулийн төслийн нэгэн адил “Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийн нөлөөллийг бууруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө” гэж засах
Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хууль	Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төсөл нь анхдагч хуулийн хувьд хуульд заасан арга хэмжээг хэрэгжүүлэх холбогдох дүрэм, журмыг шинээр боловсруулж батлуулах, бүх шатны Засаг дарга, иргэд, олон нийтийн оролцоотойгоор хэрэгжүүлэх тул удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээг тусгасан “Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулах;

Хуулийн төслийн нэр	Зөвлөмжийн агуулга
Шүүх байгуулах байгуулах тухай хууль	Хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан Өмгөөллийн тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл нь Шүүх байгуулах тухай хуулийн төсөлтэй хамааралгүй байх тул хасах
Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль	хууль зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагатай холбоотойгоор Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулах
Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль	Практикт хэрэгжих боломж гэсэн шалгуур үзүүлэлтээр: Хуулийн төслийн хүрээнд төрөөс үзүүлэх бүртгэл, мэдээллийн санг үүсгэх, улмаар дэмжлэгийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хуулийн өөрчлөлтийг дагалдах бусад хуулийн төсөлд тусгах замаар шийдвэрлэх шаардлагатай гэж үзлээ.
Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль	Холбогдох хуульд заасны дагуу хууль зөрчигчид хариуцлага хүлээлгэхээр заасан байх боловч Зөрчлийн тухай хуульд зөрчлийг тусгах талаар дагах хуулийн төсөл боловсруулаагүй байгааг анхаарах;
Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хууль	хуулийн төслийн 10.3 дахь зохицуулалт нь шууд хэрэгжих боломжгүй байх тул Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд хотод өмчийн эрх шилжүүлэх заалтыг тусгах;
Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль	Нийтийн мэдээллийн тухай хууль зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагатай холбоотойгоор Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулах.
Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хууль	Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд мэдээлэл авах эрх, мэдээлэл хүсэгчийн эрх, үүргийг заасан бөгөөд хувь хүний нууцыг хамгаалах зохицуулалтыг тусгасан байна. Харин хуулийн төсөл батлагдсан тохиолдолд хувь хүний нууц, хувь хүний мэдээллийн давхцал нь мөн дээр дурдсан хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэхэд зөрчилдөөн үүсгэхээр байх тул эдгээр зохицуулалтыг тодорхой болгох; Хуулийн төсөлд заасан хувь хүний мэдээлэлд хамаарах нэр томьёо нь Улсын бүртгэлийн ерөнхий хуульд заасан иргэний улсын бүртгэлийн төрлийн нэр томьёотой уялдаагүй байх тул хуулийн төсөл хамаараагүй нэршилд хамаарах мэдээлэл нь энэхүү хуулийн төслийн хамгаалалтад хамаарах эсэхийг тодорхой болгох; Зөрчлийн тухай хуульд Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хууль зөрчих зөрчил тусгах талаар арга хэмжээ авах; Хуулийн төсөлд хувь хүний мэдээлэл, хувь хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг заасан нь Эрүүгийн хуульд заасан “бэлгийн болон хүйсийн чиг баримжаа” гэх нэр томьёотой, мөн хуулийн төслийн “дүрс бичлэгийн систем, төхөөрөмж” гэх нэр томьёо нь Эрүүгийн хуульд заасан “дууны, дүрсний, дуу дүрсний бичлэг” гэх нэр томьёотой тус тус зөрчилдөхөөр байх тул уялдуулах;

Хуулийн төслийн нэр	Зөвлөмжийн агуулга
	Хуулийн төсөлд хувь хүний мэдээлэл хамгаалах хуулийг зөрчсөн тохиолдолд Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэхээр заасан боловч Эрүүгийн хуульд хувь хүний нууцыг хамгаалах зорилгоор гэмт хэргийг тусгасан нь хувь хүний мэдээлэл хамгаалахтай холбогдох эсэх ойлгомжгүй нөхцөлийг үүсгэж байгааг тодорхой болгох, ял завших нөхцөлийг бүрдүүлэхгүй байхад анхаарах.

Хавсралт 12. Үр нөлөөний үнэлгээний хүрээнд тус хуулийн зохицуулалтыг бусад хуульд нийцүүлсэн талаар зөвлөмж өгсөн жишээ

Хуулийн төслийн нэр	Зөвлөмжийн агуулга
Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль	Зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд: уг хуулийн төслийн 6 дугаар зүйлд заасан хүний эрхийг хангах, хамгаалах ажиллагааг Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Гэрч хохирогчийг хамгаалах тухай зэрэг хуульд нийцүүлэн тусгах Харилцан уялдаатай байх шалгуур үзүүлэлтийн хүрээнд: - Хуулийн төслийн 10 дугаар зүйл нь Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуулийн 13 дугаар зүйлд тусгасан Хүний эрхийн үндэсний комиссын чиг үүрэгтэй зарим талаар давхацсан байгааг анхаарах; - Хуулийн төслийн 8, 9 дүгээр зүйл нь Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Гэрч хохирогчийг хамгаалах тухай зэрэг хуулиудтай давхцаж байгаа зөрчлийг арилгах; - Хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т тусгагдсан “төрийн бус байгууллага” гэх нэр томъёоны тодорхойлолтыг Иргэний хуулийн 25 дугаар зүйл болон Төрийн бус байгууллагын тухай хуулийн 4 зүйлийн 1 дэх хэсэгт заасан агуулгатай нийцүүлэн томъёолох; - Хуулийн төслийн 6 дугаар зүйлийн 6.1.13 дахь заалтыг Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 18 дахь хэсэгтэй агуулгын хувьд давхардсан байдлыг харгалзан уг заалтыг хасах;
Генетик нөөцийн тухай хууль	Хуулийн төсөлд генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг ашигласнаас үүдэх үр шим гэж юу болохыг Иргэний хуулийн 88.1 болон 88.2 дугаар зүйлд заасныг гэх ойлголтыг цэглэх хэрэгтэй бөгөөд үр шимийг генетик нөөц, уламжлалт мэдлэгийн эзэмшигч хүртэхтэй холбоотой зохицуулалтыг Иргэний хуулийн 88.3-ыг эшлэл авч зохицуулалт хийх;

Хуулийн төслийн нэр	Зөвлөмжийн агуулга
Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль	Зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд: Хуулийн төсөлд заасан электрон төлбөрийн систем нь Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд заасны дагуу “цахим тодорхойлогч” болох тул тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, байршил, зорчих үеийн мэдээлэл зэрэг мэдээллийн нууцлалыг хамгаалахтай холбоотой зохицуулалтыг хуулийн төсөлд нэмэх. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал болон Засаг даргын бүрэн эрхийг зааж, 11.2.1-д “тухайн орон нутагт түншлэлээр хэрэгжүүлэх төслийн саналыг боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэх”, 11.1.2-т “тухайн орон нутагт түншлэлээр хэрэгжүүлэх төслийн саналыг Засаг даргын өргөн мэдүүлснээр хэлэлцэх” гэж Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал түншлэлийн хүрээнд хэрэгжүүлэх бүрэн эрхийг тус тус заасан тул тус хуульд нийцүүлэн хуулийн төслийн 16 дугаар зүйлд заасан Нийслэлийн Засаг даргын чиг үүрэгт төр, хувийн хэвшлийн түншлэлээр нийтийн тээврийн үйлчилгээг хэрэгжүүлэхтэй холбоотой ямар чиг үүрэг хэрэгжүүлэхийг тодорхой зааж өгөх. Практикт хэрэгжих боломж шалгуур үзүүлэлтийн хүрээнд: Хуулийн төслийн 12 дугаар зүйлд дурдсан чиг үүргүүдийг ямар байгууллага, албан тушаалтан хэрэгжүүлэх талаар тодорхой заагаагүй байгааг анхаарч, Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Монгол Улсын Нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн холбогдох зохицуулалтад нийцүүлэн чиг үүрэг тус бүрийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой заах. Хуулийн төслийн 16 дугаар зүйлийн 16.1.2-16.1.5 дахь заалтуудад заасан бүрэн эрхийг Нийслэлийн Засаг дарга дангаар хэрэгжүүлэх бус эхний ээлжид заавал Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэхээр байгаа нь Монгол Улсын Нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд нийцэхгүй байх тул нийцүүлж, өөрчлөх.
Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль	Хуулийн төсөлд мэдээллийн технологийн бүтээгдэхүүний оюуны өмч, зохиогчийн эрхийг хамгаалах нь цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын үүрэг байхаар заасныг Оюуны өмчийн тухай хуулийн 12.2.2-т “Оюуны өмчийн байгууллага нь зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрх эзэмшигчийн эрх ашгийг хамгаалах” гэж заасантай нийцүүлж, зохицуулалтын зөрчил үүсгэхгүй байхаар тусгах;
Малчны тухай хууль	Малчны тухай хуулийн төсөлд туссан бэлчээрийн газар, отрын бүс нутгийн ашиглалттай холбоотой зарим зохицуулалтыг Газрын тухай хуультай уялдуулахад илүү анхаарах нь зүйтэй.
Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хууль	Хуулийн төслийн 8.1 дэх хэсгийг Газрын тухай хуулийн 12.110, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 35.211 болон Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн 5.2-т заасантай нийцүүлэн “Хотын эдэлбэр газар нь дараах бүсчлэлтэй байна:” гэж томъёолох;

Хуулийн төслийн нэр	Зөвлөмжийн агуулга
Хөдөлмөрийн тухай хууль	1. Хуулийн төслийн 3.1.1-д “ажил хайгч” гэж тусгасан нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулиар тодорхойлогдсон өөр ойлголт байх тул нэр томъёог оновчтой болгох 2. Хуулийн төслийн 3.4-т “Хөдөлмөрийн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн хүчин чадал нь дараах эрэмбээр тодорхойлогдож үйлчилнэ” гэж заасан нь бусад хэрэгт хууль тогтоомж гэдгээр ХТХ, Хөдөлмөр эрхлэлтийн харилцааг зохицуулж байгаа бусад хууль, Хуулиар эрх олгосон субъектээс зохих журмаар баталсан хуульчилсан актыг илэрхийлснээс өөр ойлголтыг илэрхийлсэн байх тул нэр томъёог агуулгын хувьд оновчтой болгох шаардлагатай байгааг анхаарах 3. Хуулийн төслийн 7.6-д “Хүний дархлал хомсдолын вирусийн халдвар авсан буюу дархлалын олдмол хомсдолтой нь тогтоогдсон ажилтны биеийн эрүүл мэндийн байдал хөдөлмөр эрхлэхэд саад болохооргүй буюу хөдөлмөрийн нөхцөл харшлахгүй бол түүнийг уг шалтгаанаар ажилд авахаас татгалзах, эсхүл хөдөлмөр эрхлэлтийн харилцааг ажил олгогчийн санаачилгаар дуусгавар болгох, ажилтны талаарх мэдээллийг задруулахыг хориглоно” гэж заасан нь ХДХВДОХСТХ-ийн 10.1.4 дэх заалттай давхардаж байгаа тул хасах шаардлагатай байна. 4. Хуулийн төслийн 23.3-д “Ажил олгогч ажлын байр, түүний орчинд дарамт үүсэхээс урьдчилан сэргийлэх, түүнийг гаргуулахгүй байх нөхцөлийг бүрдүүлэхийн тулд хөдөлмөрийн дотоод журамдаа ажлын байранд дарамт, бэлгийн дарамт бий болохоос урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, энэ талаар гарсан гомдлыг хэрхэн шийдвэрлэх асуудлыг тусгах; дарамт, бэлгийн дарамтаас ангид хөдөлмөр эрхлэлтийн харилцаа, ажлын байрны орчин бүрдүүлэхэд чиглэсэн сургалтын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх, үр дүнг ажилтнуудад мэдээлэх арга хэмжээ авч ажиллана” гэж заасан нь ЖЭТБХ-ийн 11.4 дэх хэсэгтэй давхцаж байгаа тул хасах шаардлагатай байна.
Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль	Хуулийн төслийн үнэт цаас гаргах, концесс олгохтой холбоотой асуудал болон Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 281 -д заасныг уялдуулан томъёолох;
Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хууль	Иргэний хуульд “нас барсан этгээдийн хувийн нууцтай холбоотой мэдээллийг хууль ёсны өвлөгчийн зөвшөөрлөөр” авахаар заасан зохицуулалтад хуулийн төслийн “хүнийг нас барснаас хойш 70 жил өнгөрсөн тохиолдолд хувь хүний мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглахад зөвшөөрөл шаардахгүй байх” зохицуулалтыг уялдуулах; Хуулийн төсөлд заасан “хувь хүний мэдээлэл”, “хувь хүний эмзэг мэдээлэл” бүхэлдээ хувь хүний нууцад хамаарах эсэх, уялдаа холбоог тодорхой ойлгомжтой болгох;

Хуулийн төслийн нэр	Зөвлөмжийн агуулга
	Хуулийн төсөлд хувь хүний мэдээлэл хамгаалах эрх бүхий байгууллага нь Хүний эрхийн үндэсний комисс байхаар зааж, тухайн байгууллагын нэрийг товчлон хэрэглэхдээ “хамгаалах байгууллага” гэж товчлохоор заасныг Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд “комисс” гэж товчлол хэрэглэсэнтэй уялдуулах боломжтой эсэхийг судлах;
Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль	хуулийн төслийн мэдээллийн сантай холбоотой зохицуулалтуудын агуулгаас харахад мэдээллийн санд орж буй мэдээлэлд Байгууллагын болон хувийн нууцад хамаарах мэдээллүүд орохоор тусгагдсан байна. Тиймээс мэдээллийн сангийн нууцлалтай холбоотой зохицуулалтыг Цахим мэдээллийн сангийн мэдээллээс олон нийтэд хаалттай байвал зохих мэдээллийн төрлийг хувь хүний болон байгууллагын нууцын тухай хуультай уялдуулан нэмж тусгах шаардлагатай.

Хавсралт 13. Үр нөлөөний үнэлгээний хүрээнд олон нийтийн хэлэлцүүлэгтэй холбоотой асуудлаар дүгнэлт, зөвлөмж өгсөн жишээ

№	Хуулийн төслийн нэр	Зөвлөмжийн агуулга
1.	Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль	Хүлээн зөвшөөрөгдөх боломж шалгуур үзүүлэлтийн хүрээнд: Тандан судалгаанаас үзвэл иргэд, олон нийтийн хувьд замын хөдөлгөөний түгжрэлтэй төлбөртэй бүс, тус бүсэд нэвтэрснээр төлбөр төлөх тухай санал өгөөгүй, санаачилга гаргаагүй байгааг харж болно. Иргэдийн зүгээс ихэнх нь зам, дэд бүтэц зэргийг дурдаж тандан судалгаагаар санал өгсөн байгааг анхаарч түгжрэлийн зэрэглэл тогтоох, бүсэд хуваах зэрэг харилцааг хуульчилсан тохиолдолд иргэд, олон нийтэд гарах үр дагаврыг сайтар ойлгуулж, таниулах арга хэмжээ авах. Учир нь тандан судалгаагаар гарсан үр дүн, иргэдийн санал, хүсэлтээс давсан арга хэмжээг хуулийн төсөлд авч хэрэгжүүлэхээр тусгасан байна.
2.	Хөдөлмөрийн хууль	Санал авах, хэлэлцүүлэг явуулах явцад ирүүлсэн санал, хэлэлцүүлэгт оролцсон этгээдүүдээс хуулийн төслийг ойлгомжтой болгох талаар гарсан саналыг бусад хуулийн зүйл заалттай уялдуулан тусгах талаар хамгийн боломжтой зохицуулалтыг томъёолох.